



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

ОНОЛ, АРГА ЗҮЙН СЭТГҮҮЛ

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”
[13 дахь жилдээ]

2014/02

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс

ХҮНИЙ ЭРХ

Онол, арга зүйн сэтгүүл

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар,
цаг ямагт, хүн бүрт”

(13 дахь жилдээ)

2014/02

ХҮНИЙ ЭРХ сэтгүүл
2014/02(44)
Улсын бүртгэлийн дугаар 244
13 дахь жилдээ

П.Оюунчимэг Ерөнхий редактор /Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын гишүүн/
Ц.Адъяахишиг Хариуцлагатай нарийн бичгийн дарга /Монгол Улсын Хүний
эрхийн Үндэсний Комиссын ахлах референт/

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээл нь Хүний эрхийн
Үндэсний Комиссын бодлогыг илэрхийлэхгүй, зөвхөн
зохиогчийн үзэл бодол болно.

АГУУЛГА

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ*Ж.Бямбадорж (PhD), профессор*

Монгол Улс дахь Хүүхдийн эрхийн төлөв байдал 5

Г.Агар-Эрдэнэ (Докторант)

Ахмад настны эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангах нь 13

Б.Болорсайхан (Докторант)

Хүний эрхийн үндэсний байгууллагыг үнэлэх нь 20

С.Ганцэцэг

Төрийн жинхэнэ албан хаагчийн алба хаших харилцааны эрх зүйн зохицуулалт дахь зарим зөрчил, хийдэл 29

З.Өнөржаргал

Хүний эрх ба нийгмийн халамжийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал 37

Д.Тунгалаг

Хүний эрхийн боловсролыг насан туршийн боловсролын хүрээнд авч үзэх нь 45

СУДАЛГАА*Л.Бадамцэцэг*

Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байран дахь Хүүхэд хамгааллын өнөөгийн нөхцөл байдал /судалгааны тойм тайлан/ 52

МОНГОЛ ХЭЛЭЭР МАНАЙ ХУУДАСНААХүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх: Ерөнхий зөвлөмж №12 66
*орчуулсан Ч.Алтангэрэл***ЗОЧНЫ ЯРИА**

“Хүний эрх” сэтгүүлийн энэ удаагийн зочноор Каритас Чех олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, ноён Тибо Шапуа уригдлаа 89

ХАВСРАЛТАзийн хүүхдийн эрхийн гуравдугаар чуулга уулзалтаас гарсан тунхаглал 94
Declaration of the third Asian forum on the rights of the child

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ

МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ТӨЛӨВ БАЙДАЛ

Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын дарга,
Хууль зүйн ухааны доктор, профессор

Ж.БЯМБАДОРЖ

Аливаа улс орны тогтвортой хөгжлийн үндсэн баталгааны нэг нь хүүхэд таатай өсч хөгжих, өөрийгөө илэрхийлэх орчин байдаг билээ. Хүүхэд нь өөрийн эрхээ бие даан хамгаалах чадваргүй, онцгой халамж, хамгаалалт түүний дотор эрх зүйн онцлог хамгаалалт шаарддаг субъект болохын хувьд төрийн зүгээс хүүхдийн эрхийн асуудлыг тусгайлан авч үзэх, ялангуяа ямар нэгэн байдлаар хүүхдийн эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулах шаардлагатай байдаг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 2002 онд хуралдсан Хүүхдийн асуудлаарх Тусгай чуулганаар дэлхийн улс орнууд XXI зуунд Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнцийг бүтээн байгуулах зорилгыг өмнөө тавьж, хүүхдийн төлөө дэлхий ертөнцийг өөрчлөх үүрэг амлалтыг авсан билээ.

Монгол орны хувьд хүүхдээ өсгөн бойжуулах, хүмүүжүүлэх, нийгэмшүүлэх зан заншил болон эрх зүйн уламжлал, хандлага нь нилээд өвөрмөц онцлогтой. Энэ нь орчин үед сайн муу аль ч талаараа

нийгмийн амьдралд илэрч байгаа болохоор төрийн болон нийгмийн зүгээс тусгайлсан арга хэмжээг цаг алдалгүй авч, үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байгаа болно. Төрөөс хүүхдийн асуудлаар, тэр дундаа хүүхдийн эрхийг хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр олон чухал арга хэмжээ авч байгаа хэдий ч, нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, ажилгүйдэл, ядуурал зэрэг үзэгдэлтэй холбоотойгоор хүүхдийн эрхийн зөрчил буурахгүй харин ч нэмэгдэх хандлагатай байна.

Монгол Улсад хүүхдийн эрхийг хамгаалах олон улсын болон үндэсний эрх зүйн систем, үндэсний механизм бүрэлдэн тогтсон гэж үзэж болно. Манай улс НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсноос хойш 24 жил, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг батлан, хэрэгжүүлж эхэлснээс хойш 18 жил болж байна. Одоогийн байдлаар Монгол Улс хүний эрхтэй холбоотой 50 орчим олон улсын гэрээ, конвенцийг соёрхон баталж, нэгдэн ороод байна. Хамгийн сүүлд 2013 оны 10-р

сард “Хүүхдийн эрхийн тухай конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай 3 дугаар нэмэлт протокол”-д гарын үсэг зурсан бөгөөд соёрхон батлуулах шатандаа байна.

УИХ-ын Хүний эрхийн дэд хороо, Хүний эрхийн Үндэсний Комисс, Хүүхдийн төлөө зөвлөл, Хүүхдийн төлөө Үндэсний Газар, аймаг, нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн хэлтэс, сургуулиуд дээр багш, нийгмийн ажилтан, бүх шатны Засаг дарга нар, дүүрэг хороод, сум багийн түвшинд хөгжлийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан зэргээс гадна сүлжээ, эвслийн зохион байгуулалтад орсон иргэний нийгмийн хэдэн арван байгууллагууд гээд үндэсний механизм бүрэлдэн бий болсон учраас харилцан уялдаатай, хамтын ажиллагаагаа зөв зохицуулан ажиллаж чадвал амжилт олох боломж их гэдгийг хэлмээр байна.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих чиг үүргийнхээ хүрээнд хүүхдийн эрхийн асуудалд онцгой анхаарлаа хандуулж, хамгийн чухал зорилтот бүлэг хэмээн тодорхойлон ажилладаг юм. Тийм ч учраас дээрх олон улсын гэрээ, конвенцуудын заалтуудыг Засгийн газар хэрхэн хэрэгжүүлж, үүргээ хэрхэн биелүүлж, тайлагнаж байгаад нэн тэргүүний ээлжинд анхаарч, зарим Конвенцийн хэрэгжилтийн талаар тусгайлсан хяналт шалгалт, судалгаа хийж, тодорхой санал зөвлөмж гарган, хэрэгжилтийг нь ханган ажиллаж байна.

Хүний эрхийн Үндэсний Комисс Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний төлөө байдлын талаарх жил бүрийн илтгэлдээ

хүүхдийн эрхийн асуудлыг хөндөн тавьж, асуудлыг ээлж дараатай шийдвэрлүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж байдаг юм

Хүний эрхийн Үндэсний Комиссын үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг бол хүний эрхийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажил болно. Комиссын хувьд 2004, 2006, 2013 онд хүүхэд, залууст зориулсан зуны сургалтыг зохион байгуулж, оролцооны аргад тулгуурласан хүний эрхийн боловсролын үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийг өөрчлөх, хүний эрхийн соёлыг бий болгохыг зорьж ажиллаж байна. Сургалтын үр нөлөөг нэмэгдүүлэх, хүний эрхийн боловсролыг хүргэх арга хэрэгслийг сайжруулах зорилгоор 2013 онд цахим сургалтын талбарыг туршиж, 2014 оноос орон нутгийн ажилтнууд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг хамруулахаар төлөвлөж байна.

Үүнтэй уялдан хүүхэд, залууст хүний эрхийн ойлголтыг хялбаршуулан хүргэх, хүний эрхийн мэдлэгийг үе тэнгийнхэндээ хүргэх байдлыг дэмжихээр “Хүний эрхийн төлөөх залуучууд” олон улсын санаачлагыг дэмжин, эхлээд нийгмийн ухааны чиглэлээр 6 дээд сургуульд оюутнуудын клуб байгуулж, ерөнхий боловсролын 20 сургуулийн суралцагчдад Хүний эрхийн сургалтын хөтөлбөрийг оруулахаар ажиллаж байна.

Манай оронд гардаг хүүхдийн эрхийн зөрчлөөс нийгмийн анхаарал татаж байгаа зарим зөрчил, түүнийг багасгах, арилгах арга замын талаар та бүхэнтэй санал бодлоо хуваацахыг хүсэж байна.

1. Монголчуудын хүүхдээ зодож хүмүүжүүлдэг бараг “уламжлалт” гэж хэлж болох арга өнөөгийн нийгэмд үеэ өнгөрөөсөн

гэдгийг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч, зодуурыг жигших уур амьсгалыг гэр бүлийн харилцаанд суулгаж өгөхөд чиглэгдсэн олон талт арга хэмжээ авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Олон хүүхэд эцэг, эх, ах, эгч нартаа их бага хэмжээгээр зодуулж, зарим нь амь нас, эрүүл мэндээрээ хохирч байгаа нь нэгэнт ил болсон зүйлээ. “Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль”, “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хууль” зэрэг хууль тогтоомжийн заалтууд хүүхдийг хүчирхийллээс бүрэн хамгаалж чадахгүй байгаа учраас хүүхдийн эрхийг хамгаалах хууль тогтоомжийг шинэчлэх, боловсронгуй болгох, түүнчлэн шинээр батлагдах гэмт хэргийн болон зөчлийн тухай хуулиудад тодорхой заалт оруулах замаар гэр бүл, цэцэрлэг, сургуулийн орчноос хүүхэд зоддог үзэгдлийг бүрмөсөн арилгах шаардлагатай байна. Энэ үйлсэд иргэний нийгмийн байгууллагын хүч бололцоог үр дүнтэй ашиглавал амжилт олно гэдэгт огтхон ч эргэлзэхгүй байна.

2. Бид бэлчээрийн мал аж ахуй эрхэлж ирсэн болохоор хүүхэд бага наснаасаа гэр бүлийнхээ ажилд их бага хэмжээгээр тусалдаг уламжлалтай ард түмэн билээ. Энэ нь монголчуудыг хүүхэд багаасаа ажил хийж өсөх ёстой гэсэн үзэл баримтлалтай болгосны дээр Монгол Улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих явцад ажилгүйдэл, ядуурал нэмэгдэж, үүнтэй холбоотойгоор хараа хяналтгүй хүүхэд олширч, хүүхэд хөдөлмөр эрхлэх, ялангуяа тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх, сургууль завсардах зэрэг олон сөрөг үр дагавар бий болсон юм.

Хүүхэд хөдөлмөр эрхлэх нь байнга сөрөг үр дагавар дагуулдаггүй, зарим төрлийн хөдөлмөр хүүхдийн хөгжил, оролцоонд зэрэг нөлөөтэй болохыг

Комисс үгүйсгэдэггүй. Гэвч мөлжлөгийн чанартай, олон цагаар үргэлжилсэн, хүнд нөхцөлтэй, хүүхдийн бие махбод, сэтгэл санаанд муугаар нөлөөлж, эрүүл мэндэд харшилсан, боловсрол эзэмшихэд нь саад болж байгаа хөдөлмөрийг устгах нь хүний эрхийн зарчимд нийцнэ гэж үздэг. Тийм ч учраас Хүний эрхийн Үндэсний Комисс 2008 оны Хүний эрхийн төлөв байдлын талаарх илтгэлдээ хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн талаар судалгаа явуулж, цуглуулсан баримт мэдээлэлдээ тулгуурлан Засгийн газарт **“Улсын хэмжээнд хүүхдийн хөдөлмөрийн асуудлаар нэгдсэн судалгаа явуулж, хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэхэд нөлөөлж буй шалтгаан нөхцөлийг тогтоож, түүнийг арилгах арга хэмжээ авах, тухайн орон нутаг дахь хүүхдийн хөдөлмөрийн асуудлыг судлан үзэж, хүүхдийг тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс ангижруулах орон нутгийн засаг захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг дээшлүүлэх; Хүүхдүүд нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй ядуу, нэн ядуу өрхийн насанд хүрсэн гишүүдийг ажлын байраар хангах, төсөл хөтөлбөрт хамруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлж, хүүхдүүдийг нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөрөөс хөндийрүүлэх арга хэмжээ авах; Уулзурхайн албан болон албан бус салбарт алт, жонш, нүүрс олборлох, хог цуглуулах ажилд хүүхэд хөдөлмөрлөх явдлыг нэн даруй хориглож, тэнд ажиллаж буй хүүхдүүдийг тухайн хөдөлмөрөөс хөндийрүүлэх, сургуульд хамруулах арга хэмжээ авч, хүүхдээрээ ийм төрлийн хөдөлмөр эрхлүүлсэн эцэг, эхэд нөлөөлж, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох** зэрэг хэд хэдэн санал зөвлөмж өгч, ажил хэрэг болгуулж байсан билээ.

2008 онд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын баталсан Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад уурхайн бүх төрлийн ажил, газрын доорх бүх төрлийн ажил, газрын тос олборлолт, давс олборлолт, тэсэлгээчин, ил ба далд уурхайн ажилчин, чулуучин, өрөмдөгч болон хогийн цэгт ажиллах, хог хаягдал цуглуулах, ариутгах, ялгах, боловсруулах, цэвэрлэх, устгах ажлыг хамруулжээ.

2002-2010 онд “Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгах үндэсний хугацаат хөтөлбөр (АЙПЕК)-ийг дэмжих төсөл”-ийн санхүүжилтээр хэд хэдэн судалгаа явуулж, шинжилгээ хийж Монгол Улс дахь хүүхдийн хөдөлмөрийн нөхцөл байдлыг тодорхойлсон байна. Эдгээр мэдээлэлд тулгуурлан Хүүхдийн төлөө Үндэсний Газар хүүхдийн аж байдлын мэдээллийн нэгдсэн санд үзүүлэлт бий болгож, мэдээллийг нэгтгэж байгаа нь чухал юм. Цаашид мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлт зохицуулалтыг илүү боловсронгуй болгож, статистик мэдээлэлд үндэслэн төрийн бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх нь хэрэгтэй байна.

Хүүхэд тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхлэх явдлыг бууруулах, улмаар таслан зогсоох үр дүнтэй аргын нэг бол ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааг нэмэгдүүлэх явдал юм. Хүүхдүүд нь тэвчишгүй хэлбэрийн хөдөлмөр эрхэлж буй ядуу, нэн ядуу өрхийн насанд хүрсэн гишүүдийг ажлын байраар хангах, төсөл хөтөлбөрт хамруулах замаар өрхийн орлогыг нэмэгдүүлэх талаар АЙПЕК төслийн хүрээнд зарим ажлыг хийжээ.

Засгийн газраас 2012-2016 онд хэрэгжүүлэх “Хүүхдийн хөдөлмөрийн

тэвчишгүй хэлбэрүүдийг устгах” Үндэсний хөтөлбөрийг баталсан билээ. Гэвч хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр нь далд болон шинэ агуулга хэлбэрт шилжиж байгаад яаралтай тандалт судалгаа хийж, олон хүүхдийг эрсдэлд оруулах үр дагавартайг тооцон, бодлогын шинжилгээг хийж, зохих арга хэмжээ авах шаардлагатай байна.

3. Монгол орны уламжлалт онцлогоос үүдэлтэйгээр хурдан морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах асуудал хурцаар тавигддаг боллоо. Хурдан морины уралдааныг ЮНЕСКО-гоос 2011 онд Соёлын биет бус өвийн жагсаалтад багтаасан бөгөөд үеэс үед уламжлагдаж ирсэн монголын ард түмэн нүүдлийн соёлын салшгүй нэг хэсэг билээ. Хурдан морины уралдаан зөвхөн үндэсний их баяр наадмаар хязгаарлагдахгүй, бүх түвшинд зохиогдох болсноор хурдан морь унаач хүүхдийн амь нас, эрүүл мэнд хохирох эрсдлийг нэмэгдүүлж байна. Тойм байдлаар үзэхэд жилдээ тэмдэглэлт ойгоос хамааран 60-90 баяр наадам болж байна. Сүүлийн жилүүдэд хурдны мориноос унаснаар 15 хүүхдийн амь эрсдэж, 210 хүүхэд хүндэвтэр гэмтэл авч, хөгжлийн бэрхшээлтэй болсон тухай мэдээлэл байна.

Комиссын зүгээс хурдан морь унаач хүүхдийн эрхийн талаар, ялангуяа хуулиар тогтоосоннаснаас баганасныхүүхдээр хурдан морь унуулсан, даатгалд хамруулаагүй, хамгаалалтын хувцас хэрэгсэл өмсүүлээгүй бол буруутай этгээдэд захиргааны журмаар торгууль ногдуулдаг, дээрх шаардлагыг хангаагүйн улмаас хүүхдийн биед гэмтэл учруулсан, амь нас нь хохирсон бол гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт бий болгох, тэдний хөдөлмөрийг хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцуулах, хурдан морь

унаач хүүхдийн насны хязгаарыг 9 наснаас дээш байхаар тогтоох талаар 2003, 2008, 2010, 2013 оны илтгэлүүдээрээ дамжуулан Улсын Их Хуралд илтгэсэн болно.

Гэвч хурдан морь унаач хүүхдийн насны хязгаарыг 9 наснаас дээш байх талаарх Комиссын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй бөгөөд Үндэсний их баяр наадмын тухай хуульд “Баяр наадмын хурдан мориог 7-оос дээш насны хүүхэд унах бөгөөд ослын даатгалд даатгуулсан байна” гэж заасан хэвээр байгаа ба харин тэдний аюулгүй байдлын талаар уг хуульд нийцүүлж гаргасан “Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдааны дүрэм”-д унаач хүүхдийг ослын даатгалд хамруулсан байдал, тусгай зориулалтын хамгаалалтын хувцас хэрэглэл заавал хэрэглэх зэрэг хэд хэдэн чухал заалт орсон юм. Харамсалтай нь өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, стандартын хэрэгжилт хангалтгүйгээс шалтгаалж, хурдан морь унаач хүүхэд эндэх, бэртэх явдал гарсаар байгаад Комисс санаа зовж 2013 оны илтгэлдээ морь унаач хүүхдийн эрхийг хамгаалах шаардлагатай байгааг дахин сануулж, Монгол Улсын Ерөнхий сайдад зөвлөмж хүргүүлсэн юм. 2014 оны эхэнд хүйтний улиралд хурдан морины уралдаан явуулах зөвшөөрөл олгохгүй байхыг хүсэж Засгийн газарт зөвлөмж хүргүүлж, гаргасан шийдвэрийг цуцлуулсандаа бид туйлын баяртай байгаа. Гэвч нутаг дэвсгэртээ хурдан морины уралдаан хийлгэхгүй байх талаар хяналт тавьж ажиллахыг бүх шатны засаг дарга нараас шаардсан боловч маш олон уралдаан 2, 3, 4 дүгээр саруудад болж, нэг ч засаг дарга, буруутанд хариуцлага тооцоогүйд Хүний эрхийн Үндэсний Комисс харамсаж байна. Хэдийгээр хурдан морины уралдаан Монголын уламжлалт соёлын нэг боловч

хүүхдийн эрүүл мэнд, амь насаар баясаж цэнгэх эрх хэнд ч байхгүй гэдгийг анхаарвал зохино.

4. Комисс хараа хяналтгүй, эцэг эхгүй болон гэмт хэрэгт холбогдсон, хорих ял эдэлж байгаа хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр онцгойлон анхаарч, хяналт шалгалт, судалгааны ажил тогтмол хийдэг. Гэмт хэрэгт холбогдсон хүүхдийн асуудлыг хүүхдийн эрхийн тухай конвенцийн тусгайлан авч үзэх, насанд хүрэгчдээс тусад нь байлгах, аль болох нийгмээс тусгаарлахгүйгээр засан хүмүүжүүлэх ёстой гэсэн байр суурийг хатуу баримталж сургалт, сурталчилгааны ажил зохиодог юм. Үүний үр дүнд насанд хүрээгүй хүний хэргийг мөрдөн шалгах, ял шийтгэл оноох, таслан шийдвэрлэх талаар хэд хэдэн хөнгөлөлт өөрчлөлтийг хууль тогтоомжид тусгуулсан билээ. Монгол Улсын хэмжээнд насанд хүрээгүй хүмүүст оноосон хорих ялыг тусгайлан эдлүүлдэг ганц хорих ангитай бөгөөд Комиссын гишүүд, ажилтнууд тэнд тогтмол хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгч, ял эдэлж буй хүүхдүүдтэй уулзаж, зөвлөгөө өгч ажилладаг.

Нийслэл Улаанбаатар хотод хараа хяналтгүй хүүхдийг байрлуулж үйлчилгээ үзүүлдэг, төрийн болон хувийн өмчийн 40 орчим хүүхдийн асрамжийн газар үйл ажиллагаа явуулж, 1500 орчим хүүхэд хүмүүжиж байна. Эдгээр асрамж халамжийн газарт хяналт шалгалт хийж, асрамж халамжийн газарт тавигдах шалгуур үзүүлэлтийг холбогдох байгууллагаар тогтоолгон мөрдүүлж байна. Үүнтэй холбоотойгоор улсын хэмжээнд хараа хяналтгүй, эцэг эхгүй, тэнэмэл хүүхдийн нэгдсэн бүртгэлийг бий болгож, хөдөлгөөнд нь хяналт тавих, бичиг баримтжуулах, ялангуяа хүүхдийн асрамжийн газраас

хүүхэд үрчлүүлэх асуудалд анхаарч ажиллах шаардлагатай байгааг орон нутгийн засаг захиргааны байгууллагад зөвлөмж болгон ажиллалаа.

2013 онд Комисс хорих ял эдэлж буй нийт эмэгтэйчүүдийн шийтгэх тогтоолд асран хамгаалагчгүй үлдэж буй хүүхдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа шүүхийн практикт судалгаа хийсэн юм. Судалгааны дүнд шүүхээс гэмт хэрэг үйлдсэн эмэгтэйчүүдэд хорих ял оногдуулахдаа хүүхдийн асран хамгаалагчийг тогтоолгүй орхигдуулж буй нийтлэг нөхцөл байдал илэрсэн юм. Маш цөөн тохиолдолд асран хамгаалах асуудлыг шийдвэрлэх үүргийг Захиргааны байгууллагад үүрэг болгож, асрамжийн асуудлыг шийдүүлсэн байна. Үүний улмаас зарим хүүхэд ялангуяа бага насны хүүхэд, мөн эхнэр нь нөхрөө хөнөөсөн гэмт хэрэгт шийтгүүлсэн зэрэг эмзэг нөхцөл байдлын улмаас асран хамгаалагчгүй үлдэж байгаа хүүхдүүд хаана байгаа нь мэдэгдэхгүй алга болох, гэмт хэрэгт холбогдох, ялгаварлан гадуурхагдах, хэн нэгний зараал, тэвчишгүй хөдөлмөрийн золиос болох зэрэг сөрөг үр дагавар үүсч байна.

Тиймээс Хүний эрхийн Үндэсний Комисс сураггүй алга болсон хүүхдүүдийг эрж хайх ажлыг Цагдаагийн ерөнхий газартай хамтарч хийх, шинээр боловсруулж буй гэмт хэргийн процесс хуулиар шүүгчид шийтгэх тогтоолоо үйлдэхдээ хүүхдийн асуудлыг заавал тусгаж өгөхийг үүрэг болгосон заалт оруулах талаар санал өгөх, шүүхийн практикт хүүхдийн асуудлыг шийдвэрлэх хандлага төлөвшүүлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

5. Хүн худалдаалах гэмт хэрэгт хүүхэд өртөх магадлал өндөр байдаг. Хил Хамгаалах

Ерөнхий Газраас гаргасан тоон мэдээллээс үзэхэд 2007 онд 40393 хүүхэд гадагшаа зорчиж, тэднээс 1281 хүүхэд буцаж ирээгүй байна. 2006 онд 26118 хүүхэд гадагш зорчсоноос 22523 хүүхэд буцаж ирсэн, 2010 онд 55276 хүүхдээс 52620 нь буцан ирж, 2656 хүүхэд эргэж ирээгүй байна. Ийнхүү жил бүр гадагшаа зорчих хүүхдийн тоо өсөхийн хэрээр эх орондоо буцаж ирээгүй хүүхдийн тоо ч нэмэгдэж байгаа нь Комиссын санааг зовоож байна. Хүүхдэд олгож буй төрсний гэрчилгээ зураггүйгээс уг гэрчилгээ гадаадад зорчих гэж буй хүүхдийнх мөн эсэхийг тогтооход хүндрэлтэй, хавсралтаар яваа хүүхдийн талаар гадаадад зорчиж буй хүүхдийг өөр бусад хүний (асран хамгаалагч) паспортод нь хавсралт бичиж гаргах боломжтой байгаа талаар Комисс 2010 оны илтгэлдээ оруулсан юм. Энэ талаарх гомдол ч Хүний эрхийн Үндэсний Комисст ирж байсан. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг тодорхойлох, түүнд хүүхэд өртөх эрсдлийг бууруулах зорилгоор байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Комисс орж ажилласан бөгөөд нэн тэргүүнд гадаад руу зорчиж байгаа хүүхэд заавал гадаад паспорттай байх асуудлыг шийдвэрлэснээр хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлсэн томоохон алхам болсон гэж үзэж байна.

6. Хүүхдийн сурч боловсрох эрхийн тулгамдаж байгаа зарим асуудлыг хөндөхийг хүсэж байна. Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах талаар Монголчуудын ололт дэлхийд үнэлэгдсэнийг та бүхэн мэдэж байгаа.

НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 2012 онд сүм хийдэд шавилан сууж, шашны сургуульд суралцаж байгаа хүүхдүүдийн нөхцөл байдлыг судалсан юм. Эдгээр хүүхдэд сүм хийд,

дацангийн дэргэдэх шашны сургуулиар дамжуулж эсвэл албан бус боловсролын хөтөлбөрт хамруулах байдлаар ерөнхий боловсрол олгож байсан ба мөн зарим хэсэг нь ерөнхий боловсролоос завсардаж байгааг тогтоосон болно. Хэдийгээр манай улсад сүм хийдэд байнга шавилан сууж байгаа хүүхдийн тоо харьцангуй цөөн боловч энэ хүүхдүүд орчин цагийн хөгжил дэвшлээс ангид хоцорч, цаашид нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох мэдлэг, чадвар олж авч чадахгүйд хүрсэн байна.

Сүм хийдэд шавилан суугаа хүүхдийн асуудал төрийн холбогдох байгууллагын анхаарлын гадна үлдсэн хийгээд шашны байгууллага зөвхөн шашны ном заахыг урьтал болгодгоос шалтгаалан эдгээр хүүхэд орчин цагийн шаардлагад нийцсэн боловсрол эзэмшиж чадахгүйн дээр тэдний зарим эрх зөрчигдөхөд хүрчээ. Сүм хийдэд шавилан суугаад суурь боловсрол давхар эзэмших боломжгүй нь нэгэнт тодорхой байгаа учраас шашны сургалттай ерөнхий боловсролын сургуулийг үндэсний хэмжээнд бүсчлэн байгуулах шаардлагатай байгааг Комиссын зүгээс 2013 онд онцолж, УИХ-д өргөн барьсан илтгэлдээ зөвлөмж болгосны дагуу улсын хэмжээнд бүсчлэн 3 сургууль байгуулахаар Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны тогтоол гарч, хэрэгжүүлэх шатандаа явж байна.

2012 онд Хүний эрхийн Үндэсний Комиссоос нийслэлд үйл ажиллагаа явуулж байгаа ерөнхий боловсролын зургаан тусгай сургуульд хийсэн хяналт шалгалтаар эдгээр сургуулиудын барилга байгууламж хуучирсан, төрийн зүгээс иж бүрэн засвар хийх санхүүжилтийг олголгүй өдийг хүрч, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлогт тохирсон амьдрах, суралцах

хүртээмжтэй орчныг бүрдүүлж чадаагүй, мэргэжлийн боловсон хүчин хангалтгүй, нэг ангид суралцагчдын насны хэт зөрүүтэй (6-30 настай), сургалтын материал хүрэлцээгүй зэрэг дутагдал илэрсэн юм.

Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг дээрх сургуулиудыг Боловсрол шинжлэх ухааны яамны харьяаллаас гаргаж, дүүргийн харьяалалтай болгосноос санхүүжилтэд тавих улсын хэмжээний анхаарал суларч, бодлого алдагдсан ажээ. Хяналт шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авах талаар Боловсрол шинжлэх ухааны яам, Хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яам болон Эрүүл мэндийн яаманд Комиссын гишүүдийн 16 зүйл заалт бүхий шаардлагыг хүргүүлсэн ба шаардлагын мөрөөр холбогдох яамдаас тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тун бага хувь нь суралцаж байгаа ба олон зуун хүүхэд нийгмээс ангид сурах эрх нь хангагдахгүй гэртээ байгаа нь Комиссын хяналт шалгалт, ажиглалт судалгаанаас харагддаг билээ. Мөн ядуурал, амьдралын боломжгүй байдлаас шалтгаалан багагүй тооны хүүхэд сургуульд суралцаж чадахгүй байна. Ийм учраас улсын хэмжээнд нарийвчилсан судалгаа явуулж, гарсан үр дүнг үндэслэн төрийн тусгай бодлого гаргаж, эдгээр хүүхдийн сурах эрхийг хангаж нийгмийн амьдралд бэлтгэх шаардлага тулгарч байна.

7. Нийслэл Улаанбаатар болон бусад томоохон хотуудын агаарын бохирдол байх ёстой хэмжээнээсээ хэд дахин их болсон, уул уурхайн ашигт малтмалыг байгаль орчинд хортой, аюултай технологоор ашиглаж

тээвэрлэж байгаагаас бий болдог тоосжилт, нүх, хонгил, хөрсний эвдрэл нь хүүхэд багачуудын маань эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчих болоод удаж байна. Агаарын бохирдлоос үүдэлтэйгээр хүүхдийн өвчлөл жил бүр нэмэгдэж, ухсан нүх, цооногт хүүхэд унаж амь насаа алдсан тохиолдол ч гарсаар байна. Энэ талаар Хүний эрхийн Үндэсний Комисс онцгой анхаарч 2011 онд “Уул уурхайн бизнес ба хүний эрх” сэдвээр олон улсын хурал зохион байгуулж, УИХ, Засгийн газар, холбогдох

бусад газруудад хандаж энэ асуудлыг шийдвэрлэгдэхэд чиглэсэн зөвлөмж гарган зарим нь хэрэгжиж эхэлснийг хэлэх нь зүйтэй.

“Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрт” гэсэн уриатай ажиллаж байгаа Хүний эрхийн Үндэсний Комиссын зүгээс эрхээ эдэлж өссөн хүүхэд цаашид эрхийнхээ төлөө тууштай тэмцэгч, бусдын эрх, эрх чөлөөг хүндэтгэдэг, сахин хамгаалдаг иргэн болж төлөвшинө гэж үздэг.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АХМАД НАСТНЫ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, СОЁЛЫН ЭРХИЙГ ХАНГАХ НЬ



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын Бодлогын дүн шинжилгээ,
хүний эрхийн боловсролын хэлтсийн дарга,
докторант

Г.АГАР-ЭРДЭНЭ

Дэлхийн улс орнуудын соёл, шашин шүтлэг, зан заншил зэргийн ялгаатай байдлаас хамааран ахмад настныг тодорхойлох асуудал ялгаатай байдгийг харгалзан үзэж НҮБ болон олон улсын бусад байгууллагуудын зүгээс тэднийг он цагийн нас (chronological age)-аар нь тодорхойлох хандлагыг илүүтэй баримталж байна. Энэ нь бусад улсуудын хувьд ахмад настныг тодорхойлоход хэрэглэх нэг мөр аргачлал болох давуу талтай юм.

Тэгвэл НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын хороо “ахмад настан” гэх нэршлийг (францаар - *personnes agees*; испаниар - *personas mayores*) сонгосон ба Ерөнхий Ассамблейн 47/5¹, 48/98² тогтоолд энэ нэр томъёог ашигласан байна. НҮБ-ын статистик мэдээллээс үзэхэд уг нэр томъёонд 60 ба түүнээс дээш насны хүмүүсийг хамруулсан байдаг. 65 нас бол тэтгэвэрт гардаг нийтлэг нас буюу түүнээс дээш насанд тэтгэвэрт гарах хандлагатай байдаг учир “ахмад настан” гэх

нэр томъёонд 65 болон түүнээс дээш насны хүмүүсийг ойлгоно гэж Европын Холбооны статистикийн үйлчилгээний Евростат³ үзсэн байна.

Түүнчлэн Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын судалгаагаар ихэнх хөгжингүй орнууд хамгийн багадаа 65 настай хүнийг ахмад настны ангилалд хамааруулж байгаа ба энэ нь тэтгэвэр тогтоолгох насны хязгаартай холбоотой юм⁴. Үүнтэй адил НҮБ хөгжингүй орнуудад 60, хөгжиж буй орнуудад 50-55 насныг ахмад нас гэж тооцож болохыг зөвлөжээ⁵.

3 <http://epp.eurostat.ec.europa.eu/portal/page/portal/eurostat/home/>

4 European Union, Member state input to the fourth working session (2013). At <http://social.un.org/ageing-working-group/documents/fourth/EuropeanUnion.pdf> (viewed 20 March 2014), World Health Organisation (WHO), Definition of an older or elderly person, <http://www.who.int/healthinfo/survey/ageingdefnolder/en/#> (viewed 20 March 2014)

5 Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын дээрх мэдээллийг үзэх Office of the High Commissioner for Human Rights (OHCHR), Human rights of older persons: International human rights principles and standards (April 2011), p 3.

1 <http://www.un.org/documents/ga/res/47/a47r005.htm>

2 <http://www.un.org/documents/ga/res/48/a48r098.htm>

Цаашид дэлхийн хүн амын насжилт харьцангуй тогтворжих хандлагатай байна. Үндсэндээ 2050 он гэхэд дэлхийн хүн амын 20-иос илүү хувийг 60 ба түүнээс дээш настай хүмүүс эзлэх тооцоо байна⁶.

60 ба түүнээс дээш настны тоо 1950 онд 200 сая, 1982 онд 400 сая, 2001 онд 600 сая байсан бол 2025 онд 1.2 тэрбум болж өснө гэсэн судалгаа хийсэн ба энэ үед ахмад настны 70 хувь нь өнөөгийн хөгжиж буй орнуудад амьдарч байх болно гэж НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо үзсэн байна. Мөн 80 ба түүнээс дээш настай хүмүүсийн тоо 1950 онд 13 сая, 2004 онд 50 сая болж өссөн бол, цаашид ч эрчимтэй өссөөр 2025 онд 137 саяд хүрэх магадлалтай ажээ. 1950-2025 оны хооронд 60 ба түүнээс дээш насны бүлгийн хүмүүс зургаа дахин, нийт хүн ам гурав дахин өснө гэсэн тооцоотой харьцуулбал 80 ба түүнээс дээш насны бүлгийн хүмүүсийн тоо 10 дахин өснө гэж үзвэл хүн амын хамгийн хурдацтай өсөж байгаа бүлэг нь ахмад настнууд гэдгийг илтгэж буй юм.

Эдгээр тоо томоохон өөрчлөлтийг дүрслэхийн зэрэгцээ багагүй үр дагавар, урьдчилж тааварлашгүй нөхцөл байдлыг үүсгэж байгаа ба ирээдүйд улс орон, олон улсын түвшинд нийгэм, эдийн засгийн бүтцэд нөлөөлөх хандлагатай байна. Иймд олон улсад нийгмийн эмзэг, анхаарал шаардсан бүлэг болох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, цагаач иргэдээс дутахгүй ахмад настны эрхийг мөн адил онцгойлон анхаарч байна.

НҮБ-ын Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо аж үйлдвэржсэн улс орнууд нийгэм, эдийн засгийн бодлогоо, тэр дундаа

нийгмийн хамгааллын бодлогоо хүн амын насжилтад тохируулан боловсронгуй болгох шаардлагатай гэж үзсэн байна. Хөгжиж буй улс орнуудад хүн амын залуу бүлгийнхний дунд цагаачлал ихэссэн, гэр бүлийн уламжлалт үүрэг алдагдсан, ахмад настай хүмүүст үзүүлэх дэмжлэг суларсан зэргээс хамааран ахмад настнууд нийгмийн хамгаалалд тэр бүрий хамрагдаж чадахгүй байх, эсвэл тааруу хамрагдаж байгаа нь нөхцөл байдлыг улам дордуулж байна гэж НҮБ үзжээ.⁷ Тэр дундаа ахмад настан өөрийн эдэлбэл зохих эдийн засаг, нийгэм, соёлын эрхүүдээ хангалттай эдэлж чадахгүй байгаад шүүмжлэлтэй хандаж байна.

Тэгвэл энэхүү нийтлэлээр ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээрх өнөөгийн олон улсын бодлого, мөн ахмад настны эдэлбэл зохих эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн асуудлыг хөндөхийг зорилоо.

Нэг. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад хамрагдах ахмад настны эрх

Өдгөө НҮБ-аас баталсан олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, гэрээ, конвенцуудад ахмад настны эрхийг тусгайлан зохицуулсан нь үгүй юм. Харин бүс нутгийн шинжтэй олон улсын гэрээнд, тухайлбал, Хүний эрхийн тухай Америкийн конвенцийн Нэмэлт протоколийн 17 дугаар зүйл, Европын холбооны суурь эрхүүдийн тухай дүрмийн 25 дугаар зүйл, Хүний ба ард түмний эрхийн тухай Африкийн дүрмийн 18 дугаар зүйлд ахмад настны эрхийн талаар заасан байдаг. Олон улсын хөдөлмөрийн байгууллагаас энэ чиглэлээр цөөнгүй зөвлөмж гаргасныг мөн дурдаж болно.

⁶ <http://daccess-dds-ny.un.org/doc/UNDOC/GEN/N12/486/94/PDF/N1248694.pdf?OpenElement>

⁷ 2001 онд хэрэгжсэн байх насжилтын асуудлаарх дэлхийн зорилт, бодит стратеги. Ерөнхий нарийн бичгийн тайлан (A/47/339), 5-заалт.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад ахмад настны эрхийн талаар тодорхой заалт байхгүй ба түүний 9 дүгээр зүйлд “Энэхүү Пактад оролцогч улсууд нийгмийн даатгалыг оролцуулан, хүн бүрийн нийгмийн хангамжид хамрагдах эрхийг хүлээн зөвшөөрнө.” гэсэн нь ахмад настны тэтгэвэр тэтгэмж эдлэх эрхтэйг шууд бусаар баталгаажуулсан хэрэг юм. Гэхдээ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын зохицуулалт нийгмийн бүхий л гишүүдэд чиглэсэн учир уг Пактад заасан бүх эрхийг ахмад настнууд мөн адил эдлэх эрхтэй гэдэг нь ойлгомжтой. Цаашилбал, ахмад настны эрхийн талаар тодорхой арга хэмжээ авах шаардлага байдаг тул Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нэгдсэн улсууд өөрийн нөөц бололцоог боломжит дээд хэмжээгээр дайчлан ажиллахыг Пакт өөрөө шаарддаг.

Дараагийн анхаарвал зохих асуудал бол хүнийг насаар нь ялгаварлан гадуурхахыг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактаар хориглосон эсэх юм. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын аль алинд үүнийг тодорхой заагаагүй ба үүнийг санаатай орхисон гэхээсээ илүүтэй тухайн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан тайлбарлаж болох юм. Учир нь дээрх баримт бичгүүдийг гаргах үед дэлхийн хүн ам зүйн насжилтын асуудал өнөөдрийнхөөс огт өөр байсан гэж үзэж болно. Хэдийгээр Хүний эрхийн түгээмэл тунхаглал дахь ялгаварлан гадуурхахыг хориглосон ерөнхий заалт нь хүнийг насаар нь ялгаварлан гадуурхахыг хориглох асуудлыг багтааж буй гэж тайлбарлаж болох ч энэ нь асуудлын шийдэл биш ажээ. Эдийн засаг, нийгэм, соёлын

эрхийн тухай олон улсын пактад насаар ялгаварлан хандахыг бүрэн хориглосон гэж үзэх боломжгүй ч насаар ялгаварлан хандахыг маш хязгаарлагдмал хүрээнд хүлээн зөвшөөрч болно гэж Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо онцлон тэмдэглэжээ⁸. Түүнчлэн олон улсын түвшний цөөнгүй бодлогын баримт бичгүүд, оролцогч улсуудын хууль тогтоомжоор ахмад настанд ялгавартай хандахыг хориглосон байдгийг онцлон тэмдэглэх хэрэгтэй. Зарим улс орнуудад тэтгэвэрт гарах нас, эсхүл дээд боловсролын хүртээмж зэрэгт насаар ялгаварлан гадуурхахыг хүлээн зөвшөөрсөн байдаг ба энэ хандлагыг бууруулах, арилгахад чиглэсэн тодорхой оролдлогуудыг хийж байна. Улмаар Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос үзэхдээ улс орон бүр энэхүү хандлагыг өргөжүүлэн түргэтгэх арга зам хайх хэрэгтэй гэж зөвлөсөн байна.

Тэгвэл өнгөрсөн хугацаанд ахмад настны эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хангахад чиглэсэн олон улсын ямар бодлогын баримт бичгүүд гарсан талаар товч авч үзье.

Юуны өмнө 1982 онд Австрийн Вена хотноо хуралдсан Насжилтын асуудлаарх Дэлхийн бага хурлыг дурдах нь зөв. Энэхүү хурлаас Венийн Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж Ерөнхий Ассамблей баталсан байна. Энэ төлөвлөгөө нь ахмад настны эрхийг хамгаалах чиглэлээр оролцогч улс бүрийн авах ёстой арга хэмжээг нарийвчлан тодорхойсноороо чухал удирдамж болсон байна. Энэхүү үйл ажиллагааны төлөвлөгөөнд 62 зөвлөмж орсон ба дийлэнх нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакттай шууд холбоотой байв.

⁸ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 6 дугаар ерөнхий зөвлөмж. Арван тавдугаар чуулган (1995 он)

1991 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей ахмад настнуудад чиглэсэн “Нэгдсэн Үндэстний зарчмууд”-ыг гаргасан ба энэ нь прагматик байдлаараа тухайн үеийн нөхцөл байдалд тохирсон чухал баримт бичиг болжээ⁹. Зарчмууд нь Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан эрхүүдтэй нягт хамааралтай 5 хэсэгт хуваагддаг. Нэгдүгээрт, “Бие даасан байдал” гэсэн хэсэгт хүрэлцээтэй хоол хүнс, ус, орон байр, хувцас, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж орно. Эдгээр үндсэн эрх дээр нэмээд цалин хөлстэй ажиллах боломж, сурч боловсрох бололцоо орно. Хоёрдугаарт, “Оролцоо” гэсэн хэсэгт ахмад настнууд өөрсдийн сайн сайхан амьдралд нөлөөлөх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажилд идэвхитэй оролцох, залуу үетэйгээ өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцах мөн эвлэлдэн нэгдэх, хөдөлгөөнд оролцох боломжийг тусгажээ. Гуравдугаарт, “Халамж” гэсэн хэсэгт ахмад настнууд гэр орондоо, эсхүл эмнэлэгт байх үедээ гэр бүлийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэж, хүний язгуур эрх, эрх чөлөөг эдлэх ёстойг илэрхийлсэн байна. Дөрөвдүгээрт, “Санасан зүйлдээ хүрэх” гэсэн хэсэгт ахмад настнууд өөрсдийн нийгэм дэх боловсрол, соёл, оюун санаа болон нөхөн сэргээх нөөц бололцоог хүртэх замаар өөрсдийгөө бүрэн хөгжүүлэх боломж эдлэх ёстой гэсэн зарчим байна. Эцэст нь “Нэр хүнд” гэсэн хэсэгт ахмад настнууд бусдаар хүндлүүлэн, аюулгүй амьдарч, мөлжлөг, биений болон сэтгэл санааны дарамтаас ангид байж, нас, хүйс, яс үндэс, арьсны өнгө, гарал үүсэл, хөгжлийн бэрхшээл, эд хөрөнгийн байдал, бусад нөхцөл байдлаас үл хамааран эрх тэгш байх ёстой бөгөөд эдийн засагт оруулсан

хувь нэмрээсээ үл хамааран үнэлэгдэх нь зүйтэй гэж үзсэн байна.

Мөн 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей насжилтын асуудлаарх дэлхийн 8 зорилт дэвшүүлж, үндэсний зорилт болгон тавихад зориулсан товч удирдамж гаргасан байна. Эдгээр 8 зорилт нь чухал ач холбогдолтой төдийгүй Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад¹⁰ оролцогч улсуудын үүрэг, хариуцлагыг батжуулжээ.

Венийн Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан гаргасны 10 жилийн ойн баярын арга хэмжээн дээр буюу 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблей насжилтын асуудлаар тунхаглал гаргасан байна. Энэхүү тунхаглалд ахмад настай эмэгтэйчүүд нийгэмд оруулсан хувь нэмрээ дутуу үнэлүүлж ирсэн практикийг арилгахын тулд зохистой тусламж дэмжлэг үзүүлэх, мөн гэр бүлээ тэжээх гэж ажиллаад нийгэм, соёл, сэтгэл санааны чадавхиа хөгжүүлж амжаагүй ахмад настай эрэгтэйчүүдэд түүнийгээ хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, асаргаа сувилгаа хийхэд нь зориулж гэр бүлийн гишүүдэд нь дэмжлэг үзүүлэх, үүнд: гэр бүлийн бүх гишүүд хамтран оролцох явдлыг хөхиүлэн дэмжих замаар 2001 он гэхэд хэрэгжсэн байх насжилтын асуудлаарх Дэлхийн зорилтод хүргэх стратегийн хүрээнд олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэгт чиглэсэн үндэсний санаачлагыг дэмжжээ. Мөн түүнчлэн хүн амын насжилт нэмэгдэж байгаагаар уялдуулан 1999 оныг Олон улсын ахмад настны жил болгон зарласан байна.¹¹

9 Ерөнхий Ассамблейн 1991 оны 12 дугаар сарын 16-ны 1 46/91 тогтоол, Насжилтын асуудлаархи Олон улсын ажил үйлсийн төлөвлөгөө болон бусад арга хэмжээний хэрэгжилт, хавсралт

10 2001 онд хэрэгжсэн байх асуудлаарх дэлхийн зорилт: бодит стратеги. (а/47/339), 3-4 бүлэг

11 Ерөнхий Ассамблейн 1992 оны 10 сарын 16-ны № 47/5 тогтоол, “Насжилтын талаарх тунхаглал”.

2002 онд Мадрид хотноо Насжилтын талаарх дэлхийн 2 дугаар бага хурал болж, ахмад настныг хөгжлийн үйл явцад үр дүнтэй оролцуулахад чиглэсэн зөвлөмж бүхий Мадридын Насжилтын асуудлаарх олон улсын үйл ажиллагааны төлөвлөгөө (2002)-г баталсан юм¹². Энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей 2012 оны 7 дугаар сарын 26-ны өдөр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хүргүүлэх тайланг баталсан байна.

Сүүлийн жилүүдэд НҮБ-аас ахмад настны эрхийг хамгаалсан бие даасан конвенц батлах нь зөв гэж үзэж өдгөө конвенцийн хэрэгцээ, зорилгыг тодорхойлох ажил үе шаттай хийгдэж байна. Бие даасан конвенцтой болохоос өмнө ахмад настны эдэлбэл зохих тэрхүү эрхүүдийг нарийн тогтоож, тодорхойлохыг чухал гэж үзэж энэ чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил нилээд хийж байна¹³.

2010 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 65/182 дугаар тогтоолоор Нээлттэй ажлын хэсгийг (OEWG) байгуулсан бөгөөд уг ажлын хэсэг нь ахмад настны эрхийг баталгаажуулж, зохицуулж буй олон улсын хэм хэмжээнд судалгаа хийх, цаашид авч хэрэгжүүлбэл зохих арга хэмжээг тодорхойлох зорилготой ажилласан болно. Улмаар НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 67/139 дүгээр тогтоолын хүрээнд Нээлттэй ажлын хэсгийг “ахмад настны эрх, эрхэмсэг оршихуйг хамгаалах,

хөхиүлэн дэмжих олон улсын эрх зүйн хэм хэмжээг, үндсэн элементүүдийг агуулсан санал бэлтгэхийг...”¹⁴ хүссэн байна.

Нэмж хэлэхэд, 2013 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл 24 дэх хуралдаанаараа¹⁵ ахмад настны бүхий л хүний эрхийн хэрэгжилтийг үнэлэх чиг үүрэг бүхий бие даасан шинжээчээр Роза Корнфилд Матег томилох шийдвэрийг гаргасан юм. Энэхүү шинжээчийн ажлын үр дүнгээс хамааран Ахмад настны эрхийн тухай бие даасан конвенцтой болох эсэх асуудлыг шийдвэрлэх юм.

Бие даасан шинжээч ажлын анхны тайлангаа 2014 оны 7 дугаар сарын 24-ний өдөр хуралдсан НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн 27 дахь хуралдаан дээр танилцуулсан ба дэлгэрэнгүй тайлангаа тус зөвлөлийн 33 дахь хуралдаан дээр танилцуулах болно.

Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй олон улсын хүний эрхийн хэм хэмжээ, стандартуудыг удирдлага болгон авч үзвэл Ахмад настны эрхийн тухай конвенцийн зорилго нь “Бүхий л ахмад настны хүний эрх, үндсэн эрх чөлөөгөө ижил тэгш, бүрэн дүүрэн эдлэх явдлыг хөхиүлэн дэмжих, хамгаалах, хангах болон тэдний эрхэмсэг оршихуйг хүндэтгэх”¹⁶-эд чиглэх учиртай

12 <http://social.un.org/index/Ageing/MadridPlanofActionanditsImplementation/RegionallImplementationStrategiesoftheMIPAA.aspx>.

13 Sandra Huenchuan and Luis Rodriguez-Picero “Ageing and the protection of human rights: current situation and outlook” Economic Commission for Latin America and the Caribbean (ECLAC) 2011

14 Towards a comprehensive and integral international legal instrument to promote and protect the rights and dignity of older persons, General Assembly Resolution 67/139, A/RES/67/139 (2012), para 2. At http://www.un.org/en/ga/search/view_doc.asp?symbol=A/RES/67/139 (viewed 17 March 2014).

15 The human rights of older persons, Human Rights Council 24th session, A/HRC/24/L.37/Rev.1 (2013), Item 5. At http://ap.ohchr.org/documents/alldocs.aspx?doc_id=22360 (viewed 17 March 2014).

16 Convention on the Rights of Persons with Disability (CRPD), 2006, art 1. At <http://www.un.org/disabilities/convention/conventionfull.shtml>. Fydйration internationale des associations de personnes vйgies

гэж олон улсын шинжээчид үзжээ.

Улмаар конвенц нь дараах тодорхой зорилтуудад чиглэх болно. Үүнд:

- Ахмад настан нь нийгмийн бусад гишүүдийн нэгэн адил хүний эрх, үндсэн эрх чөлөөг баталгаатай эдлэх явдлыг хүлээн зөвшөөрөх¹⁷
- Ахмад настан нь халамж хүртэгчид, нийгмийн хөгжилд саад учруулагч гэсэн хэвшмэл ойлголтыг халж, нийгмийн амьдралд идэвхитэй хувь нэмрээ оруулагч, эрх эдлэгчид гэсэн үзэл хандлага руу шилжих¹⁸
- Насжилт нь байгалийн, жам ёсны, түгээмэл үйл явц болохыг хүлээн зөвшөөрөх¹⁹
- Оролцоонд тулгарч буй саад бэрхшээлийг арилгаж, ахмад настныг нийгмийн өдөр тутмын

амьдралд оролцуулах²⁰

- Ахмад, залуу бүхий л үеийнхнийг оролцуулсан эв нэгдэл, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих.²¹ зэрэг болно.

Хоёр. Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын дагуу Монгол Улсын хүлээж буй үүрэг

Эмэгтэйчүүд, хүүхдүүд зэрэг хүн амын бусад бүлгүүдийн нэгэн адил ахмад настны эрхийн талаарх олон улсын Конвенц хараахан батлагдаагүй байгаа энэ үед Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай пактад заасан эрхийг ахмад настнуудад тууштай эдлүүлэх үүрэг улс орон бүрийн өмнө тавигдаж байна.

Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хороо тус Пактад нэгдэн орсон улс орнууд ахмад настны эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хамгаалахад анхаарал хандуулж, үе шаттай арга хэмжээ авах ёстой гэж үздэг.

Тодруулбал, манай улсын хувьд тус хороонд тайлан хүргүүлэхдээ дан ганц нийгмийн хамгааллын тухай заасан 9 дүгээр зүйлийг хэрхэн хэрэгжүүлсэн тухай мэдээллээс илүүтэй Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад заасан бусад бүхий л эрхүүдийг ахмад настнуудын түвшинд хэрхэн хангаж ажиллаж

(FIAPA), Convention on the right of older adults and optional protocol to the convention (version 6), (2012), art 1. Age UK, Submission to the UN Department of Economic and Social Affairs call for non-governmental organisation input into the open ended working group on ageing, Ref 1613 (2013). At <http://social.un.org/ageing-working-group/documents/fourth/AgeUK.pdf> (viewed 17 March 2014).

17 Үүнийг мөн үзэж болно. AARP, Submission to the UN Department of Economic and Social Affairs call for non-governmental organisation input into the open ended working group on ageing (2013). At <http://social.un.org/ageing-working-group/documents/fourth/AARP.pdf> (viewed 17 March 2014). Age Platform Europe, Submission to the UN Department of Economic and Social Affairs call for non-governmental organisation input into the open ended working group on ageing (2013). At <http://social.un.org/ageing-working-group/csoinputfourth.shtml> (viewed 17 March 2014). Age UK, note 3.

18 See for example, International Federation on Ageing (IFA), Submission to the UN Department of Economic and Social Affairs call for non-governmental organisation input into the open ended working group on ageing (2013). At <http://social.un.org/ageing-working-group/csoinputfourth.shtml> (viewed 17 March 2014). AARP, note 4.

19 See for example, HelpAge International (HelpAge), Submission to the UN Department of Economic and Social Affairs call for non-governmental organisation input into the open ended working group on ageing (May 2013) p 2. At <http://social.un.org/ageing-working-group/documents/fourth/HelpAgeInternational.pdf> (viewed 17 March 2014). Age UK, note 3.

20 See for example, Gray Panthers, Submission to the UN Department of Economic and Social Affairs call for non-governmental organisation input into the open ended working group on ageing (2013). At <http://social.un.org/ageing-working-group/documents/fourth/GrayPanthers.pdf> (viewed 17 March 2014). Permanent Mission of the Republic of Indonesia, Member state input to the fourth working session (2013). At <http://social.un.org/ageing-working-group/memberstatesinputfourth.shtml> (viewed 17 March 2014).

21 Үүнийг мөн үзэж болно. Gray Panthers, note 6. FIAPA, note 3, art 1.

байгаагаа тодорхой тайлагнах үүрэгтэй бөгөөд Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос өгсөн зөвлөмж²² ч үүнд чиглэж байна.

Ахмад настнууд нь хүн амын бусад бүлгийн нэгэн адил өөр хоорондоо ялгаатай байдаг ба тэдний нөхцөл байдал нь бүхэлдээ улс орны нийгэм эдийн засгийн байдал, хүн ам зүй, байгаль орчин, ахуй соёл, ажил эрхлэлтийн хүчин зүйлээс хамаардаг бол хувь хүний хувьд гэр бүлийн нөхцөл, боловсролын түвшин, орон нутаг эсвэл хотод амьдарч байгаа, ямар газар ажиллаж, тэтгэвэрт гарсан эсэхээс хүртэл хамаардаг байна.

Эрүүл мэндийн хувьд сайн, санхүүгийн бололцоотой ахмад настнууд байдгийн зэрэгцээ шаардлагатай тусламж, дэмжлэгийг авч чаддаггүй, хамгийн эмзэг, хамгаалалтгүй бүлэгт багтах ахмад настнууд хөгжингүй орнуудад ч олноор амьдарч байна. Мөн эдийн засгийн хямрал болон өөрчлөлт, шинэчлэлтийн үед ахмад настнууд эрсдэлд орох магадлал өндөр байдаг гэж үздэг. Гэхдээ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын оролцогч улс нөөц бололцоо хүнд байгаа үед ч гэсэн нийгмийн эмзэг гишүүдийг хамгаалах үүрэгтэй болохыг Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооноос²³ зөвлөсөн болно.

Ахмад настны нийгмийн хамгаалалтай холбогдох харилцааг зохицуулах зорилгоор Улсын Их хурал 2005 онд Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Засгийн газар 2009 оны 156 дугаар тогтоолын

22 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны 6 дугаар ерөнхий зөвлөмж. Арван тавдугаар чуулган (1995 он)

23 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн хорооны ерөнхий зөвлөмж №3 (1990) 12 дугаар заалт

хавсралтаар Хүн амын насжилтын асуудлаарх үндэсний стратегийг тусгайлан баталсныг сайшаалтай ч тэдний бусад бүхий л эрхийг баталгаатай эдлүүлэхэд чиглэсэн төрийн бодлого хэрэгтэй юм.

Иймд ахмад настны эрхийг хангах чиглэлээр Улсын Их Хурал, Засгийн газраас төрийн холбогдох байгууллагуудад хяналт шалгалт явуулах замаар нөхцөл байдал, цар хүрээг тодорхойлох, шаардлага хангахуйц бодлого, хөтөлбөрийг уялдаатай боловсруулах, гарцаагүй тохиолдолд хууль тогтоомж батлан гаргах, ялгаварлан гадуурхалтыг нөхцөлдүүлсэн хууль тогтоомжийг өөрчлөх, төсвийн холбогдох дэмжлэг үзүүлэх зэрэг арга хэмжээг авах шаардлагатай байна. Түүнчлэн Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын 22, 23 дугаар зүйл²⁴-д заасан олон улсын хамтын ажиллагааны хүрээ нь хөгжиж буй Монгол Улсын хувьд тус Пактаар хүлээсэн үүргээ биелүүлэх хамгийн чухал арга замын нэг юм.

24 Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт:

22 дугаар зүйл “Эдийн засаг, нийгмийн зөвлөл нь техникийн тусламж үзүүлэх асуудал эрхэлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын бусад байгууллага, тэдгээрийн туслах байгууллага болон төрөлжсөн байгууллагуудын анхаарлыг энэхүү Пактыг амьдралд аажмаар, үр ашигтай хэрэгжүүлэхэд өөрийн эрх хэмжээний дагуу олон улсын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг шийдэхэд нь тэдгээр байгууллагад дөхөм үзүүлэхүйц хийгээд Пактын энэхүү хэсэгт дурдсан тайлантай холбоотой аливаа асуудалд хандуулж болно.”

23 дугаар зүйл: “Энэхүү Пактад оролцогч улсууд түүгээр хүлээн зөвшөөрсөн эрхийг хэрэгжүүлэхэд дөхөм үзүүлэх олон улсын арга хэмжээнд конвенц байгуулах, зөвлөмж гаргах, техникийн тусламж үзүүлэх, зөвлөлдөх зорилгоор бүсийн болон мэргэжлийн зөвлөгөөн хийх, түүнчлэн засгийн газруудтай хамтран судалгаа хийх зэрэг арга хэмжээ багтана гэж үзэж байна.”

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫГ ҮНЭЛЭХ НЬ



Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний
Комиссын референт, докторант

Б.БОЛОРСАЙХАН

Түлхүүр үгс: хүний эрх, хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, хүний эрхийн үндэсний байгууллага, бүс нутгийн механизм, Нэгдсэн Үндэстний Байгууллага, омбудсман, хүний эрхийн омбудсман, хүний эрхийн комисс, бүрэн эрх, үнэлгээ, үр дүн, үр нөлөө

Abstract: In this article the author will discuss the evaluation of national human rights institutions in view of its establishment process, structural elements, mandate and impact in the society.

Хүний эрхийн үндэсний байгууллагыг үнэлэх, ялангуяа үндэсний түвшинд хүний эрхийг эдлүүлэхэд гүйцэтгэж байгаа үүргийг нь тодорхойлоход гадаад болон дотоод хүчин зүйлс шууд хамааралтай. Дотоод хүчин зүйлд хүний эрхийн үндэсний тогтолцоо, түүний үйл ажиллагаа, бүрдүүлж байгаа хэсэг бүрийг анхаарах бол гадаад хүчин зүйлд хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах олон улсын тогтолцоо, түүний чиг үүрэг багтана. Хүний эрхийн үндэсний байгууллагууд (ХЭҮБ) нь ямарваа нэгэн

хүний эрхийн асуудалд шуурхай, хариу арга хэмжээг авахдаа дотоод, гадаад хүчин зүйлийг нэгэн зэрэг анхаарах буюу орон нутгийн хүрээг олон улсын түвшинтэй холбож ажиллах үүрэгтэй гэж болно. Улс орнуудын хувьд хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоог бэхжүүлэх үйл явц бол тасралтгүй үргэлжлэх, зайлшгүй үзэгдэл юм. Хүний эрхийн стандартыг тогтоох, хөхиүлэн дэмжих, түүнийг сахиулахад ахиц дэвшил гарах нь орон нутгийн түвшинд хэрхэн өөриймшүүлсэнээс хамаарна. Тодруулбал хүний эрх, эрх чөлөөг тогтолцоондоо хүлээн зөвшөөрч, байгууламжаараа дэмжиж ажилласан тохиолдолд легитив буюу хүлээн зөвшөөрөхүйц, хууль ёсны шинжийг олно. Тухайн улсын дотор ямар нэгэн хүний эрхийн байгууллагыг бий болгох нь ХЭҮБ өөрийн хараат бус байдлаа хадгалж хүний эрхийг эдлүүлэхэд төртэй нягт хамтран ажиллах, улсынхаа нийгэм, соёлын үндэст тулгуурлан хүний эрхийг олон нийтэд ойлгуулах замаар өөрийгөө таниулах, хүний эрхийн байгууллага болон түүний удирдлага болгох зарчмуудыг иргэний нийгмийн зүгээс мэдрэх зэрэг ашигтай.

Хүний эрхийн талаарх олон улсын гэрээг боловсруулагчид үндэсний түвшинд тус баримт бичгийг хэрэгжүүлэхэд дөхөм болгох зорилгоор гэрээний бичвэрт тусгай заалт оруулах, ХЭҮБ-т мониторинг хийх чиг үүрэг ногдуулах, эсвэл ийм байгууллага байгуулахыг илүүд үзэх болжээ. Жишээлбэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын (НҮБ) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн төслийг боловсруулагчдын зүгээс хяналт тавих, хэрэгжүүлэхэд чиглэсэн заалт оруулж, гишүүн улсуудаа хараат бус ХЭҮБ-д хянах үүргийг ногдуулах, мөн энэ асуудлаарх олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх талаар тусгайлан заажээ. Хамтран ажиллах боломжтой дотоодын хүний эрхийн байгууллагагүй тохиолдолд ХЭҮБ-ууд өөрийн мөрдөн шалгах чиг үүргээ хэрэгжүүлэх замаар учирсан хохирлыг зүй зохистой хэлбэрээр нөхөн төлүүлэхээр шахах, дотоодын байгууллагуудыг хариуцлагатай байхыг шаардах боломжтой. Зүй бус үйлдлийг хянаж баримтжуулсан талаар илтгэл бичиж, үүнд олны анхаарлыг хандуулан төр болон олон нийтийг соён гэгээрүүлэх буюу үйл ажиллагааны шинэ чиглэлд зүглүүлж болно. Тодруулбал, Хүний эрхийн Үндэсний Комиссоос эрүүдэн шүүх болон хүнлэг бус харьцахыг таслан зогсоох, арилгах, төрийн албан хаагчийн буруутай үйлдлээс учирсан хохирлыг барагдуулах, хүүхэд, эмэгтэйчүүд, өндөр настай хүмүүс,

хөгжлийн бэрхшээлтэй, ядуу, бэлгийн цөөнх зэрэг эрх мэдэлгүй, ялгаварлан гадуурхагдсан нийгмийн эмзэг бүлэгт эн тэргүүнд анхаарч байгааг дурдах нь зүйтэй²⁵.

Олон улсад түгээмэл байдлаар хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн талаарх ойлголтыг дотооддоо өөрийн болгоход ХЭҮБ-уудын өдөр тутмын үйл ажиллагаа чухал хувь нэмэртэй билээ. ХЭҮБ чиг үүргээ үр нөлөөтэй гүйцэтгэснээр тухайн улс дахь үндэсний хэмжээний хүний эрхийн нөхцөл байдлыг баримтжуулах, хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцооны талаар мэргэжлийн туслалцаа үзүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх болон түүний хамрах хүрээний талаар төрийг шахах, зөвлөх, НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын өгсөн зөвлөмжийн дагуу арга хэмжээ авахад туслах гэх мэт хүний эрхийг хөхиүлэн дэмжихэд хэд хэдэн үүрэг гүйцэтгэдэг.

Хэдийгээр олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс улс орнуудад ХЭҮБ-ыг байгуулах талаар анхаарч ирсэн ч хүний эрхийн чиглэлээр хэрхэн ажиллаж байгааг үнэлэх асуудлыг чухалд тооцож, зэрэгцүүлэн авч үзэхийг онцолж байна. Үүнтэй уялдан ямар бүтэцтэй болох, хэрэгжүүлж байгаа бүрэн эрх, үзүүлж байгаа нөлөө гэсэн гурван талаас үнэлэх хандлага байж болохыг цохон дурдлаа.

ХЭҮБ-уудыг үнэлэх гурван хандлага			
Үнэлгээ	Бүтцийн	Бүрэн эрхэд чиглэсэн	Нөлөөнд тулгуурласан
Шалгуурын эх сурвалж	Гадаад	Дотоод	Дотоод болон гадаад
Ахиц дэвшлийг илэрхийлэх шинж	Албан ёсны дүрэмд гарсан өөрчлөлт	Бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүтээмжит/үр ашигт байдал	Нийгэмшил

25 Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын илтгэл <http://mn-nhrc.org/32-аас> үзнэ үү.

1. Парисын зарчмуудыг ашиглан бүтцийг тодорхойлох нь:

Нэгдсэн Үндэстний Байгууллагаас 1991 онд зохион байгуулсан Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах зорилготой үндэсний байгууллагуудын талаарх олон улсын хурлын үеэр НҮБ-ын зүгээс ХЭҮБ-уудыг дэмжих санаачлага өрнөсөн билээ. Тус хурлын эцэст хүний эрхийн үндэсний байгууллагуудын эзлэх байр суурь, эрх хэмжээ, чиг үүргийн талаар удирдлага болох зарчмуудыг боловсруулсан юм. Удалгүй НҮБ-ын Ерөнхий Ассемблей 1993 онд Үндэсний байгууллагуудын статуст хамаарах зарчмуудыг баталсан нь “Парисын зарчмууд” гэж түгжээ²⁶. Одоо ХЭҮБ-уудыг үнэлэхдээ Парисын зарчмуудыг үнэлгээний үндсэн хэрэглэгдэхүүнээр сонгох нь түгээмэл гэж болно. Ийнхүү ашиглахдаа бүтцийн асуудалд түлхүү анхаардаг гэсэн үг. Зарим судлаачид “Парисын зарчмуудыг хангасан нь тухайн ХЭҮБ нь хүний эрхийг хамгаалах, өөрчлөлт авчрах үр нөлөөтэй байгууллага гэж тооцох үндэслэл болохгүй” гэж шүүмжилдэг²⁷. Гэсэн хэдий ч “олон улсын хамтын нийгэмлэгээс Парисын зарчмуудад нийцүүлэхийг хүлээн зөвшөөрснөөр тухайн ХЭҮБ илүү хариу үйлдэл үзүүлж, үр нөлөөтэй ажиллана гэж тооцож болно” гэжээ²⁸.

Өмнө дурдсанчлан Парисын зарчмууд аливаа ХЭҮБ-уудад бүтцийн хүрээнд тавих шалгууруудыг заасан юм²⁹.

Парисын зарчмууд нь хүний эрхийн үндэсний байгууллагуудын статус, бүрэн

эрх, чиг үүрэгтэй холбоотой жишиг тогтоодог³⁰. ХЭҮБ-уудын үйл ажиллагаа зөвлөх шинжтэй буюу хууль тогтоох, шүүх эрх мэдлийн салбарт хамаарахгүй ч хувь хүний гомдлыг шийдвэрлэхдээ хагас-шүүх эрх мэдлийн (quasi-judicial) шинж агуулдаг³¹. Хэдийгээр гомдол хүлээн авч шийдвэрлэх механизм нэмэлт шинжтэй байдаг бол хүний эрхийн мониторинг огт өөр асуудалд хамаарна. ХЭҮБ-ууд өөрийн улсын нөхцөл байдлыг хянаж, төрийн зүгээс үйлдсэн зүй бус үйлдлийг илтгэдэг билээ. Мөн ХЭҮБ-ууд засгийн газарт үндэсний хууль тогтоомжтой холбоотой болон олон улсын хүний эрхийн гэрээтэй нийцэж байгаа эсэх асуудлаар зөвлөдөг онцлогтой. Тухайн байгууллага нь үүсгэн байгуулах зохицуулалт бүхий үндсэн хуулийн эсвэл хуульд үндэслэнэ. Түүний бүрэн эрх нь аль болох өргөн бөгөөд алсын хараа бүхий зохицуулалттай байвал зохино. ХЭҮБ-ыг гишүүдийг томилох журам нь хараат бус ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн байх ба бүрэн эрхийг хуульд тусгайлан заасан байна. Байнгын үйл ажиллагаатай байхын зэрэгцээ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлж, өөрийн бүрэн эрхийг эдлэхэд хүрэлцэхүйц төсөвтэй байна. Тухайн ХЭҮБ нь эн тэргүүнд гүйцэтгэх эрх мэдлээс хараат бус байх ёстой³².

НҮБ-аас дэмжин хамтран ажилладаг, ХЭҮБ-уудын хамтын удирдлагатай Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Олон улсын зохицуулах хороо (ОУЗХ) нь дэлхий дахины ХЭҮБ-ууд дээрх зарчмуудад нийцэж

26 <http://www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/StatusOfNationalInstitutions.aspx> -аас үзнэ үү.

27 Э.Бирнес, А.Дурбах, К.Реншау "Клубт элсэх нь: Хүний эрхийн үндэсний байгууллагуудын Ази Номхон далайн чуулган, Парисын зарчмууд, бус нутагт хүний эрхийн хамгаалалтыг сайжруулах нь", Australian Journal of Human Rights 14 (2009), 63-98 дугаар тал.

28 Мөн тэнд.

29 Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын тухай мэдээллийн хуудас №19 <http://www.ohchr.org/Documents/Publications/FactSheet19en.pdf> -аас үзнэ үү.

30 ХЭҮБ-ууд байгуулах Ази, Номхон далайн чуулганаас гаргасан зөвлөмж <http://www.asiapacificforum.net/members/international-standards/downloads/best-practice-for-nhris/APF%20-%20Guidelines%20on%20Establishing%20NHRIs.doc/view> -аас үзнэ үү.

31 Брайн Бурдекин, "Хүний эрхийн комиссууд", "Хүний эрхийн комиссууд, омбудсманы газрууд: Дэлхий дахин дахь үндэсний туршлага" (Boston: Brill, 2000), 801-8 дугаар тал.

32 Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах үндэсний байгууллагуудын тухай мэдээллийн хуудас №19 <http://www.ohchr.org/Documents/Publications/FactSheet19en.pdf> -аас үзнэ үү.

байгаа түвшингээр магадлан итгэмжилдэг. Магадлан итгэмжлүүлэх хүсэлт гаргаж байгаа ХЭҮБ-ын бэлтгэсэн тайлан мэдээ, аман мэдэгдэлд үндэслэн ОУЗХ-оос байгууллага бүрийг гурван ангилалд хуваадаг. ОУЗХ-ны журмын дагуу “А” (Парисын зарчмуудад бүрэн нийцсэн, ОУЗХ-ны гишүүн байгууллага), “В” (Парисын зарчмуудад бүрэн нийцээгүй, “ажиглагч” статустай байгууллага), “С” (Парисын зарчмуудад огт нийцээгүй, ямар нэгэн статусгүй байгууллага) гэж ангилдаг. “А” магадлан итгэмжлэл бүхий ХЭҮБ нь НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн үйл ажиллагаанд төрөл бүрийн байдлаар оролцох боломжтой болсон цагаас ОУЗХ-ны магадлан итгэмжлэлийн ач холбогдол нэмэгдсэн³³. ХЭҮБ-уудын үйл ажиллагаа нь Парисын зарчмуудтай нийцээгүй тохиолдолд “А”, “В” магадлан итгэмжлэлийг түр эсвэл нэг мөсөн хүчингүй тооцох зохицуулалт бий³⁴.

ОУЗХ-ны гүйцэтгэдэг гол үйл ажиллагааны нэг нь ХЭҮБ гишүүдийн бүрэлдэхүүндээ олон ургалч байдлыг тусгаж байгаа эсэх, олон талт, нээлттэй оролцоог дэмжсэн журам хэрэгжүүлж байгааг хянахад оршино. Хянахдаа:

- Үйл ажиллагаа явуулж байгаа хүн амын олон янзат байдлыг хэрхэн тухайн байгууллагын төлөөлөлд тусгасан бэ?
- Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харьцаа ямар вэ?
- Угсаатны бүлгийг оруулсан уу?
- Томилгоонд тавих шаардлага нь одоогийн томилгоог үнэлж болохуйц бодитой, үндэслэлтэй юу?
- Гавьяа зүтгэлд (мерит) тулгуурласан томилгооны шалгуур бий юу?
- Хүний эрхийн талаарх мэдлэг

33 Хуучин НҮБ-ын Хүний эрхийн комиссыг орлохоор 2006 онд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийг байгуулсан юм.

34 ОУЗХ-ны Дүрэм <http://nhri.ohchr.org/EN/AboutUs/Governance/Statute/ICC%20Statute%20as%20amended%20at%20ICC%2025.pdf> –аас үзнэ үү.

шаардсан шалгуур бий юу? зэрэг асуулт тавьдаг³⁵.

ОУЗХ-ны зүгээс эдгээр асуултыг бүх улсад давтаж асуух нь хачирхалтай үр дүнд хүргэх нь бий. Жишээлбэл, үйл ажиллагаагаа Парисын зарчмуудад нийцүүлэхээр хичээж буй Малайз Улсын ХЭҮБ олон ургалч байдалтай холбоотой асуудлаар ахиц гаргасан тул “А” магадлан итгэмжлэл авсан бол хүний эрхэд харьцангуй ээлтэй гэж болох Швейцарийн Холбооны Улс эмэгтэйчүүдийн асуудал дээр оновчгүй шийдвэр гаргасан тул “В” магадлан итгэмжлэл авсан байна³⁶. Дээрх үр дүнгийн улмаас ОУЗХ-г “ХЭҮБ-ууд хэт туйлширсан шийдвэр гаргаж байна” гэж шүүмжилдэг.

ХЭҮБ-ыг үнэлэхэд Парисын зарчмуудтай холбоотой шүүмжлэл дагуулдаг өөр нэг асуудал бол тухайн улс доторх асуудлыг арилгахаар төрөөс байгуулдаггүй, харин тодорхой нөхцөл байдлаас хамааралтайгаар тус улсын гадна орших эрх мэдэл бүхий этгээд ХЭҮБ байгуулах юм. Үүний тод жишээ нь 1995 оны Босниа-Герцеговинад хамаарах Дейтоны хэлэлцээр, 1998 оны Хойд Ирландад хамаарах Сайн Баасан гаригийн хэлэлцээр зэрэг НҮБ-ын оролцоотой байгуулсан энхийн хэлэлцээрийн дагуу үүсэн бий болсон ХЭҮБ юм. Урьд хараат бус байгууллага байгуулж байгаагүй улсуудад асуудал тулгарах нь илэрхий ажээ. ХЭҮБ-уудын нэг онцлог шинж нь төр болон иргэний нийгмийн аль алианаас хараат бус байх билээ. Гэсэн хэдий ч Ирак зэрэг улсын хувьд төрөөс дэмжлэг авах, эсвэл Иракийн улс төрийн болон шашны бүлгийн нөлөөнд автаж байсан байна.

35 ОУЗХ-ны Магадлан итгэмжлэл хариуцсан дэд хорооноос гаргасан Ерөнхий тайлбар <http://nhri.ohchr.org/EN/AboutUs/ICC Accreditation/Documents/SCA%20GENERAL%20OBSERVATIONS%20ENGLISH.pdf>

36 ОУЗХ-ны Магадлан итгэмжлэл хариуцсан дэд хорооны 2009 оны 11 дүгээр сарын хурлын тайлан http://nhri.ohchr.org/EN/AboutUs/ICC Accreditation/Documents/2009_November%20SCA%20REPORT.pdf

Мөн Парисын зарчмуудын заалт нь олон улсын зүгээс хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхийг уриалсан ч гэсэн учир дутагдалтай, хэрэгжихүйц биш гэж үзэх нь бий. Жишээлбэл, Парисын зарчмуудын дэд бүлэгт тусгасан “хараат бус, олон ургалч байдлын баталгаа” нь хараат бус байдлаа хэрхэн хангах талаар удирдамж болж чадахгүй, үр нөлөөгүй гэж тооцдог. Эдгээр зарчим бол ХЭҮБ-уудыг байгуулах тухай хэлэлцэхэд санаа өгөх төдий болохоос сул талаа арилгах, хязгаарлагдмал нөөцтэй тул төрөл бүрийн байдлаар дэмжих зэрэгт олон улсын хүний эрхийн хөдөлгөөний зүгээс ач холбогдол өгөхгүй байна гэдэг³⁷. Гэхдээ Парисын зарчмууд бол үнэлгээний хэрэглэгдэхүүн биш. Дээрх зарчмын зорилго нь тус тусдаа байгууллагуудын статусыг тогтоох, өөрийн үүргээ тодорхойлох боломжийг ХЭҮБ-уудад олгоход оршино. Нөлөөлийн үйл ажиллагаа явуулдаг зарим бүлэг ХЭҮБ-уудад шинэ шалгуур тогтоох эсвэл Парисын зарчмууд дахь шалгуурын дагуу ХЭҮБ-уудын статусыг илүү тодруулах хэрэгтэй гэж үздэг³⁸. Женев хотод байрлах Хүний эрхийн бодлого хариуцсан олон улсын зөвлөл (ХЭБОУЗ) ХЭҮБ-уудын үйл ажиллагааны үр нөлөөг бэхжүүлэхэд ашиглаж болохуйц бүтцийн асуудал хөндсөн арван хоёр өөрчлөлт санал болгожээ. ХЭБОУЗ-ийн саналын дагуу ХЭҮБ-ууд албан ёсны эрх зүйн статус авахдаа:

- Олон нийт хүлээн зөвшөөрөх;
- Хүн бүрт, ялангуяа хамгийн эрх мэдэлгүй, гадуурхагдсан бүлэгт хүрч ажиллах
- ХЭҮБ-ын соёл нь нээлттэй, хамтын ажиллагаат, өөртөө шүүмжлэлтэй ханддаг байна.

37 Раж Кумар, “Хүний эрхийн үндэсний байгууллагууд: Хүний эрхийг институцичлах сайн засаглалын үзэл санаа”, *American University Law Review* 19 (2003), 259-90.

38 Human Rights Watch, *Protectors or Pretenders? Government Human Rights Commissions in Africa* (New York, HRW, 2001)

Гишүүнчлэлд өндөр шалгуур тавих ба олон янзат төлөөллийг багтаах, төлөөллийн чанарт анхаарах ёстой. Мөн ХЭҮБ-ын ажилтнууд ч гэсэн олон янзат төлөөлөлтэй байна. Тухайн ХЭҮБ хүний эрхийн асуудлаар өргөн хүрээнд ажиллах боломжтой байх ба хөндлөнгийн хяналт тавих, мониторинг хийх, түүндээ тулгуурлан зөвлөмж өгөх, хүний эрхийн асуудалд өөрийн бодлоготой хандах, хүрэлцэхүйц төсөвтэй байх, үр нөлөөтэй олон улсын харилцаа тогтоох ёстой.

Энэхүү төсөөлсөн хэлбэр нь бүрэн илэрхийлээгүй байж магад. Хүсч буй үр дүндээ хүрэх буюу үр нөлөөг нь дан ганц ХЭҮБ-ууд байгуулах, чиг үүргээ хэрэгжүүлэхээр харвал өрөөсгөл болно. Хүсч буй үр дүн бол хараат бус байдлаа хангасан эсэхээс илүүтэйгээр ХЭҮБ-ын бүрэн эрхэд тусгасны дагуу хүний эрхийг хөхиүлэн дэмжиж чадсан уу гэж үзэх боломжтой.

2. Бүрэн эрхэд чиглэсэн байдлаар үнэлэх нь

Тухайн ХЭҮБ нь хараат бусаар бусад этгээдтэй нягт хамтрах боломжтой ч тухайн улсад нийгэм, улс төрийн эрхүүдийг эдлэхэд ахиц гаргахаар шууд нөлөөж чадахгүй. Хэдийгээр ямар хэлбэртэй байх нь чухал боловч бодлого боловсруулагчид хууль ёсны шинжтэй ямар дүрэм журам тогтоосон бэ гэдгээр үр дүн илэрч болно. ХЭҮБ-ын үр нөлөөт байдлыг илэрхийлэх олон хүчин зүйлс байгаа ч байгууллага өөрийгөө бүрэн хянаж, удирдаж ажиллах нь хангалтгүй. Иймээс албан ёсоор ХЭҮБ-ыг хэрхэн байгуулсан гэдгээр бус, хүний эрхийн талаарх бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгааг анхаарах нь зүйтэй.

Үүнтэй уялдан ХЭҮБ бүрийн үр нөлөөт байдлыг үнэлэхдээ хуулиар олгосон бүрэн эрхээ үндэсний хэмжээнд хэрхэн хэрэгжүүлж

байгааг анхаардаг хандлага бий болжээ. Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтрах, нийгмийн харилцаанд илүү өргөн хүрээг хамарч оролцох боломжийг төрийн зүгээс хүлээн зөвшөөрсөн байна. Улс бүрийн нөхцөл байдал харилцан адилгүй ч тухайн улс дахь хувь хүмүүс болон төрийн түүхэн харилцаанаас хамаарч, улс төрийн шинжтэй үйл явцын нөлөөгөөр бүрэн эрхийг харилцан адилгүй тогтоодог ажээ³⁹. Шилжилтийн үедээ, тодруулбал зөрчилдөөний дараа сэргэж байгаа (Босни Герцеговина, Хойд Ирланд гэх мэт), төрийн хэлбэрээ өөрчилж байгаа улсын хувьд (БНЧУ гэх мэт) ХЭҮБ нь нийгмийн бүлгүүдэд үүссэн дарамт шахалтад эн тэргүүнд анхаарах, төрд итгэх нийгмийн итгэлийг бий болгохын төлөө анхаарч ажиллах боломжтой⁴⁰. Хэрэв хүний эрхийг хамгаалах чадавхтай байгууллага дулимаг байвал хувь хүний гомдол гаргах эрхийг төрөөс анхаарч, онцгойлон ач холбогдол өгч болно⁴¹. Хүний эрхийг хөхүүлэн дэмжих талаар ажилласан олон жилийн туршлагатай, тогтвортой байгууллагуудаараа дамжуулан дэлхий дахинд өөрийн улсын ололт амжилтыг түгээх зорилгоор ажилладаг улс (Данийн вант улс, ХБНГУ гэх мэт) байна⁴². Парисын зарчмуудын дагуу ХЭҮБ-д аль болох өргөн бүрэн эрх олгохыг дэмждэг ч бүрэн эрхэд чиглэсэн үнэлгээг хийхдээ ирээдүйд юу хийхээр зорьж байгааг бус, харин тухайн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ямар ололт амжилт гарсныг анхаарч үздэг онцлогтой. Төрийн зүгээс ХЭҮБ-ын бүрэн эрхтэй холбоотой асуудлаа хамгийн бага хэмжээнд харуулахыг хүссэн үед энэ аргачлалыг илүүд үздэг бол хүний эрхийн тэмцэгч анхаарвал зохих гурван зүйл байна гэж байр сууриа илэрхийлдэг.

39 Sonia Cardenas. Review of Mertus, Julie, Human Rights Matters: Local Politics and National Human Rights Institutions. H-Human-Rights, H-Net Reviews. August, 2009.

40 Мөн тэнд.

41 Мөн тэнд.

42 Мөн тэнд.

Нэгдүгээрт, ХЭҮБ чиг үүргээ үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд тодорхой бүтцийн шинжтэй тулгууруудаа бий болгох ёстой. Төрийн хувьд улс орны одоогийн нөхцөл байдлын улмаас хэрэгжүүлэх боломжгүй бүрэн эрхийг хүлээн зөвшөөрч болох ч төрийн зүгээс ямар алхам хийж байна вэ гэдгийг анхаарах нь чухал. Жишээлбэл, ХЭҮБ-д үндэсний хэмжээнд хүний эрхийн нөхцөл байдалд хөндлөнгийн хяналт тавих, мониторинг хийх бүрэн эрхийг дэмжсэн ч нотлох баримт цуглуулах эрх мэдлийг хязгаарлаж болзошгүй. Үүний тод жишээ бол Хойд Ирланд юм⁴³. Өөрөөр хэлбэл төр ХЭҮБ байгуулахыг олны өмнө дэмжмэгцээ бүрэн эрхийг нь хязгаарлагдмал тогтоох боломжтой гэсэн үг. ХЭҮБ хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжийг судлах эсвэл шүүхэд оролцох эрх хэмжээгүй байж болно. Хэдийгээр мөрдөн шалгах эрх хэмжээ олгосон ч нотлох баримт цуглуулах, гэрч дуудах, хохирогчдын эрхийг хамгаалах, шүүхэд хандах, эрх сэргээн эдлүүлэх тухай зөвлөмж гаргах талаар огт тусгаагүй байх жишээтэй.

Хоёрдугаарт, ХЭҮБ-уудын зөвлөх үүргийг анхаарч үзвэл зохино. Ихэнх ХЭҮБ-ууд олон улсын стандартын дагуу төрийн үйл ажиллагаа задлан шинжлэх, гэрээний хороодод тайлагнахад дэмжлэг үзүүлэх, ялангуяа хүний эрхийн стандартыг үндэсний хууль тогтоомжид нийцүүлж байгаа талаар санал гаргах зэрэг бүрэн эрхтэй байдаг. Шаардлагатай үед ХЭҮБ-ууд Засгийн газрынхаа илтгэлтэй зэрэгцүүлэн өөрийн байр сууриа илэрхийлсэн илтгэл явуулах боломжтой⁴⁴. Хүний эрхийн талаар илтгэх шаардлагагүй гэж үзсэн тохиолдолд

43 Хойд Ирландын Хүний эрхийн Үндэсний Комисс <http://www.nihrc.org/about-us/what-we-do/investigating-human-rights-issues>

44 Danish Institute for Human Rights, Parallel Report To The Un Committee On The Rights Of Persons With Disabilities, Denmark 2014.

жил бүр өргөн барьдаг үндэсний илтгэлдээ оруулах боломжтой. ХЭҮБ-уудаас цаг ямагт өөрийн олж авсан мэргэжлийн туршлагаа идэвхтэйгээр, байнга хуваалцахыг шаарддаг гэж болно. Гэхдээ хараат бус ажиллаж байгаа гэдгээ бүрэн илэрхийлэхийн тулд төртэй улам ойртох бус, тэнцвэрийг хадгалах шаардлагатай. Гэсэн хэдий ч Бүгд Найрамдах Босни Герцеговина Улсад байгуулсан хэд хэдэн ХЭҮБ-ууд тэнцвэрээ хадгалж чадаагүй байна.

Гуравдугаарт, бүрэн эрхэд чиглэх нь ХЭҮБ хүний эрхийг үр нөлөөтэй хөхиүлэн дэмжиж байгаа эсэхээс үл хамааран өөрийн төлөвлөсөн ажлаа гүйцэтгэж байгааг анхаардаг тул төрийн зүгээс дэмжих хандлагатай байдаг. ХЭҮБ-ын бүрэн эрхийн хэр хэмжээ нь төрийн зүгээс идэвх санаачлагатай эсэхтэй шууд хамааралтай. Мөн ХЭҮБ-ын үйл ажиллагаагаар дамжуулан хязгаарлагдмал шинжтэй бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгааг анхаардаг.

Хязгаарлагдмал шинжтэй бүрэн эрх бүхий, ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн чиглэлээр ажилладаггүй ХЭҮБ-уудын талаар хүний эрхийн байгууллагууд өрнөсөн санаачлага бий. Хорин дөрвөн ХЭҮБ-уудын төлөөлөл 2005 онд БНЭУ-ын Шинэ Дели хотод цугларан Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлж буй үндэсний байгууллагуудын талаарх Олон улсын дугуй ширээний уулзалтад оролцжээ. Үүний дүнд ХЭҮБ-ууд өөрийн бүтэцдээ Эдийн засаг, нийгэм, соёлын эрх хариуцсан нэгж байгуулах, эдгээр эрхийн чиглэлээр үр нөлөөтэй ажиллахын тулд бодлого боловсруулахыг зөвлөсөн байна⁴⁵. Мөн ХЭҮБ-уудын бүрэн эрхийг илэрхийлэх шинжүүдийг өргөжүүлэхийн тулд ОУЗХ

⁴⁵ Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийг хэрэгжүүлж буй үндэсний байгууллагуудын талаарх Олон улсын дугуй ширээний уулзалт <http://nhrc.nic.in/dispatchive.asp?fno=1156>

болон Харвардын Хуулийн сургуулийн Хөгжлийн бэрхшээлийн талаарх төслийн санаачлагаар ХЭҮБ-уудын бүрэн эрх, үйл ажиллагааны төлөвлөгөөнд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг тусгайлан уялдуулахыг дэмжсэн ажээ⁴⁶.

ХЭҮБ-ын бүрэн эрхийг өргөжүүлэхээр ажиллахын зэрэгцээ үйл ажиллагааг нь үнэлэхдээ ХЭҮБ байгуулахаас өмнө, байгуулах үед, мөн байгуулсан ХЭҮБ-ын үйл ажиллагааны үр дүнд дэмжлэг авсан тал бүрийн хүмүүс оролцуулахыг зорьдог. Ялангуяа орон нутгийн анхан шатны нэгжид иргэд ямар хүний эрхийн асуудалтай нүүр тулж байгааг тодорхойлохын хамт ХЭҮБ-аа мэдэж байгаа эсэх, тэдний амьдралд нөлөөтэйг мэдэж байгаа эсэхийг тодруулдаг онцлогтой. Мөн хүний эрхийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, эрх мэдэлгүй гадуурхагдсан бүлэг, төрийн албан хаагчид, хууль тогтоох байгууллагын гишүүд, сайд нар, улс төрийн намын гишүүд, хуульчид, шүүгчид, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод, судлаачид, багш нар, хүний эрхийн шинжээч нарыг хамруулдаг. Харин ямар бүлэгт анхаарч ажиллах ёстой гэдгээ тодорхойлохоос илүү хууль тогтоох үйл явцад хэрхэн нөлөөлөх, байгууллагаа яаж бэхжүүлэх, олон нийт орон нутгийн түвшинд нийгмээ өөрчлөх боломжтой эсэхийг задлан шинжилвэл зохино.

3. Нөлөөнд тулгуурлах нь

Дээрд дурдсан тухайн ХЭҮБ бүтцийн тодорхой шинжээ хадгалж байгаа талаарх бүтцийн үнэлгээ, мөн өөрийн төлөвлөсөн зүйлээ гүйцэтгэх бүрэн эрхэд чиглэсэн үнэлгээний зэрэгцээ “эдгээр үйл ажиллагаа нь хүний эрхийн нөхцөл байдлыг өөрчилсөн үү” гэдэгт анхаардаг нөлөөнд тулгуурласан

⁴⁶ Харвардын Хуулийн сургуулийн Хөгжлийн бэрхшээлийн талаарх төсөл <http://hpod.org/activities/archive>

үнэлгээ бий⁴⁷. Бүтцийн үнэлгээг төр болон ХЭҮБ-д хамаарах гадаад шинжтэй асуудлын талаар гарсан ахиц дэвшлийг үнэлэхдээ ашигладаг бол бүрэн эрхэд чиглэсэн үнэлгээ нь анхан шатны нэгжид хэр хүрч байгаагаар шалгуураа тогтоосон гэж болно. Нөлөөнд тулгуурласан үнэлгээ нь ХЭҮБ хүний эрхийг хөхиүлэн дэмжих замаар ямар нөлөө нийгэмд үзүүлснийг тодорхойлдог. Үүнд нийгмээ өөрчилсөн эсэхийг тогтоох шалгуур, хүний эрхийн хэм хэмжээтэй нийцсэн байдал, хүний эрхийн ойлголт, түүгээр бий болсон туршлага нь нийгэмд тогтсон буюу хүний эрхийн ойлголт нийгэмшсэн/нийт олонхид бий болсон эсэхийг анхаарна.

НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссарын дэмжлэгтэйгээр 2005 онд ХЭБОУЗ нь ХЭҮБ-ууд өөрийн үр нөлөөт байдлаар хэрхэн үнэлэх талаар судалгааны төсөл хэрэгжүүлсэн. ХЭБОУЗ-ийн “Гүйцэтгэл, хууль ёсны шинж” сэдэвт ХЭҮБ-уудын талаарх 2000 оны илтгэлийн дагуу гүйцэтгэсэн уг төслийн тайланг ОУЗХ-оос хүлээн зөвшөөрч чуулганыхаа хэлэлцэх асуудалд оруулсан юм⁴⁸.

ХЭБОУЗ-ийн тайланд ХЭҮБ өөрийгөө үнэлэх, мөн өөрийн гүйцэтгэлийг хэмжих хэмжүүрүүдийг тусгасан байна. Парисын зарчмуудад үндэслэн боловсруулсан хэмжүүрт өмнө дурдсанчлан үр нөлөөт байдлын бүрэн дүүрэн баталгаа болохгүй үзүүлэлт бий. Үүнд:

- Хараат бус байдал
- Үндсэн хууль/хуулиар байгуулах
- Шударга, ил тод томилох журам
- Гишүүнчлэлд тавих шаардлага (Олон ургалч байдлыг дэмжсэн)
- Мэргэжлийн ур чадвар, хүний эрхийн мэдлэгтэй гишүүдийг оруулах

- Иргэний нийгэмтэй сайтар харилцах
- Өргөн хэмжээтэй, хариу үзүүлэх боломжит бүрэн эрх
- Нийтийн хариуцлага зэрэг багтана.

ХЭҮБ-ууд дээрх хэмжүүрийг хангасан эсэхээ нягтлах тооны, чанарын, оролцооны шинжтэй шалгуур ашиглаж болно. Үүнтэй уялдан дээрх жагсаалт дээр нэмж, ХЭҮБ-ын нөлөөг тухайн ХЭҮБ-ын бүтцийн шинжтэй механизмаа өөрчлөх чадвараар үнэлж болох юм. Үүнд:

- Үндсэн хуулийн шинжтэй хяналт тавих эрх мэдэл
- Хууль тогтоох шинжтэй хяналт тавих эрх мэдэл
- Эрх зүйн санкц (Шүүхийн журмаар)
- Хүний эрхийн нөхцөл байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хөндлөнгөөс хяналт тавих
- Үйл ажиллагааны хэм хэмжээг өөрчлөх шинжтэй шүүмж агуулсан илтгэл
- Эрхийг сэргээн эдлүүлэх механизмын хариу үзүүлэх байдал нэмэгдэх
- Эрхийг сэргээн эдлүүлэх механизмын хүртээмж дээшлэх
- Төрийн бусад байгууллагуудтай ажиллах ХЭҮБ-ын уялдаа холбоо гэх мэт.

ХЭҮБ-ын нөлөөг тодорхойлох тогтсон салбарын арга зүй байхгүй учир дийлэнх ХЭҮБ-уудад ашиглаж болох хэмжүүр боловсруулж, шалгуур үзүүлэлтээ сайжруулах боломжтой. Гэхдээ шалгуур үзүүлэлт нь нийгмийн өөрчлөлтийг бүрэн дүүрэн илэрхийлэхээс илүүтэй тодорхой, хэмжигдэхүйц үр дүнг харуулдаг болохыг онцлох нь зүйтэй. Нийгмийн өөрчлөлтөө үнэлэхийн тулд төрөл бүрийн арга зүйг боловсруулж ашиглаж ирсэн Азийн

47 R.Carver, Assessing the Effectiveness of National Human Rights Institutions (Versoix: ICHRP, 2005), 7 дахь тал.

48 http://www.nhri.net/default.asp_PID=85_DID=0.html

барометр⁴⁹, Афробарометр⁵⁰, Евробарометр⁵¹, Арабын ардчиллын барометр⁵², Латинбарометр⁵³, Дэлхийн үнэт зүйлсийн судалгаа⁵⁴ зэрэг туршлага байдаг. Нийгэмд өөрчлөлт гарсан, ялангуяа ХЭҮБ-ын зүгээс төрийн байгууллага, албан хаагчийг үүргээ биелүүлэхийг шаардах боломж бүрдсэн, асуудалд шуурхай хандаж байгааг тодруулах шалгуур үзүүлэлтэд:

- Олоннийтийн мэдээллийн хэрэгслээр шүүмжилсэн сурвалжлага, мэдээ цацагдах
- Төрийн бодлогод мэдэгдэхүйц өөрчлөлт гарах
- Төрийн албан хаагчийн (цагдаа, хянагч, прокурор, шүүгч, сонгуулийн хорооны ажилтан, нийгмийн халамжийн байгууллага гэх мэт) хүний эрхийн боловсрол нэмэгдэх
- Хүний эрхээ шаардсан гомдлын тоо нэмэгдэх
- Хуулийн байгууллагад гарах өргөдөл, нэхэмжлэл нэмэгдэх (шүүх, захиргааны шүүх гэх мэт)
- Хүний эрхийн асуудлаар бодлогоо тодорхойлсон улс төрийн намуудын гишүүнчлэл нэмэгдэх
- Нийтийн байр суурь өөрчлөгдөх, хүний эрхийн талаарх мэдлэг ойлголт нэмэгдэх гэх мэт.

Дүгнэвэл, дэлхий дахинд ХЭҮБ-ууд өсч нэмэгдэж байгаа нь тэдний үзүүлэх нөлөө эсвэл үр нөлөөг илэрхийлэх шалгуур болохгүй. Төрийн болон төрийн бус байгууллагын зүгээс өөрийн хууль ёсны шинжийг тодорхойлох, амжилтаа үнэлэх нь зайлшгүй зүйл тул ХЭҮБ-ын үнэлгээ чухал ач холбогдолтой.

49 www.asianbarometer.org

50 www.afrobarometer.org

51 http://ec.europa.eu/public_opinion/

52 www.arabbarometer.org

53 www.latinobarometro.org

54 www.worldvaluessurvey.org

ХЭҮБ-ыг байгуулснаар л XXI зуунд хүний эрхийг бодит биелэл болгоно гэж ойлгохгүй ч эдгээр байгууллагууд нь хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалахад туслах болно. Парисын зарчмуудад нийцүүлэн ХЭҮБ байгуулмагцаа үр нөлөөг нь тодорхойлох боломжгүй ажээ. Ялангуяа ХЭҮБ-ууд өөрийн үр нөлөөг байдлаа батлахын тулд Парисын зарчмуудын зэрэгцээ тухайн улсын төр хэрхэн хамтарсан, улс төрийн хичээл зүтгэл ямар байгааг дахин анхаарах нь чухал. Үүнгүйгээр Парисын зарчмууд бол эхлэлийн цэгээс хэтрэхгүй ба тухай үндэсний байгууллагын бүрэн эрх, эсвэл нөлөөг хэмжихэд өчүүхэн төдий хувь нэмэртэй байна.

ХЭҮБ-ын үйл ажиллагааг үнэлэх нь өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлсэн эсхийг хэмжих зарим хэмжүүрийг харуулах бол нөлөөнд тулгуурлаж задлан шинжилснээр ХЭҮБ нь хүний эрхийн соёлыг бий болгох, төлөвшүүлэх үүргээ биелүүлсэн эсэх тодорхой нотолгоотой болно. ХЭҮБ-ын зүгээс орон нутгийн шинжтэй хүний эрхийн соёлыг бий болгоход ямар арга замаар хувь нэмрээ оруулсан, хэрхэн ажилласан талаар туршлага солилцох, хэлэлцэх, үнэлэх нь Парисын зарчмууд, бусад шалгуурын дагуу бодитой нөлөө үзүүлж, үр нөлөөтэй ажиллаж байгаагаа мэдэх боломжийг бүрдүүлнэ. Цаашилбал хүний эрхийн асуудлаарх онолын ойлголтоо бэхжүүлэх, тодруулбал хэрхэн ХЭҮБ-ууд болон дотоодын бусад байгууллагуудын эрх мэдлийн харилцаа нь, ХЭҮБ-уудад бүс нутгийн болон олон улсын түвшний байгууллагуудаас үзүүлэх эрх мэдлийн нөлөө нь үндэсний хэмжээний бодлого боловсруулах түвшинд тэднийг хязгаарлаж, эсвэл дэмжиж байна уу зэргийг судлах, тайлбарлах шаардлага тулгарч байна.

ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН АЛБА ХАШИХ ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ ДАХЬ ЗАРИМ ЗӨРЧИЛ, ХИЙДЭЛ



Удирдлагын Академийн эрх зүйн тэнхмийн
багш, Хууль зүйн магистр

С.ГАНЦЭЦЭГ

Монгол Улс ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжин төрийн байгууллага, төрийн албаны тогтолцоо, үйл ажиллагааны зарчмыг дэлхийн жишигт нийцүүлэн цоо шинээр бий болгох шаардлагын үүднээс 1994 онд Төрийн албаны тухай хуулийг баталсан. Энэ хууль бол төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагч, тэр дундаа төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийг төрийн алба, төрийн жинхэнэ албаны онцлог, мөн чанарт тохируулж тусгайлан зохицуулсан анхны хууль юм. Улмаар тухайн хууль төрийн албыг улс төр, бизнесийн нөлөөнөөс ангид байж мэргэжлийн үндсэн дээр хаших боломжоор албан хаагчдыг хангах, төрийн жинхэнэ ба улс төрийн албан хаагчийн эрх зүйн статусын ялгаа заагийг тодорхой болгох, бусад хуультай нийцүүлэх шаардлагаар⁵⁵ 2002 онд шинэчлэгдэн батлагдсан. Өнөөг хүртэлх хугацаанд 178 удаа нэмэлт, өөрчлөлт орсноос үзвэл, тус хууль төрийн албан хаагчийн мөн чанар,

онцлогт хэр нийцтэй тогтоогдсон, практикт хэр оновчтой хэрэгжих бололцоотой байсныг зохих хэмжээгээр тодорхойлох юм. Хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүдийг бүхэлд нь буруу гэж үзээгүй бөгөөд зарим нэмэлт өөрчлөлт нь салбарын бусад хуулийн зохицуулалт өөрчлөгдсөнтэй холбоотой орсныг энд дурдах нь зөв юм. Гэхдээ чухам орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн алба, тэр дундаа төрийн жинхэнэ албаны хүрээнд тулгарч буй хэрэгцээ, шаардлагад хир тохирч байгаа нь огт өөр асуудал билээ.

1990-ээд оноос хойш Монголын нийгэм дэх хөдөлмөрийн харилцаанд асар их өөрчлөлт гарсныг судлаач, эрдэмтэд нилээд өргөн хүрээнд шинжлэн судалсан байдаг. Үүний нэг нь олон төрөл, хэлбэрийн хөдөлмөрийн харилцаа, мөн хөдөлмөр эрхлэлтийн олон хэв маяг үүссэн явдал юм.

Доктор, профессор Б.Уранцэцэг төрийн албаны хүрээнд төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлж хүн амд нийтийн үйлчилгээг

⁵⁵ Төрийн албаны тухай хуулийн хувийн хэрэг – I боть. УИХ-ын архив. ХН № 788, 89-90 дэх тал

үзүүлэхэд чиглэгдсэн албаны харилцаа, төрд алба хаших харилцаа гэсэн өөр хоорондоо нягт холбоотой ч ялгаа бүхий харилцаа үүсдэг гэж өөрийн бүтээлүүдэд цөөнгүй тэмдэглэжээ.⁵⁶

Нийгэмд төрийн үйлчилгээг үзүүлж хэрэгжүүлэхэд чиглэгдсэн албаны харилцаанд төрийн албан хаагч (төрийн өмнөөс) ба уг үйлчилгээг хүртэж буй субъект (хувь хүн, хуулийн этгээд) оролцдог бол харин төрийн алба хаших харилцаанд төрийн байгууллага, түүнийг төлөөлж зохих албан тушаалтан, төрийн албан хаагч оролцдог. Мөн дурдсан хоёр төрлийн харилцаа зорилго, мөн чанар, агуулгаараа ялгаатай. Иймд төрийн үйлчилгээг нийтэд хүргэх (төрийн албыг хэрэгжүүлж буй хэрэг юм) хүрээнд үүсэх албаны харилцаа нь захиргааны эрх зүйн хэм хэмжээгээр, харин уг албыг залгуулах субъект-төрийн албан хаагчдын төрд алба хаших харилцаа нь хөдөлмөрийн харилцаа нь хөдөлмөрийн эрх зүйгээр зохицуулагдана гэж тэрээр үзсэн байна.⁵⁶

Төрийн албан хаагчийн алба хаших харилцаа нь нийгэм дэх бусад төрлийн хөдөлмөрийн харилцаатай нийтлэг үндсэн шинжүүдийг агуулдаг ч бас өвөрмөц онцлогтой.

Үүний хамт төрийн алба дотроо хэд хэдэн төрлүүдээс бүрдэгтэй уялдан төрийн албан тушаал, улмаар төрийн албан хаагчид ч өөр өөр статустай юм.

56 Уранцэцэг.Б. “Төрийн захиргаа” онол, арга зүйн сэтгүүл, “Удирдахуйн онол практикийн асуудлууд” эрдэм шинжилгээний бичиг, Ажилтан, албан хаагчид ногдуулах хууль зүйн хариуцлага: Онол, хууль, практик, II дэвтэр зэрэг ном, өгүүлэлд энэ талаар дэлгэрэнгүй дурджээ.

57 Уранцэцэг.Б. Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн сургалтын гарын авлага УБ хот, 2012 он, 6 дахь талд

Эдгээр ялгаанаас хамаарч төрийн албан хаагчдын хөдөлмөрийн харилцааг тус тусын онцлогт нийцүүлж өөр өөр хууль тогтоомжоор зохицуулдаг. Төрийн жинхэнэ албан хаагчдын хөдөлмөрийн харилцааны үндсэн гол хэсгийг Төрийн албаны тухай хуулиар, үйлчилгээний албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг Хөдөлмөрийн тухай хуулиар тус зохицуулж байна. Гэхдээ төрийн алба хаших харилцаа нийгэм дэх хөдөлмөрийн харилцааны нэг хэсгийн хувьд нийтлэг зохицуулалт байх бөгөөд энэ нь Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-аар тогтоогддог. Гэхдээ “*төр*” гэсэн онцгой субъект оролцон түүний бүрэн эрхтэй холбоотой албыг залгуулдаг субъектын онцлогт тулгуурлан аль ч статусын төрийн албан хаагчийн алба хаших харилцаанд нийтлэг байх зохицуулалт бий. Энэ нь Төрийн албаны тухай хууль (2002 он)-аар тогтоогддог. Тэгвэл, төрийн албан хаагчдаас “*төрийн засаглах эрх мэдэл*”-тэй холбоотой албыг залгуулдаг төрийн жинхэнэ албан хаагчдын алба хаших харилцааны онцлогийг харгалзсан зохицуулалтууд Төрийн албаны тухай хууль (2002 он)-д дийлэнх байрыг эзэлдэг. Эдгээрээс үзвэл, төрийн алба хаших харилцаа хэд хэдэн хуулиар зохицуулагдаж байна. Энд тухайн албаны (Цагдаагийн албаны тухай хууль (2013 он)-ийн 33-39 дүгээр зүйл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль (2002 он)-ийн 132-136 дугаар зүйл гэх мэт) салбарын хууль ч бас хамаарна.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд авах талаар заасан. Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт “*Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд тухайн байгууллагад*

ажиллаж байгаа буюу төрийн холбогдох бусад байгууллагад ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчдаас үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр нь сонгон шалгаруулах замаар уг орон тоог нөхнө” гэж заасан. Энэ зохицуулалтаас үзвэл төрийн жинхэнэ албанд иргэнийг томилох сонгон шалгаруулалтыг төрийн жинхэнэ албан хаагчдын дунд зохион байгуулах, ийнхүү зохион байгуулахдаа:

а/ сул орон тоо гарсан тухайн төрийн байгууллага

б/ төрийн холбогдох бусад байгууллагын хүрээнд хэмээн хүрээг нь тодорхойлжээ. Гэтэл Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйл дэх зохицуулалтын агуулгыг харвал төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд сонгон шалгаруулалтад зохих шаардлага хангасан (Төрийн албаны тухай хуулийн 10.1, 33.5 дахь хэсэгт заасан шаардлага, 16 дугаар зүйлд заасан болзол) иргэн оролцох боломжтой. Түүнчлэн Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.5 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол ажил олгогч төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тооны талаар нийтэд мэдээлэх үүрэгтэй” гэж заасан. Энэ зохицуулалт нь зохих шаардлага шалгуур хангасан Монгол Улсын иргэн сонгон шалгаруулалтад орох боломжийг нээж өгсөн, нөгөө талаар нээж өгөх үүргийг ажил олгогчид үүрэг болгосон зохицуулалт юм. Харин Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэгт нь сонгон шалгаруулалтад төрийн жинхэнэ албан хаагчид л хамрагдахаар заасан нь ойлгомжгүй юм. Өөрөөр хэлбэл, төрийн жинхэнэ албаны сул орон тоонд шаардлага хангасан иргэнийг бус, харин төрийн жинхэнэ албан хаагч л томилогдох боломжтой мэт харагдаж байна. Энэ нь

эргээд Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэг дэх “Мэргэшлийн шалгаруулалтаар шалгарсан иргэнийг зохих албан тушаалд томилсон тухай төрийн холбогдох байгууллагын эрх бүхий албан тушаалтан шийдвэр гаргаж баталгаажуулна” гэсэн зохицуулалттай агуулгын хувьд зөрчилтэй ажээ. Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн зохицуулалтад буй бас нэг зөрчил нь сонгон шалгаруулалтыг сул орон тоо гарсан байгууллага дотор эсхүл төрийн холбогдох бусад байгууллагын хүрээнд зохион байгуулна гэж заасан нь эргэлзээтэй юм. Учир нь, сул орон тоо төрийн нэг л байгууллагад бий болно, гэтэл сул орон тоо бий болсон төрийн байгууллага сонгон шалгаруулалтыг төрийн бусад байгууллагын хүрээнд хэрхэн зохион байгуулах вэ? гэдэг нь зөрчилтэй бөгөөд хэрэгжих боломжгүй зохицуулалт болжээ.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.10 дахь хэсэгт “Энэ хуулийн 17.9 дэх хэсэгт заасан албан тушаалд ажиллаж байгаа этгээд төрийн жинхэнэ албаны өөр албан тушаалд шилжиж ажиллахад төрийн албаны мэргэшлийн шалгалт өгнө” гэжээ. Энд нэр томьёоны зөрчил ажиглагдана. Эндээс өөр албан тушаалд шилжин ажиллах хэмээх ойлголтыг тодруулах шаардлага гарна.

Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэхийн зорилго нь “төрийн зохих байгууллагад ажлын зайлшгүй шаардлага гарсан байх явдал” юм. Энэхүү ойлголт нь Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн агуулгаас ойлгомжтой.

Ажлын зайлшгүй шаардлага
гэдгийг доктор, профессор Б.Уранцэцэг

өөрийн бүтээлдээ "... ажил олгогчийн үйл ажиллагааг тасалдуулах, зогсоох сөрөг үр дагаварт хүргэж болохоор байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол гарах бодит нөхцөл байдал бий болсныг арилгаж, түүний хор уршгаас сэргийлэх мөн уг бодит нөхцөл байдал бий болсноор нэгэнт гарсан сөрөг үр дагаврыг даруй арилгаж хэвийн байдал тогтоох, түүнчлэн улс орон буюу бүс нутагт бий болох нь тодорхой болсон байгалийн гамшиг буюу үйлдвэрлэлийн ослын шалтгааныг арилгах, эдгээрийн эцэст бий болсон үр дагаврыг багасгах арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг хийхээс өөр аргагүй байдал"⁵⁸ гэж үзжээ. Төрийн албан хаагч өөр ажилд шилжих шалтгаан, үндэслэл нь ажлын зайлшгүй шаардлага байх бөгөөд энэ нь ажилтан, албан хаагчийн хүсэл зоригоос төдийлөн хамааралгүй үүсэх нөхцөл билээ.

Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх зохицуулалтыг үзэхэд үндэслэл нь ажлын зайлшгүй шаардлага бий болсон байх, төрийн жинхэнэ албан хаагчтай харилцан тохиролцох, төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллага руу шилжүүлэх гэсэн агуулга илэрнэ. Эндээс үзвэл, ажлын зайлшгүй шаардлагаар төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэхэд алба хашиж буй төрийн байгууллагад түүний хөдөлмөрийн харилцаа дуусаж, улмаар шилжин очих байгууллагад шинээр үүсэх шинж үүснэ.

Доктор, профессор Б.Уранцэцэг "Хөдөлмөрийн маргаан заримдаа хууль тогтоомжоосоо үүдэлтэй үүсдэг" нийтлэлдээ: Өөр ажилд шилжүүлэх гэсэн ойлголт нь

албан хаагч буюу ажилтны хөдөлмөрийн харилцаа хуульд заасан үндэслэлээр түр өөрчлөгдөж байгаад эргэж хуучин байдалдаа орох гэсэн агуулгаар Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-д тусгагдсан. Гэтэл, өөр ажил, албан тушаалд шилжүүлэх зохицуулалт хэрэглэгдсэнээр төрийн жинхэнэ албан хаагчийн төрийн тухайн байгууллагын төрийн жинхэнэ албан тушаал дээр алба хаших харилцаа нь дуусгавар болж төрийн өөр байгууллагын төрийн өөр нэг жинхэнэ албан тушаалыг хаших шинэ харилцааг бий болгож байна (Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэг) гэж дүгнэн тайлбарласан.

Тэгэхээр, Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 17 дугаар зүйлийн 17.10 дахь хэсэгт заасан зохицуулалтын агуулга нь Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад тэнцэн гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн шүүгчийн албан тушаал эрхлэх, прокуророор ажиллаж буй иргэн төрийн өөр албан тушаал хаших бол төрийн албаны мэргэшлийн шалгалт өгнө гэдгийг илэрхийлнэ.

Төрийн албаны тухай хууль (2002 он) дахь төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулсан зохицуулалт оновчтой бус, уялдаагүй, бусад хуулийн зохицуулалттай зөрчилдөх нь олонтаа байгаагаас түүнд орж буй зарим нэг нэмэлт өөрчлөлт нь зөрчлийг улам нэмэгдүүлж байна.

Эндээс үзвэл, төрийн албан хаагчид үүсч болох нэг тохиолдлыг дээрх хоёр хуульд гурван өөр хэлбэрээр зохицуулсан нь өөр хоорондоо зөрчилдөж байна.

58 Уранцэцэг.Б. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль (Онол арга зүйн тайлбар) УБ хот, 2001 он, 70 дахь талд

Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)	Төрийн албаны тухай хууль (2002 он)	Төрийн албаны тухай хууль (2002 он)
<p>35 дугаар зүйл. Ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг хэвээр хадгалах</p> <p>35.1. Ажил, үүргээ гүйцэтгээгүй үед ажил, албан тушаалыг дараахь тохиолдолд хэвээр хадгална:</p> <p>35.1.8. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан. /Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/</p>	<p>22 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах</p> <p>22.5. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалах арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно. /Энэ хэсгийг 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/</p>	<p>23.3. Төрийн жинхэнэ албан хаагчийг дараахь үндэслэлээр захиргааны санаачилагаар төрийн албанаас түр чөлөөлнө:</p> <p>23.3.4. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан. /Энэ заалтыг 2013 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн/</p>

Гэмт хэрэг хянан шийдвэрлэх явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх зорилго бүхий Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг Улсын Их Хурлаас 2013 онд батлан мөрдөж эхэлсэн. Энэ хуульд гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээг аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээ ба сэтгэл зүйн хамгаалалтын арга хэмжээ гэсэн хоёр төрөлд хуваажээ.

Төрийн жинхэнэ албан хаагч гэрч, хохирогч болсон үед ямар тохиолдолд төрийн албыг хаших боломжгүй болох вэ? гэдэг асуудал гарна.

Аюулгүй байдлын хамгаалалтын хүрээнд гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах, нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авсан үед хэрэв гэрч, хохирогч нь төрийн жинхэнэ албан хаагч байгаа бол албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болно. Гэтэл нэг л тохиолдолд:

- Хөдөлмөрийн тухай хууль (1999

он)-ийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалтад зааснаар ажил, албан тушаалыг нь хадгалах;

- Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт зааснаар өөр ажилд шилжүүлэх;
- Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 23 дугаар зүйлийн 23.4.3 дахь заалтад зааснаар төрийн алба хаших харилцааг дуусгавар болгох гэсэн гурван өөр төрөлийг хэрэглэж болохоор оруулсан нь оновчгүй болжээ.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт “Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалах арга хэмжээнд хамрагдсан албан хаагчийг түүнтэй тохиролцож төрийн нэг байгууллагаас нөгөө байгууллагад өөр албан тушаалд шилжүүлэн ажиллуулж болно” гэжээ. Төрийн жинхэнэ албан хаагч гэрч, хохирогч болсон тохиолдолд түүний аюулгүй байдлыг хамгаалах арга хэмжээ нь ямар хэлбэртэй тохиолдолд түүнийг

шилжүүлэх, тухайн төрийн жинхэнэ албан хаагч хамгаалалтын арга хэмжээ арилсан үед хуучин албан тушаалаа үргэлжлүүлэн хаших боломжтой эсэх нь тодорхойгүй зохицуулалт болжээ⁵⁹.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт төрийн жинхэнэ албан хаагчийг захиргааны санаачлагаар төрийн албанаас түр чөлөөлөх гэж заасан. Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 23 дугаар зүйлийн 23.3 дахь хэсэгт 2013 оны 07 дугаар сарын 05-ны өдөр “Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан” гэсэн заалт нэмэгдэж энэ тохиолдолд түр чөлөөлнө гэжээ. Гэтэл энэ нь Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 35 дугаар зүйлийн 35.1.8 дахь заалттай зөрчилдөж байна. Учир нь, Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 35 дугаар зүйлд ажилтны ажил, албан тушаалыг хадгалах талаар зааж, энэ зохицуулалт нь төрийн жинхэнэ албан хаагчид ч нэгэн адил хамаарна.

Ажилтны ажил албан тушаал хадгалагдах зохицуулалт нь практикт өргөн хүрээгээр хэрэглэгддэг. Тодорхой ажил эрхэлж байгаа ажилтан өвдөх, өвчтэй хүн асрах, ээлжийн амралтаа эдлэх зэрэг бодит шалтгаанаар эрхэлж буй ажил, албан тушаалаасаа түр хөндийрэх шаардлага гарна. Харин энэ үед түүний хөдөлмөрийн гэрээний харилцаа нь ажилтныг эргэж ажлын байрандаа ирж үргэлжүүлэн ажиллах хүртэлх хугацаанд нь хэвээр хадгалагдах явдлыг ажил, албан тушаал хадгалагдах зохицуулалт гэнэ.⁶⁰

59 Доктор, профессор Уранцэцэг.Б “Өөр ажилд шилжүүлэх гэж албан хаагч буюу ажилтны хөдөлмөрийн харилцаа хуульд заасан үндэслэлээр түр өөрчлөгдөөд эргэж хуучин байдалдаа орох” гэж тайлбарласан.

60 Уранцэцэг.Б. Хөдөлмөрийн тухай Монгол Улсын хууль

Ажил, албан тушаал хадгалагдах зохицуулалтыг хэрэглэх үндэслэлүүдийг хуульд тусгагдсан үндэслэлүүд, талууд тохиролцож хэрэглэх үндэслэлүүд гэж ангилж болох юм. Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 35 дугаар зүйлд ажилтны ажил албан тушаалыг хадгалагдах үндэслэлүүд тусгагдсан. Эдгээр үндэслэлийн аль нэг нь ажилтны хувьд бодитой бий болсон бол ажил олгогч тал нь түүний ажил албан тушаалыг хадгалах үүрэгтэй болно. Харин уг зүйлд тусгагдаагүй боловч ажил албан тушаалаасаа түр хөндийрэхийг ажилтан хүссэн тохиолдолд түүний гаргаж буй үндэслэлийг хэрхэн хүлээн авах нь ажил олгогч талын эрхэд хамаарах юм. Харин ажил, албан тушаал нь хадгалагдах хугацаанд ажилтны хөдөлмөрийн гэрээг ажил олгогч санаачлан цуцлах эрхгүй. Ажил, албан тушаал хадгалагдах хугацаа дууссан буюу хадгалах шалтгаан нь арилж (өвчилсөн ажилтан эдгэх гэх мэт) ажилдаа эргэн ирэх үед түүнийг ажиллуулах (хадгалагдсан ажил, албан тушаалд нь) үүргийг ажил олгогч хүлээдэг.⁶¹ “Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан бол ажилтан албан хаагчийн ажил, албан тушаалыг Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 35 дугаар зүйлд зааснаар хадгалах үүрэг ажил олгогч төрийн байгууллагад үүснэ. Гэтэл төрийн жинхэнэ албан хаагч “Гэрч, хохирогчийг хамгаалах хуулийн дагуу хамгаалалтын арга хэмжээнд хамрагдсан бол ажлын байр хадгалагдахгүй хөдөлмөрийн харилцаа дуусахаар, улмаар энэ нь Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 35 дугаар зүйлтэй агуулгын хувьд зөрчилдөнө. Учир нь, Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь хэсэгт “Төрийн албан хаагчийн

(Онол арга зүйн тайлбар) УБ хот, 2001 он, 75 дахь талд
61 Уранцэцэг.Б. Хөдөлмөрийн эрх зүй хичээлийн сургалтын гарын авлага УБ хот, 2012 он, 57 дахь талд

хөдөлмөрийн харилцаатай холбоотой, энэ хуулиар зохицуулаагүй бусад асуудлыг Хөдөлмөрийн хуулиар зохицуулна” гэж заасан нь төрийн жинхэнэ албан хаагчийн ажил, албан тушаалыг хадгалахад Хөдөлмөрийн тухай хууль (1999 он)-ийн 35 дугаар зүйлийг баримтална гэсэн утгатай.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 23 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагчийг түр чөлөөлөх, чөлөөлөх тухай тус тусад нь зааж өгсөн.

Гэтэл Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 23.3 дахь хэсэгт түр чөлөөлөх гэж тусгайлан нэрлэсэн нь ийнхүү түр чөлөөлөгдсөн төрийн жинхэнэ албан хаагч чөлөөлөгдөх болсон шалтгаан арилаад (жишээ нь, эмчлүүлж сувилуулж дуусах, суралцаж бэлтгэгдээд дуусах зэрэг) эргэж ирвэл түүнийг төрийн жинхэнэ албан тушаалд нь буцааж авах үүргийг байгууллага хүлээдэг мэт ойлгогдоно. Улмаар төрийн албанаас чөлөөлөх (энэ нь бүрмөсөн чөлөөлөх бололтой), түр чөлөөлөх гэсэн хоёр зохицуулалтыг тус тусад ялган тусгасан нь ойлгомжгүй ажээ. Төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх гэж нэрлэгдсэнээрээ хоорондоо ялгаатай зохицуулалт мэт боловч төрийн жинхэнэ албан хаагч тодорхой албан тушаалд ажилд орсноор төрийн зохих байгууллагатай тогтоосон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болох хууль зүйн адил үр дагаврыг агуулна. Хууль тогтоомжид тусгагдсан ажил, албан тушаал хадгалах, ажил албанд авч ажиллуулах, ажил албан тушаалыг түдгэлзүүлэх, эгүүлэн тогтоох гэх мэт зохицуулалтын хэлбэр тус бүр өөр өөрийн зорилготой, хууль зүйн зохих үр дагавартай. Төрийн албанаас түр чөлөөлөх хэлбэрийн зохицуулалт нь “төрийн албанаас чөлөөлөх” хэлбэрийн зохицуулалтаасаа

агуулгын ялгаагүй, ямар зорилгоор хуульд тусгагдсан, хууль зүйн ямар үр дагаврыг албан хаагчид буй болгох нь тодорхойгүй байна.

Энэ бүхнээс үзвэл, гэрч, хохирогчийг хамгаалах хамгаалалтын арга хэмжээ нь ямар хэлбэртэй тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийг өөр ажилд шилжүүлэх, эсхүл албан тушаалыг хадгалах, алба хаших харилцааг дуусгавар болгох вэ? гэдэг нь тодорхой бус болж үүнээс үүдэн албан хаагчийн хууль ёсны эрх ашиг хохирох нөхцөл бүрдэх талтай. Өөрөөр хэлбэл, дээрх нэг тохиолдолд гурван өөр зохицуулалтыг хэрэглэх зааг ялгааг нарийвчлан зохицуулаагүйн улмаас ажил олгогч /төрийн байгууллагын удирдлага/ гурван өөр зохицуулалтыг өөрийн хүсэл зоригийн дагуу хэрэглэх, ингэснээр төрийн жинхэнэ албан хаагчийг хохироох тал ажиглагдах магадлалтай. Угтаа төрийн жинхэнэ албан хаагч гэрч хохирогч болно гэдэг нь гэмт хэрэгтэн бус, эрх нь зөрчигдсэн этгээд /хохирогч/, эсхүл гэмт хэргийг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээ баримт өгөх этгээд /гэрч/ болж байгаа хэрэг билээ.

Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 26 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл, шийтгэлийн хэлбэрийг бүхэлд нь заасан. Гэтэл хуулийн 25 дугаар зүйлд төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас халах үндэслэлийг заахдаа уг зүйлийн 25.1.1 дэх заалтад “Хуульд өөрөөр заагаагүй бол удаа дараа /2 ба түүнээс дээш/ албан үүргээ хангалтгүй биелүүлсэн бол” төрийн албанаас хална гэж заасан. Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 25 дугаар зүйлд заасан “халах” гэдэг нь сахилгын шийтгэлийн хэлбэр бус, харин албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлэх гэдэг нь

сахилгын зөрчил болж хоорондоо уялдахгүй байна.

Төрийн албан хаагч албан үүргээ биелүүлэх гэдэг нь төрийн албаны холбогдох хууль тогтоомж болон ажлын байрны тодорхойлолтод тусгагдсан албаны ажил үүргийг бүгдийг, эдгээр хэм хэмжээгээр тогтоосон горим журмын дагуу, түүнд яв цав нийцүүлж гүйцэтгэж хангах явдал юм. Албан ажил үүргийг бүгдийг нь бус, заримыг нь гүйцэтгэх, тогтоогдсон горим журмыг бүхэлд нь баримтлаагүй, заримыг нь хангах явдал практикт цөөнгүй. Эндээс төрийн албан хаагч албан үүргээ хангалтгүй биелүүлж байна гэсэн ойлголт бий болох юм.⁶²

Гэтэл сахилгын зөрчил гаргасан бол ногдуулах сахилгын шийтгэлийн хэлбэрийн талаар Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 26 дугаар зүйлд тусгайлан заасан билээ. Үүнээс үүдэн сахилгын зөрчил, түүнд хүлээлгэх шийтгэлийг тус тусад нь зүйл заалтад багтаасан нь хоорондоо шүтэлцэхгүй болно.

Мөн Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 24 дүгээр зүйлд төрийн жинхэнэ албан хаагч төрийн албанаас чөлөөлөгдөх үндэслэлийн талаар заасан. Энэ зүйлд төрийн жинхэнэ албан хаагчийг төрийн албанаас чөлөөлөх гурван үндэслэлийг зааж хэрэв эдгээр гурван үндэслэлийн аль нэг чөлөөлөгдсөн бол төрийн албан хаагчийн нөөцөд байгаад үл тооцогдоно. Мөн хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 ба 25.1.3 дахь заалтад заасан төрийн албанаас халах үндэслэлийн үр дагавар нь 24 дүгээр зүйлтэй ижил буюу төрийн албанаас халагдсан бол төрийн албан хаагчийн нөөцөд багтахгүй. Эндээс үзвэл, Төрийн албаны тухай хууль (2002 он)-ийн 24 ба 25 дугаар зүйлийн хооронд үр дагаврын ялгаа огт гарахгүй байна.

Энэ мэтчилэн төрийн жинхэнэ албан хаагчийн хөдөлмөрийн харилцааг зохицуулахаар Төрийн албаны тухай хууль (2002 он)-д тусгагдсан зарим зүйл заалтад агуулгын болоод нэр томъёоны учир дутагдалтай зүйлс ажиглагдаж байна.

62 Уранцэцэг.Б. Ажилтан, албан хаагчид ногдуулах хууль зүйн хариуцлага: Онол, хууль, практик, II дэвтэр, УБ хот, 2005 он, 229 дэх талд

ХҮНИЙ ЭРХ БА НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ



Монгол Улсын Хүний эрхийн
Үндэсний Комиссын Ахлах референт,
Хууль зүйн магистр

З.ӨНӨРЖАРГАЛ

Аливаа улс орны төр бусдын туслалцаагүйгээр бие даан амьдрах бололцоогүй ахмад настан, өнчин хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон ядуу дорой амьдралтай хэсэг бүлгийн өдөр тутмын наад захын хэрэгцээг хангах болон амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд туслах зорилгоор нийгмийн халамжийн бодлогыг хэрэгжүүлдэг.

Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг⁶³ бүрдүүлэхдээ нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээг шаардлагатай эмзэг хэсэгт хүргэх, үр ашигтай хэлбэрээр хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Ялангуяа нийгмийн халамжийг дэмжлэг туслалцааг зайлшгүй шаардлагатай хэсэгт чиглүүлэх, зорилтот бүлгийг оновчтой тодорхойлох,

үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх болон түүнд тавих хяналтыг сайжруулах, хөгжлийн бодлоготой уялдуулах нь чухал билээ.

Нийгмийн халамжид шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төр хариуцдаг учир нийгмийн халамжийн бодлого стратегийг зөв явуулаагүйгээс гарах үр дагавар нь улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлдөг тул нийгмийн халамжийн санхүүжилт, түүний зарцуулалт нь улсын төсвийн бусад зарцуулалтын нэгэн адил чухал байдаг.

Нийгмийн халамж нь ядуурлыг бууруулахад чиглэсэн стратегийн нэг хэсэг бөгөөд нийгмийн даатгал, эрүүл мэнд, боловсрол, санхүү, нийтийн үйлчилгээ, зам тээвэр, болон ядуурлыг бууруулах, эрсдэлийг багасгах бусад бодлогуудад нөлөөлж, тэдэнтэй харилцан уялдаатай хэрэгждэг.

Нийгмийн халамжийн бодлого хөтөлбөрүүд нь хөгжлийн бодлогод дараах

63 Монгол Улсын Үндсэн хууль (1992)-ийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх заалт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна."

үүргийг гүйцэтгэдэг. Үүнд:⁶⁴

- Нийгмийн халамж нь хүн амын эмзэг болон нэн ядуу хэсэгт орлогыг дахин хуваарилах замаар ядуурал, тэгш бус байдлыг арилгахад шууд нөлөө үзүүлдэг. Ихэнх улс орнууд нийгмийн ядуу хэсэгт шаардлагатай үед туслах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч хэрэгжүүлж буй арга зам нь өөр өөр байдаг.
- Нийгмийн халамж нь өрх гэр бүлд ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийх боломжийг олгодог. Энэ үүргийнхээ хүрээнд нийгмийн халамж нь санхүүгийн зах зээлээс авч чадахгүй байгаа боломжийг орлож, хүүхдүүдийнхээ ирээдүй болон өрхийн амьжиргаандаа хөрөнгө оруулахад нь тусалдаг.
- Нийгмийн халамж нь өрх гэр бүлийг эрсдлээс хамгаалдаг. Нийгмийн халамж нь өрх гэрийн амьжиргааны үндэс болсон гэр орон, аж ахуйгаа хүнд хэцүү цагт авч үлдэх, хүүхдүүдээ сургуульд хамруулах, тэжээн тэтгэх зэрэгт тусламж болдог. Түүнчлэн өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд шаардлагатай сонголт хийх боломжийг олгодог. Үүгээрээ нийгмийн халамж нь өрх гэрийг эрсдлээс хамгаалан, тэдний бие даасан байдлыг дэмжиж байдаг.
- Нийгмийн халамж нь үр өгөөж, өсөлтийг дэмжин ажиллах боломжийг Засгийн газарт олгодог. Нийгмийн халамжийн зохистой, тогтвортой тогтолцоо нь нийгэмд шаардлагатай байгаа дахин хуваарилалтыг хийснээр бусад салбарыг энэ үүргээс чөлөөлдөг.

64 Маргарет Грош, Карло дел Нинно нар. Нийгмийн халамжийн үр дүнтэй тогтолцоо, (Дэлхийн Банкнаас 2008 онд англи хэл дээр хэвлэсэн), УБ, (Адмон компани), 2011, 1 болон 2 дахь тал

Иймээс нийгмийн халамжийн бодлогыг хөрөнгө санхүү, удирдлага зохион байгуулалтын хувьд зохистой, сөрөг урамшуулал (бэлэнчлэх сэтгэлгээ) бий болгохгүй байхаар шийдвэрлэхэд анхаарах хэрэгтэй байдаг.

Нийгмийн халамж аль ч улс орнуудын хөгжлийн бодлогод чухал үүрэг гүйцэтгэдэгийн адил манай улсын хувьд сүүлийн 20 жилд энэхүү үүрэг улам бүр өсөн нэмэгдэж байна.

Монгол Улсад Нийгмийн халамжийн анхны багц хууль 1995 онд батлагдсанаар төрөөс зайлшгүй дэмжлэг тусалцаа үзүүлбэл зохих иргэдийн ажилгүйдэх, өвчлөх, тахир дутуу болох, бэлэвсрэх, өтлөх, эсхүл өөрөөс үл хамаарах бусад шалтгаанаар амь зуулгагүй болох нөхцөлд тэтгэмж авах эрхийг⁶⁵ хангаж, хамгаалах нийгмийн халамжийн тогтолцооны шинэ үеийн түүх буюу олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх алхамуудыг хийсэн байна.

Ингэснээр Монгол Улсад нийгмийн даатгалын болон нийгмийн халамжийн нилээд орчин үеийн, зах зээлийн зүй тогтолд илүү нийцтэй тогтолцоо бий болж эхэлсэн гэж үзэж болно. Энэхүү нийгмийн халамжийн шинэчилсэн тогтолцоо нь нийгмийн нэн эмзэг хэсгийг хамгаалж, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өнчин хүүхэд, ядууралд өртсөн өрхийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэж, 1995-2005 он хүртэл хугацаанд нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд тэтгэмж, тусламж, үйлчилгээ үзүүлж байв.

65 Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 1946 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 217/A/III тогтоолоор батлагдсан Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалын 25 дугаар зүйл

Харин 2005 оноос хүүхдийн мөнгө хөтөлбөр, 2006 оноос шинэ гэр бүл, шинэ төрсөн хүүхэд, “Эхийн алдар” одонтой эхийн тусламж, хүүхдийн хөгжлийн мөнгө зэрэг нийтлэг мөнгөн тусламжуудыг олгож эхэлснээр нийгмийн халамжид зарцуулах хөрөнгө их хэмжээгээр нэмэгдэж, хүүхэдтэй айл өрх бүр халамжид хамрагдах болсноор 2004 онд нийгмийн халамжийн арга хэмжээнд 23,1 тэрбум төгрөг зарцуулж байсан бол 2008 онд 218,6 тэрбум төгрөг болж, 2004 онд 378,7 мянган иргэн, 2008 онд 1,6 сая иргэн хамрагджээ. Нийт зарцуулсан хөрөнгийн 80 гаруй хувийг нийтлэг шинж чанартай мөнгөн тусламжид, 20 хүрэхгүй хувийг эмзэг бүлгийн иргэдэд зарцуулжээ.⁶⁶

Мөн 2008 онд Монгол Улсын баатар, хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийн тухай, Эх хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуулиуд шинээр батлагдан гарснаар нийгмийн халамжид зарцуулах хөрөнгийн хэмжээ бараг 10 дахин, хамрагдах хүний тоо 5 дахин нэмэгдсэн байна.

Нийгмийн халамжийн тухай хуульд 2000, 2008 онд тус тус нэмэлт өөрчлөлт оруулж, 1998, 2005 онд шинэчилсэн найруулга хийгдсэн хэдий ч халамжид хамруулах шалгуур, нөхцөл зэрэгт өөрчлөлт орж байжээ.

Энэхүү нөхцөл байдлаас үүдэн “нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, давхардлыг арилгах, өрхийн амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд бодитой нөлөө бүхий хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх, олон нийтэд түшиглэсэн

халамжийн үйлчилгээг дэмжих, салбарын хууль тогтоомжоор зохицуулагдаж байгаа нийгмийн халамжийн шинж чанартай олон төрлийн арга хэмжээ, хөтөлбөрийг нийгмийн халамжийн бодлогын эрх зүйн нэгдсэн зохицуулалтын хүрээнд шийдвэрлэх”⁶⁷ шаардлага тавигдсан байна.

2012 оны Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн хуулиар нийгмийн халамжийг хүртэх зорилтот бүлгийг тодорхойлох, халамжийн байгууллагын бүтэц, тогтолцоог оновчтой болгох, хяналт тавих үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр оруулсан өөрчлөлт нь төрөөс үзүүлж буй нийгмийн халамжийн үйлчилгээг боловсронгуй болгох, иргэний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад ач холбогдолтой болжээ.

Хуульд нийгмийн халамж, нийгмийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, бүтэн өнчин хүүхэд, өрх толгойлсон эх (эцэг) зэрэг нэр томъёоны тодорхойлолтыг шинэчлэн найруулж, нийгмийн халамжийн мөнгөн тэтгэмж, тусламжуудыг нэгтгэх замаар төрлийг цөөлөх, хөтөлбөрт суурилсан халамжийн үйлчилгээний төрөл хэлбэрийг өргөжүүлэх, хамрах хүрээг ядуу болон эмзэг хэсэгт түлхүү чиглүүлэхэд анхаарсан байна.

Мөн нийгмийн халамжийн үйл ажиллагаа нь **нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ** гэсэн 4 төрөлтэй байхаар хуульд тусгаж, боловсрол, эрүүл мэндийг дэмжих болон хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний хүрээнд зарим тусламж, дэмжлэгийг үргэлжлүүлэхийн зэрэгцээ шинэ төрлийн тусламжийг үйлчилгээний төрлийг

66 Г.Оюунцэцэг, Ч. Дагвадорж, Нийгмийн халамжийн удирдлага, онол, арга зүйн асуудлууд, УБ, 2003

67 Нийгмийн халамжийг сайжруулах талаар авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын 2009 оны 81 дүгээр тогтоол

бий болгосон байна. Тухайлбал нийгмийн халамжийн үйлчилгээг хүртэж чадахгүй байгаа бага орлоготой өрх, иргэд, орон гэргүй тэнэмэл амьдралтай иргэд, шилжих хөдөлгөөнд орсон, хорихоос суллагдсан иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээний төрөл хэлбэрийг илүү оновчтой болгох, олон талт үйлчилгээг үзүүлэх боломжтой болжээ.

Энэхүү хуульд заасан тэтгэвэр, тэтгэмжийг тогтоолох өргөдөл, гаргах шийдвэрлэх, хугацаа олгох, журам болон нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа нь өөрөө процессын шинжтэй харилцааг агуулдаг. Иймээс материаллаг хэм хэмжээнээс гадна процессын хэм хэмжээгээр илүү зохицуулагдах ёстой. Одоо үйлчилж байгаа хуулийн зохицуулалтаас үзэхэд 20 гаруй заалтын хүрээнд эрх бүхий байгууллага, албан тушаалтан нэмэлт дүрэм, журмуудыг боловсруулан баталж мөрдүүлэхээр тусгагдсан нь нэг талаас процессын хэм хэмжээгээр зохицуулагдах шинжтэй харилцаа болохыг илэрхийлэхийн зэрэгцээ нөгөө талаас тухайн харилцааг зохицуулах процессын хэм хэмжээ ихээхэн дутагдалтай тусгагдсан нь судалгаанаас харагдаж байна.⁶⁸

Дээрх дүрэм, журмаас үүдэн олон шат дамжлага бий болгох, шийдвэрлэх хугацааг тодорхойгүй, эсхүл өөр өөрөөр тогтоосон, мөн хуулийн зохицуулалтаас давсан босго, шалгуурыг тогтооход хүргэж байна. Үүнд иргэдийн бүрдүүлэх баримт бичгийн тоо, төрөл, байнгын асаргаанд байгаа иргэн асруулагчаа бүртгүүлэх, ахмад настнууд таяг, тэргэнцэр авахад тавьж буй шаардлага зэргийг дурдаж болно. Энэ нь иргэдэд ихээхэн чирэгдэл үүсгэж улмаар иргэний

халамж хүртэх эрхийг бодитой хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэх талтай. Нөгөө талаас төрийн үйлчилгээний хүртээмж чанарт доголдол гарч, хүнд суртал, чирэгдэл үүсэх улам нэмэгдэх сөрөг үр дагавартай.

Иймээс иргэний хэрэгцээнд суурилсан, хүртээмжтэй, чанартай шуурхай, ил тод байдлыг хангасан үйлчилгээний эрх зүйн орчинг бүрдүүлэхийн олон дүрэм журмын зохицуулалтыг багасгаж, хуулиар нэг мөр журамлан зохицуулах нь зүйтэй.

Процессын хэм хэмжээ нь материаллаг хуулийг хэрэгжүүлэх журам буюу процедурыг тогтоосон хэм хэмжээнээс бүрддэг хэдий ч энэхүү процессын, процедурын хэм хэмжээнүүд нь өөр хоорондоо шууд хамааралтайгаар тухайн харилцааг зохицуулж байгаа нь зохицуулалтын хийдэл, давхардал болон өөр хоорондын зөрчилдсөн байдлыг арилгах, хуулийн үйлчлэлийн үр нөлөөг дээшлүүлэх үүднээс нийгмийн халамжийн үйл ажиллагааг нэг мөр журамлан зохицуулсан процессын шинжтэй хэм хэмжээг хуульд тусгаж оруулах хэрэгтэй байна.

Төрийн үйлчилгээг иргэнд ойртуулж, үйлчлүүлэгчийнхээ хэрэгцээнд суурилсан чанартай үйлчилгээг өртөг багатай, хүнд суртал, олон шат дамжлагагүй, түргэн шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлж, үйлчлүүлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, ингэхдээ үйлчилгээний чанар, хүртээмжийг иргэдийн сэтгэл ханамжид нийцүүлэн сайжруулж, хөгжлийн үр шимийг иргэн бүрт хүргэх, тэр дундаа өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эмэгтэйчүүд, ядуу иргэдэд чиглүүлэх ёстой.

68 “Хүний эрх ба хүнд суртал, чирэгдэл” судалгааны тайлан, 2012, ХЭҮК, “Карьер хөгжлийн хүрээлэн” ТББ

Гэтэл судалгаагаар⁶⁹ “Үйлчилгээ авах хугацаа”, “бүрдүүлэх баримт бичиг”, “төрийн албан хаагчдын зан харилцаа”, “үйлчилгээний стандарт”-тай холбоотой асуудлаар нарийвчилсан зохицуулалтгүй, дүрэм, журмууд зохицуулах ёстой харилцааг бүрэн зохицуулж чадахгүй байгаа нь илэрсэн. Иргэдийн нийгмийн халамж авах нэг гол үндэс болж буй хөдөлмөрийн чадвараа алдсан байдлыг тогтоох, эрүүл мэндийн байгууллагын мэргэжлийн эмч нарын хяналтын комисс, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисстой холбоотой зохицуулалтууд тодорхой бус байгаа нь тухайн салбарт төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг бий болгох, иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчих нэг шалтгаан болж байна.

Түүнчлэн Засгийн газрын 2010 оны 288 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрэм, Нийгмийн халамжийн тухай хууль⁷⁰, байгууллагын дотоод журамд, нийгмийн ажилтны үүрэг хариуцлагын хүрээнд ёс зүйн шаардлагыг тусгасан байгаа боловч хэрэгжилт нь хангалтгүй байна. Тухайлбал нийгмийн халамжийн ажилтнууд зан харилцаа, үйл ажиллагаагаар иргэдийн хувийн нууцыг санаатай, санамсаргүйгээр задлах, хүний эрхэм зэргийг үл хүндэтгэх зэргээр илэрч байна.

Иймээс нийгмийн халамжийн эрх зүйн зохицуулалтыг хүний эрхэд суурилсан хандлагад нийцүүлэн өөрчлөх,

69 “Хүний эрх ба хүнд суртал, чирэгдэл” судалгааны тайлан, 2012, ХЭҮК, “Карьер хөгжлийн хүрээлэн” ТББ
70 “Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйн дүрэмтэй байна” Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь заалт, “Нийгмийн ажилтан нь мэргэжлийн ёс зүйг чандлан сахиж, ажил, үйлчилгээ явуулах эрхийн гэрчилгээ болон хувийн тэмдэг авсан байна” Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.3 дахь заалт

нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дараах асуудлуудад анхаарах шаардлагатай байна. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн хуульд **“нийгмийн халамж”** гэсэн ойлголтыг **эрүүл мэндийн доройтолтой**, гэр бүлийн халамж, асрамж дутагдалтай, бие даан, эсхүл бусдын тусламжгүйгээр хэвийн амьдрах боломжгүй, **өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн**, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнд наад захын хэрэгцээг нь хангах зорилгоор улсаас тэтгэвэр, тэтгэмж олгох, тусгайлсан үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ гэж тодорхойлжээ.

Энэхүү **“эрүүл мэндийн доройтол”, “өвөрмөц хэрэгцээ бүхий иргэн”** гэсэн ойлголтуудыг хэрхэн ойлгож, хэрэглэх нь тодорхой бус байх тул тухайн иргэн нийгмийн халамжийн үйл ажиллагааны ямар төрөлд хамрагдах, тэдэнд үзүүлэх үйлчилгээг тодорхойлох боломжгүй юм. Иймд хуулийн зарим нэр томъёог нэг мөр болгож, тодорхойлох нь зүйтэй байна.

2. Нийгмийн халамжийн үйлчилгээ нь тухайн субъектын онцлог, үйлчилгээ авах болсон хэрэгцээ шаардлагатай уялдсан, түүнд суурилсан байж илүү үр дүнтэй болно. Энэ нь хуулийн үйлчлэлийн үр нөлөөг дээшлүүлэхэд ач холбогдолтой тул халамж үйлчилгээний нэр төрлийг тодорхой болгон өөрчлөх, шинээр тусгах бусад хуулиудтай уялдуулж түүний зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай юм.

Тухайлбал Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.4-т **“Хүчирхийлэлд өртсөн иргэн”** олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдахаар тусгагдсан боловч аль үйлчилгээнд хамрагдах нь тодорхойгүй, үзүүлэх үйлчилгээ нь цогц бус төрөлжөөгүй, хохирогчийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх үйлчилгээ, дэмжлэгийн талаарх зохицуулалт тодорхой бус, энэ хууль болон Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд хохирогч болон түүний гэр бүлийн гишүүдийн эрх ашиг, сонирхлыг хамгаалах үүднээс **“Гэр бүлд нь эргэн нэгтгэх”**, мөн **“Хохирогчийг түр хамгаалан байрлуулах”**, **“Нэг цэгийн үйлчилгээ”**, **“Эмнэлгийн тусламж үйлчилгээ”** г.м үйлчилгээг тусгаж, тэдгээр үйлчилгээний журмыг нэг мөр зохицуулах хэлбэрээр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй байна.

3. Хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2-т заасан **“хөгжлийн бэрхшээлтэй иргэн”**, мөн 18.2.3-т заасан **“хүнд нөхцөлд байгаа хүүхэд”** олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа боловч үзүүлэх үйлчилгээ, түүний журмыг боловсронгуй болгох шаардлагатай. Монгол Улс 2008 онд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийг соёрхон баталсан. Конвенцийн 25 дугаар зүйлийн б-д **“хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг эрт оношлох, зохих үед таслан зогсоох буюу багасгахад чиглэсэн болон хүүхдүүд, ахмадуудыг цаашид хөгжлийн бэрхшээлтэй болохоос урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамруулах”** талаар улс орнууд бүхий л зохистой арга хэмжээ авах тухай заасан тул энэхүү конвенцийн

заалттай нийцүүлэн холбогдох хуулиудад энэ төрлийн үйлчилгээг нэмж оруулах шаардлагатай.

4. Түүнчлэн хуулийн 18.2.3-т заасан хүнд нөхцөлд байгаа хүүхдэд үзүүлэх үйлчилгээ гэсэн ерөнхий зохицуулалтыг боловсронгуй болгох үүднээс Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд **“Хүүхэд хамгааллын үйлчилгээ”** гэсэн зохицуулалтыг шинээр тусгах нь энэ төрлийн үйлчилгээний зохицуулалт илүү тодорхой болсноор холбогдох хуулиудын өөр хоорондын зохицуулалт уялдаж, улмаар хуулийн үйлчлэлийн үр нөлөөнд ач холбогдолтой юм.
5. Төрийн чиг үүргийг шилжүүлэх, гэрээлэх, түншлэлийн олон талт хэлбэрийг бий болгох үүднээс төрийн зарим үйлчилгээний чиг үүргийг хувийн хэвшлийн болон иргэний нийгмийн байгууллагуудад шилжүүлж, гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлыг хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд эрх бүхий албан тушаалтаны баталсан журмын дагуу шийдвэрлэж байна.

Тухайлбал Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн хуулийн 18.7 дахь хэсэгт **“Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ үзүүлэх иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагатай хийх гэрээний загвар болон үйлчилгээнд хамрагдах иргэний тоо, шаардагдах хөрөнгийн хэмжээг тодорхойлох аргачлал, зааврыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална”** гэж заажээ. Гэтэл олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ гэрээлэн гүйцэтгэгчдийн хувьд уг үйлчилгээг авах

шаардлагатай нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн мэдээлэл олддоггүй, энэ талаар холбогдох төрийн байгууллагатай хамтран ажиллах эрх зүйн зохицуулалт байхгүй, төрөөс олгож буй санхүүжилт хангалттай биш, хууль журмын өөрчлөлт, тендэрийн ажиллагаатай холбоотойгоор тэдний үйл ажиллагааг тодорхойгүй хугацаагаар зогсоодог зэрэг бэрхшээлтэй тулгардаг байна.⁷¹

Иймээс хүний эрхэд суурилсан хөгжлийн чиг хандлагыг бий болгож, иргэнд үйлчлэх, үйлчлүүлэгчийг хамгаалах, иргэдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн чанартай үйлчилгээг хүргэх, үйлчилгээний байгууллагаа сонгож үйлчлүүлэх иргэний эрхийг хамгаалах зорилгоор Төрийн үйлчилгээг хувийн хэвшлээр гэрээлүүлэн гүйцэтгүүлэх тухай бие даасан хуультай болох нь зүйтэй юм.

6. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенцийн 9 дүгээр зүйлд “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна” гэж заажээ.

71 “Олон Нийтийн Санал Клуб” ТББ, “Иргэдийн хэрэгцээнд нийцсэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний нэр төрлийг тодорхойлох, гэрээлэх үйлчилгээний механизмыг сайжруулах судалгаа” УБ, 2013

Мөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй орчин бий болгохдоо нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан объект, үйлчилгээг хүртээмжтэй байлгахад чиглэсэн наад захын стандарт, гарын авлагыг боловсруулж мөрдүүлэх, нийтэд нээлттэй үйлчлэх байшин барилга, бусад байгууламжид брайль үсгээр буюу хялбар уншигдах, ойлгогдохуйц байдлаар тэмдэг, тэмдэглэгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүлээн авах хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дэмжлэг, туслалцаа үзүүлэх зохих хэлбэрийг хөхиүлэн дэмжих, ингэхдээ хүний туслалцаа, зуучлалын хэлбэрүүд, тухайлбал хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагчийг бий болгох, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, үүний дотор интернэтийг хэрэглэх боломжийг нэмэгдүүлэхийг конвенцид заасан байдаг.

Нийгмийн халамжийн үйлчилгээний нэг зорилтот бүлэг нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс юм. Эдгээр хүмүүс нийгмийн халамжийн үйлчилгээг өөрсдөө биечлэн очиж хүртэх нөхцөлөөр хязгаарлагдмал, байгаа нь манай улсад энэхүү тусгай хэрэгцээт бүлгийн онцлогт нийцсэн үйлчилгээний орчны хүртээмж бүрдээгүй, мэдээлэл, солилцох харилцах харилцааны болон үйлчилгээний стандарт байхгүйтэй холбоотой. Иймд нийгмийн халамжийн байгууллагын үйл ажиллагаанд тусгай хэрэгцээт бүлгийн онцлогт нийцсэн орчны хүртээмж, үйлчилгээний, мэдээлэл солилцох харилцааны стандартыг цогцоор нь шийдвэрлэж, шинээр нэвтрүүлэх шаардлагатай.

Стандартыг боловсруулахдаа дараах зарчмуудыг харгалзахыг санал болгож байна.

Үүнд⁷²:

- **Нэгэн утгатай хэрэглэх нөхцөлийг хангах:** Хууль тогтоомжид иш татсан стандарт заавал мөрдөгдөх учиртай бөгөөд ялангуяа, Нийгмийн халамжийн тухай шинэчилсэн хуульд төрөлжсөн асрамжийн үйлчилгээний болон олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний чанарт тавигдах шалгуур, шаардлагыг боловсруулан хэрэгжүүлэхийг асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн болон стандартчиллын байгууллагад үүрэг болгосон байна.
- **Бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсруулагч, үйлдвэрлэгч, хэрэглэгчдийн сонирхлыг тэнцвэржүүлэх:** Энэхүү зарчим нь нийгмийн халамжийн үйлчилгээг авахтай холбогдож үүсэж буй харилцаанд оролцогч сонирхлын бүлгүүдийн хуулиар баталгаажсан сонирхлыг дээд зэргээр харгалзан үзэхэд оршино. Наад зах нь нийгмийн халамжийн үйлчилгээг авч буй иргэд, төрийг төлөөлөн ажиллаж буй мэргэжлийн бүлгүүд хэлэлцэж байгаа гол асуудлаар санал нэгдэж ерөнхий зөвшилцөлд хүрсэн байна гэсэн үг юм.
- **Стандартчиллын түрүүлэх хөгжлийг хангах:** Шинээр боловсруулж буй стандарт нийгмийн хөгжлөөс түрүүлэх хандлагатай байх ёстой. Түрүүлэх хандлага стандартад

шинэ дэвшилтэт технологи, сорилт туршилтын арга, чанарын үзүүлэлт, шаардлагыг тогтоох боломж олгоно.

- **Стандартын агуулгыг тодорхой томъёолох:** Хоёрдмол утгатай хэм хэмжээ норматив баримт бичгийн ноцтой дутагдлыг харуулдаг. Иймд стандартыг нэг утгатай товч, тодорхой агуулгатайгаар боловсруулна.
- **Үзүүлэлт, шаардлагыг шалгах, хэмжих бодит байдал:** Стандарт нь харилцан орлуулалт, нийцтэй байдал, хүрээлэн буй орчин, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдлыг хангаж байгаа шаардлагыг оролцуулаад бодитой шалгагдах, стандартчиллын объектын үндсэн шаардлагуудыг тогтоох ёстой.
- **Стандартыг нэг хэлбэрээр хэрэглэх нөхцөлийг хангах:** Энэхүү зарчмыг байгууллагын стандарт боловсруулахад харгалзан үздэг. Байгууллагын стандартыг боловсруулах, батлах, бүртгэх, хүчингүй болгох, түүнд нэмэлт өөрчлөлт оруулах журмыг өөрсдөө бие дааж тогтоож хэрэгжүүлнэ. Ингэхдээ холбогдох хууль тогтоомж, улсын стандартыг мөрдлөг болгож түүний шаардлагуудад харшлахгүйгээр ханган биелүүлэхэд чиглэсэн стандартчиллын нийтлэг зарчмын дагуу нэгдсэн хэлбэр, бүтэц, агуулгатай байна.

72 Т.Сосорбарам, "Европын стандартыг Монголд нутагшуулах асуудал", УБ, 2011

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭНД АВЧ ҮЗЭХ НЬ



“Бүх нийт боловсролын төлөө!”
Иргэний нийгмийн үндэсний эвслийн
зохицуулагч, Боловсролын магистр

Д.ТУНГАЛАГ

Хүний эрх, ардчилал, хүмүүнлэг ёсыг Хүнэт зүйлсээ гэж дээдэлсэн нийгэм байгуулахыг зориод 20 гаруй жил өнгөрсөн ч НҮБ-ын Тусгай илтгэгчийн дүгнэснээр⁷³ дан ганц сургуулийн орчинд төдийгүй нийт Монгол Улсын хүн амын дунд хүний эрхийн соёлыг жинэхэнэ утгаар төлөвшөөгүй байгааг онцолсонтой санал нийлж байна.

Буруутгахаас илүүтэй учир шалтгааныг дүгнэн үзвээс ардчилсан нийгмийн эхний жилүүдэд нийгмийн өөрчлөлттэй уялдуулан насанд хүрсэн хүн амд чиглэсэн сургалт боловсролын үйл ажиллагаа явуулаагүй, Монгол хэл дээр хүний эрхийн талаарх зохиол бүтээл дутмаг, сургуулиудын хичээлийн хөтөлбөрт хүний эрхийг зарим нэг байдлаар тусгасан байх боловч тэдгээр нь тайлбарласан, өнгөц шинжтэй, нийгэм судлал, түүх, иргэний боловсрол гэсэн гурван хичээлээр л хүний эрхийн боловсрол хязгаарлагдагдсан, багш нарт системтэй сургалт зохион байгуулаагүй гээд дурдаж болно.

73 НҮБ-ын Сурч боловсрох эрх хариуцсан тусгай илтгэгч Вернор Мунозын тайлан, Монгол Улс дахь томилолт (2009 оны 10 дугаар сарын 1-8)

Олон соёлт ертөнц, зөвхөн Монгол Улсын биш дэлхийн иргэн байх, хүний нийгмийн шинэ хэлбэрийн эв нэгдэл, дэлхийн түвшний оролцоо, зөвхөн өнөөдрийн төлөө биш ирээдүйн төлөө хүлээх өсөн нэмэгдэж байгаа хариуцлагын тухай асуудлууд хүний эрхийн боловсролын хэрэгцээ шаардлагыг бий болгож байна. Энэ нь нийгэм, улс төр, соёл, эдийн засаг, байгаль орчны хүрээнд дэлхий нийтэд тулгамдаад байгаа асуудлыг ойлгох ба шийдвэрлэхтэй боловсрол ба сургалт холбоотой гэдгийг дэлхий даяараа хүлээн зөвшөөрсөнтэй холбоотой юм.

Боловсролын үүрэг мэдлэг олгох, танин мэдэхүйн чадвар эзэмшүүлэхээс даван гарч үнэт зүйлс, зөөлөн (зарим үед амьдрах ухааны ур чадварууд гэдэг) ур чадвар, хандлагыг төлөвшүүлэх чиг рүү хандаж, боловсрол нь олон улсын хамтын ажиллагаанд чиглүүлсэн, илүү шударга, тайван, хүлцэн тэвчдэг, бүгдийн тэгш оролцоот, аюулгүй, тогтвортой байх нийгмийн хувирал өөрчлөлтийг хөхиүлэн дэмжсэн байх ёстой гэж үзэж эхэллээ.

Боловсролын зорилго нь дан ганц мэдлэг, эсвэл зарим нэг ур чадвар биш хандлага, үнэт зүйлийг нэмэн багтаасан компетенц буюу цогц чадамжийг хүүхэд залуус насанд хүрэгчдэд эзэмшүүлэхэд чиглэх боллоо. Зарим нэгээс дурдвал:

- Хувь хүний ялгаатай байдлаас давж гарсан “хамтын айдентити”-ийн боломж, айдентитигийн олон түвшинг ойлгох байдлаар илрэх хандлага (хүн төрөлхтөнд харьяалагдах мэдрэмж, ялгаатай байдлыг хүндэтгэх гм)
- Дэлхий нийтэд тулгамдсан асуудлууд ба шударга ёс, тэгш эрх, эрхэм чанар, хүндэтгэл зэрэг түгээмэл үнэт зүйлсийн талаарх гүнзгий мэдлэг (даяарчлах үйл явц, тогтвортой хөгжил гм)
- Шүүмжлэлтэй, цогц, бүтээлчээр сэтгэх зэрэг асуудлын олон хэмжээс, ойрын ба хэтийн төлөв, олон талын хүлээн зөвшөөрөх байдлаар хандах танин мэдэхүйн ур чадварууд (учир шалтгааныг олох, асуудлыг шийдвэрлэх гм)
- Бусдын оронд өөрийгөө тавих, зөрчлийг шийдвэрлэх, харилцааны, ялгаатай байдал, гарал, соёл, төлөв бүхий хүмүүстэй харилцах, сүлжээ болж ажиллах зэрэг танин мэдэхүйн бус чадвар (эх дэлхийгээ хайрлах, эв нэгдлийн мэдрэмж гм),
- Хамтын сайн сайхны төлөө чармайх ба дэлхий нийтэд тулгамдаад байгаа сорилтод нийтийг хамарсан шийдэл олоход хариуцлагатайгаар хамтран ажиллах зан байдлын чадамж (шийдвэр гаргах)

Тэгэхээр хүний эрхийн боловсролыг сургалтын хөтөлбөрт интеграцчилан сургалтын агуулга, аргад шингээхгүй бол

дээр дурдсан цогц чадамжийг хүн бүр эзэмших боломжгүй юм. Гэхдээ зөвхөн сургалтын хөтөлбөр болон хичээлээс гадуурх зохиогдох ажил зэрэг албан боловсролын тогтолцоогоор биш албан бус байдлаар, амьдралын туршид суралцах боломжийг нээх, мэдээлэл харилцааны технологи ба нийгмийн сүлжээг ашиглан олгох боломжийг бүрэн дүүрэн ашиглах нь зүйтэй юм.

Гэхдээ боловсролын байгууллага гэдэг бол нийгэмшлийн хамгийн том институцийн хувьд хүүхдэд бага наснаас нь хүний эрхийн боловсрол олгох гол үүрэгтэй. Сургууль, цэцэрлэгт л хүн анх юуг бусдаас хүсэн хүлээх вэ, нийгэмд ямар хэм хэмжээ тогтсон байдаг, үнэт зүйлсүүдийн талаар, хүлээх үүргийн талаар, оршин байхын арга зам, хүсэл мөрөөдлийн эх сурвалж зэргийн талаар танин мэдэж, ойлгон зохицож, өөрт төлөвшүүлэх замаар нийгэмшиж эхэлдэг. Цаашилбал ухамсрын болон далд ухамсрын түвшинд сургууль болон бусад нийгмийн институцуудийн зүгээс үг болон үзэл санаанд бөмбөгдүүлж, тогтсон хэм хэмжээнд нийцэхгүй бол шийтгүүлж, нийцвэл шагнуулж, өөрөөр буюу өөрийнхөөр байвал ялгаварлан гадуурхагдаж, мэдлэг, туршлага хуримтлуулах замаар эрх мэдэлжих зэргээр нийгэмших үйл явц⁷⁴ өрнөнө. Багш болон бусдын хэл яриа, үйлдэл, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагаа, дууны үг, шүлэг, үлгэр, зүйр цэцэн үг, сургалтын арга, үнэлгээ, сургуулийн соёл, сургуулийн материаллаг орчин, сургуулийн удирдлага, засаглал зэргээр дамжин нийгэмших үйл явц тасралтгүй үргэлжилнэ.

Тэгэхээр хүн ийм эрхтэй, тийм эрхтэй эсвэл тийм нэртэй, гэдэн конвенц байна гэдэг жагсаалт ярихын зэрэгцээ, өөрөөр

74 Cycle of Socialization developed by B.Harro, 2000

хэлбэл хүний эрхийн хэм хэмжээ, зарчим, тэдгээрийн суурь болсон үнэт зүйлсийн цогц ба хамгаалах механизмуудын талаарх мэдлэг ойлголт өгөхийг зорьдог хүний эрхийн тухай боловсрол олгохын (I) зэрэгцээ багш ба суралцагчдын хүний эрхийг хүндэтгэсэн байдлаар боловсрол, сургалтын үйл явц өрнөх хүний эрхийг дээдэлсэн боловсрол (II), бүр цаашилбал хүнийг өөрийн эрхээ эдлэх, хэрэгжүүлэх болон бусдын эрхийг хүндэтгэх ба хамгаалах талаар эрх мэдэлжүүлэх⁷⁵ хүний эрхийн төлөөх боловсролыг олгох (III)⁷⁶ тухай ярих шаардлага туйлын хурц байна.

Сургуулиудын хүний эрхийн боловсрол олгож буй хөтөлбөр, сурах бичигт дүн шинжилгээ хийж үзэхэд хүний эрхийн түүх, философи, бие даасан үнэт зүйл болох тухай, ёс зүй, ёс суртахууны бусад үнэт зүйлстэй хэрхэн холбогдох тухай, ардчилал, энхтайван, эдийн засаг, нийгмийн хөгжил, даяарчлалын үйл явцын хүрээнд холбож авч үзээгүй байх зэрэг агуулгын дутмагшил илт харагддаг. ХЭТТ ба Хүүхдийн Эрхийн Конвенц зэрэг хүний эрхийн баримт бичгүүдийн заалтыг сургуулийн амьдрал, хүүхдийн туршлагад холбон ойртуулахгүй, хүний эрхийн зарчмуудыг гүнзгийрүүлэн таниулахгүй, өнөө үед явагдаж буй эрх чөлөө, тэгш эрх, шударга ёсны тэмцэлтэй холбохгүй байгаа⁷⁷ нь хүний эрхийн боловсролын чанарт сөрөг нөлөө үзүүлж байна.

Анги танхимд явагдаж байгаа сургалтын чанар бидний хүссэн хэмжээнд хүртэл өөрчлөгдөхгүй байгаагийн цаад учир шалтгааныг хайх эрлийн замд боловсролын салбарт хүүхдийн эрх, хүний эрхийн талаар

нэг л ташаа ойлголт, мэдлэг, хандлага яваад байгаа нь анзаарагдлаа. Тиймээс хүний эрх, эрх чөлөөг дур зорготой андуурах, барууны соёлын нэг хэсэг гэж үзэх, манай уламжлал заншилтэй зөрчилдөх юм шиг, эрх хэтэрдэг мэт, эрхийг заавал үүрэг дагалдах ёстой зэрэг тогтсон зарим нэг гажуудсан ойлголтуудыг засах нь хүний эрхийн боловсролын хүрээнд хийгдэх ёстой эн тэргүүний ажил байна.

Боловсролын үүрэг, зорилго ч өөрчлөгдөн академик мэдлэг дамжуулдаг байдлаасаа хүүхэд залуучуудыг ямар байх нь ч тодорхой биш маргаашийн дэлхий ертөнцөд амьдрахад бэлтгэх, хүний ёсоор оршин байх, бусадтай энэ дэлхий ертөнцөд харилцан ойлголцон, хүлцэн тэвчиж хамтран амьдрахад сургах, үүнд хэрэгтэй мэдлэг, ур чадвар, хандлага, үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чиглэж байна. Нийгэм ч өөрчлөгдөж, ардчилсан нийгмийн үнэт зүйлс, тулгуур баганы нэг нь иргэдийн оролцоо болсон үед хүүхэд залуус хүний эрхийн мэдрэмжтэй, хүний эрхэд суурилсан байдлаар асуудалд ханддаг, шийдвэр гаргадаг байх, аливаа зүйлд шүүмжлэлтэй, бүтээлч байдлаар ханддаг, өөрийн үзэл бодолтой, задлан шинжлэх, шүүн тунгаах чадвартай байж, нийгмийн шударга ёс, тэгш эрх, хүний эрх, эрх чөлөөг хангах чиглэлд нийгмийн өөрчлөлт хийх эрмэлзлэл бүхий иргэн болж төлөвших эрэлт хэрэгцээ байна.

НҮБ-ын Тусгай илтгэгч мөн хүний эрхийн үүсээд байгаа нөхцөл байдалд сургалт, боловсролыг ойртуулах нь хүсээд байгаа нийгмийн өөрчлөлт буюу аливаа хэлбэрийн ялгаварлал, гадуурхал, ад шоо үзэх хэлбэр байхгүй нийгэмд дэвшиж, хүний эрхийн соёл хэрэгжихэд чухал ач холбогдолтой болохыг тэмдэглэж байгаа юм.

75 Эрх мэдэлжих-empowerment гэдэг үгийг орчуулан хэрэглэв.

76 Хүний эрхийн боловсролын дэлхийн хөтөлбөр, НҮБ, 2005

77 Дунд сургуульд хүний эрхийн боловсрол олгох удирдамж, 2011

Дээр дурдсан 2 дахь санаа буюу багш ба суралцагчдын хүний эрхийг хүндэтгэсэн байдлаар боловсрол, сургалтын үйл явц өрнөх хүний эрхийг дээдэлсэн боловсролын талаарх санааг дэлгэрүүлбэл, сурч боловсрох эрхээ эдэлнэ гэдэг нь боловсрол хүн бүрд хүртээмжтэй байх, хүүхэд бүр чанартай боловсрол эзэмших, сурч боловсорч байгаа орчиндоо хүндэтгэл хүлээхийг хэлж байна. Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх, авьяас сонирхлыг нь тэтгэж дэмжих, сурагч төвтэй сургалт, хүүхдийн өөрийнх нь оролцоог хангасан сургалтын үйл явц, идэвхтэй сургалтын арга, ёс суртахууны үнэт зүйлсийг төлөвшүүлэх тухай, идэвхтэй, хариуцлагатай иргэн болгох тухай нийгмийн хүрээнд яригдаад нэлээд цаг хугацаа өнгөрлөө. Энэ бүхний цаад үзэл санаа, суурь зарчим нь хүний эрх, хүний эрхэм чанар, эрх чөлөөний үзэл санаа байдгийг бид тэр бүр анзааралгүй явж иржээ. Хүүхдийн боловсрол эзэмших үйл явц нь хүний эрхийн зарчмын дагуу явах ёстой бөгөөд хүүхэд нэг бүрийг эн тэнцүү авч үзэж, хүндэтгэх, тэдний ашиг сонирхлыг хөндсөн асуудлыг шийдэхдээ хэлбэр төдий биш утга учиртай оролцоог хангах, хүчирхийллийн бүх хэлбэрээс ангид байлгах, тэдний хэл, соёл, шашин шүтлэгт хүндэтгэлтэй хандах хэрэгтэй юм.

Хичээл болон хичээлээс гадуур бүх үйл ажиллагааны хүрээнд хүүхэд өөрийн үзэл бодолтой байх, өөрийгөө илэрхийлэхийг дэмжиж, харилцан ярилцах, хамтран ажиллах, багаар ажиллах, оролцоог хангахад анхаарч, сурагч төвтэй буюу хүүхэд нэг бүрийн онцлогт таарсан арга зүйг нэвтрүүлэх нь чухал байна. ЕБС-ийн иргэний боловсролын сургалтанд хийсэн үнэлгээ мониторингийн хүрээнд⁷⁸

78 ННФ, ЕБС-ийн иргэний боловсролын сургалтанд хийсэн үнэлгээ мониторинг, судалгааны тайлан, УБ, 2011

судлаачид хичээлд ажиглалт хийхэд багш нар ихэвчлэн асуулт тавьдаг, суралцагчид хариулдаг, асуултууд нь хаалттай, сурагчдын үзэл бодлыг сонсох, хэлэлцэх, бусдын үзэл бодолд хүндэтгэлтэй хандах, өөрийн байр сууриа хамгаалах зэрэг чадварт анхаараагүй, асуултууд нь мэдээллийг эргэн сануулсан, нэрлүүлсэн, агуулгын талаарх мэдлэг шалгасан, сурагчдын оролцоог хязгаарласан байсан нь нэг талаас жигд оролцоог хангах, дэмжлэг үзүүлэх зохион байгуулалт хийгдэх боломжгүй, нөгөө талаас багшид арга зүйн дэмжлэг дутагдаж байна гэжээ. Багш нар зөвхөн сурах бичгийн хүрээнд зааж байгаа нь багшид зориулсан гарын авлага материалыг бэлтгэж гаргадаггүй, интернэт техник хэрэгсэл ашиглах боломж муу байгаа зэрэг шалтгаантай бөгөөд суралцагчдад нийгэм дэх олон ургалч үзэл, мэдээллийн олон эх сурвалжийг ашиглах, үнэлгээ дүгнэлт хийх, мэдээлэлтэй ажиллах, хэлсэн ярьснаа нотлох, хариуцлагаа хүлээх зэрэг чадвар төлөвшихөд саад болж байна. Тэгэхээр хүний эрхийн боловсрол олгох гэдэг нь санхүү төсвийн, багшийн мэргэжлийн бэлтгэл, ур чадвар, сургуулийн үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдах ажилтны арга барилтай холбоотой өргөн хүрээний асуудал⁷⁹ болж байна.

Сурагчид болон багш, боловсролын салбарт ажиллагсдын хүний эрхэм чанарыг хүндэтгэсэн сахилга бат, дэг журам тогтоох үйл явцыг дунд сургуулиас эхлэх ёстой. Боловсролын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, засаглалын үйл явц, журам дүрэм нь суралцагчид, багш, боловсролын ажилтнууд, эцэг эх, асран хамгаалагчдыг ямарваа нэг байдлаар ялгаварлан гадуурхаагүй, тэгш хамруулсан,

79 “Бүх нийт боловсролын төлөө!” ИН-ийн Үндэсний эвсэл, “Боловсрол: чанар ба хариуцлага” түргэн үнэлгээний тайлан, УБ, 2011

хүний эрхэм чанарыг⁸⁰ нь дээдэлсэн, хүндэтгэсэн, хариуцан тайлагнасан, оролцуулсан, эрх мэдэлжүүлсэн байхыг хүний эрхийн соёл тогтсон байгууллага гэж хэлнэ.

Монголын ард түмэн бидний нийтлэг хүсэл зоригийг илэрхийлдэг Үндсэн хуульд “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гээд биччихсэн нь хэн ч маргашгүй нийгмийн үнэт зүйлсийн нэгээхэн илэрхийлэл гэж хэлж болно. Ард түмний татвараас санхүүждэг төрийн боловсролын тогтолцоо дээрх зарчмаар ажиллаж, нийтэд итгэл үнэмшил болгох үүрэг хүлээх ёстой.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бусад эцэг эхчүүд ялгаварлан гадуурхах, хүүхэд хүүхдээ сургуулийн орчинд дээрэлхэх, хүүхэд асрах чөлөөнөөс ирсэн эмэгтэй багшийг ажилд нь эргүүлэн авахгүй байх, захирал, эрх мэдэлтнүүд хууль бус дарамт шахалт үзүүлэх зэрэг хүний эрхийн наад захын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хариу үйлдэл үзүүлэх механизм, чадавхи боловсролын салбарт бүрдүүлэх шаардлагатай байна.

Хүнийг өөрийн эрхээ эдлэх, хэрэгжүүлэх болон бусдын эрхийг хүндэтгэх ба хамгаалах талаар эрх мэдэлжүүлэх хүний эрхийн төлөөх боловсролыг олгох тухай сүүлчийн санааг задалбал боловсролын бодлого боловсруулагчид, хэрэгжүүлэгчдийн дунд боловсролын үйлчилгээг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх дүгнэхдээ хүний эрхэд суурилсан хандлагаар авч үзэх, боловсролын салбарт байгаа хүний эрхийн зөрчлүүдийг

тодорхойлох, суурь шалтгааныг олж арилгах хүчин чармайлт тавих, зөрчигдсөн эрхийг сэргээхийн төлөө төлөвлөгөө, хөтөлбөр гаргах, үйл ажиллагаа зохион байгуулах, төсөвт тусгах зэрэг нь хүний эрхийн төлөөх боловсролын түвшин ямар байгааг харуулна.

Мартин Лютер Кинг, Элеонара Рузвельт, Нельсон Мандела, Ан Сан Сучи, Махатма Ганди, Малала Юсавзай гэх мэт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн болон Монголын, өөрийн орон нутаг дахь хүний эрхийн төлөө тэмцэгчид, иргэний нийгмийн байгууллагуудын талаар заавал хичнээн сонирхолтой вэ? Өөрийн эрхээ мэдээд, хамгаалаад, шаардаад зогсохгүй бусдын эрх, эрх чөлөөний төлөө тэмцэх, дуу хоолойгоо өргөх, хамтрах ёстой гэдгээ мэдээд, хандлага, үнэт зүйлс нь тогтоод, бусадтай хамтран өөрийн зүгээс санаачлаад үйл ажиллагаа болгоод явбал хүний эрхийн боловсролын ач холбогдол тэр байх болно.

Хүний эрхийн боловсрол олгоход тулгамдаж буй асуудлуудыг Монголын нөхцөлд тодорхойлох судалгаа явуулахад⁸¹

- Хүний эрхийн боловсролыг дунд сургуулийн албан боловсролын түвшинд олгох ёстой гэж судалгаанд оролцогчдын 32,7 % нь үзсэн бол, 44,4% нь бага дунд дээд боловсролын түвшинд хичээл болгон оруулах, 45,3% нь албан, албан бус боловсролын хөтөлбөрүүдэд интеграцчилан оруулах нь зүйтэй гэж үзжээ.
- Тэдний 31,7% нь хүний эрхийн олон улсын стандартад нийцүүлсэн боловсрол хэрэгтэй гэсэн бол 43,8% нь хүний эрхийн боловсролын агуулга, арга зүйг өдөр тутмын амьдралтай

80 Human Dignity-Хүний нэр төр гэж орчуулсан байдаг нь хүмүүст буруу ойлголт төрүүлдэг тул хүний эрхэм чанар гэж орчуулан хэрэглэв.

81 "Монгол дахь хүний эрхийн боловсрол ба соёлын хүчин зүйлсийн нөлөөлөл" судалгааны тайлан, Ч.Алтангэрэл, К.Рудельс Палмер, 2005, УБ хот

холбож өгөх шаардлагатай гэж үзсэн байна.

Сүүлийн үед төрийн зүгээс сурах бичигт хүний эрх, жендэрийн тэгш эрхийн өнцгөөс дүн шинжилгээ хийх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах зохицуулалтыг хуульд оруулах, үндэсний цөөнхийн боловсролын асуудлаар судлаачдыг ажиллуулах, цаатан хүүхдийн боловсролын санхүүжилтийг нэмэх зэргээр хүний эрхийн мэдрэмжтэй бодлогууд хэрэгжиж эхлээд байна.

Мөн хүүхэд, залуус, олон нийтийн ойлголт нэмэгдүүлэх кампанит ажил зохион байгуулж, хэвлэл мэдээллээр өөрсдийн дуу хоолойг илэрхийлэх, сэтгүүлчдийн клуб байгуулан төрөл бүрийн сэдвээр мэдээ бичих, мэтгэлцээний клуб, кино клуб байгуулан өөрт тулгамдаад байгаа асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх зэрэг хүний эрхийн соёл төлөвшихөд хувь нэмрээ оруулсан үйл ажиллагааг ИНБ-ууд зохион байгуулж байгаа нь сайшаалтай. Жишээлбэл, “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвсэл “Сайн сургуулийг бүтээцгээе!” Сургуулийн орчныг үнэлэх аргачлал боловсруулан сурагчдын төлөөллийг хамтарсан багт оруулж, өөрсдийн сургуулийн материаллаг, сэтгэл зүйн болон засаглалын орчныг сайжруулахад оролцох эрхтэй гэдгийг харуулах, мэдрүүлэх улмаар эрх мэдэлжүүлэх санаачлагыг хэрэгжүүлж байна. Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг сургуулиуд дээр кино клуб ажиллуулан, хүүхдүүд өнөөдрийн дэлхий ертөнцөд тулгамдаад байгаа ядуурал, гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн хөдөлмөр, хөгжлийн бэрхшээлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалт, байгаль орчны бохирдол, нийгмийн цөөнхийн эрх зэрэг хүний эрхийн

зөрчлийн ноцтой хэлбэрүүдийн талаар кино үзсэний дараа ярилцлага хийх, мэтгэлцээн өрнүүлэх, зурагт хуудас хийх, сайн дурын ажилд оролцох зэргээр хүний эрхийн боловсролыг олж авах боломжийг олгож байна.

Монголд шинэ нийгмийн, шинэ соёлыг албан ба албан бус боловсролоор дамжуулан бүтээхгүй бол сул орон зай дээр нугтархдаг, хамаархдаг, социализмын үеийн намчирхдаг, мухар сүсэгт автдаг, ялгаварлан гадуурхдаг, ялгаатай нэгнээ үзэн яддаг соёл шинэ дүр төрхтэй болж хувираад буцаж сэргэдэг, эсвэл шинээр бойждог нь тодорхой болоод байна. Шинээр гарч буй нийгмийн үзэгдлүүдийг хүний эрхийн өнцгөөс задлан шинжилдэг, тодорхойлдог, хариу үйлдэл хийдэг, нийгмийг соён гэгээрүүлдэг төрийн механизм ажиллах шаардлага байна. Хүний эрхийн Үндэсний Комисс байгуулагдтал хүний эрхийн боловсрол, сургалт, мэдлэг ойлголт нэмэгдүүлэх, мэдээлэл түгээх, хүний эрхийн төлөөх өмгөөлөл, тэмцэл, хөдөлгөөн, шаардлага зэрэг үйл ажиллагааг Монголд иргэний нийгмийн байгууллагууд голлон гүйцэтгэж ирсэн билээ. Цаашид ХЭҮК, Боловсролын яам, хүрээлэн, багш нарын мэргэжил дээшлүүлэх институтээс санаачлан хүний эрхийн чиглэлээр ажилладаг ИНБ-уудтай хамтран багшид зориулсан гарын авлагууд, сургалтын сонирхолтой материалууд боловсруулан хэвлэн гаргах нь багш өөрийн сургалтын үйл ажиллагааг мэдэж төлөвлөдөг эрх мэдэлтэй болсон өнөө үед чухал байж мэдэх юм.

Хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхийг нээж, эерэг зан үйл, хандлага төлөвшүүлэхэд чиглэгдсэн,

хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, хүрэлцээтэй, хүртээмжтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, цаг үетэйгээ хөл нийлэн алхсан боловсролын тогтолцоог төлөвшүүлэх нь энэ нийгэмд амьдарч байгаа хэн бүрийн хамтын хариуцлагын асуудал мөн.

Тийм ч учраас Хүүхдийн эрхийн Конвенцийн 29 дүгээр зүйлд боловсрол нь хүүхдийг хувь хүнийх нь хувьд болон авьяас, оюуны болон биеийн чадавхийг чинээнд нь тулгал хөгжүүлэхийн зэрэгцээ хүний эрх, үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үзлээр хүмүүжүүлэх, өөрийн болон бусдын соёл, үнэт зүйлс, ялгаатай байдалд хүндэтгэлтэй хандах, харилцан ойлголцол, энхийг эрхэмлэх, хүлцэн тэвчих, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эрх тэгш байдал, бусдын

эрхийг хүндэтгэн нийгэмд хариуцлагатай амьдрахад сургах шаардлагатай гэж заасан байдаг нь учиртай.

Хүний эрхийн боловсрол нь хүний эрхийн түгээмэл соёлыг бүтээн цогцлоход чиглэсэн боловсрол, сургалт, мэдээллийн үйл ажиллагаа юм. Хүүхэд, залуус насанд хүрэгчдэд хүний эрхийн боловсрол олгох нь тэднийг өөрийн эрхээ эдлэхэд туслаад зогсохгүй бусдын эрхэнд халдахгүй байхад тусална. Сургуулийн өмнөх боловсролоос насанд хүрсэн амьдралын туршид, албан ба албан бус боловсролын хүрээнд, насан туршдаа хүний эрхийн боловсролыг эзэмших боломж бололцоог төр хангах үүрэгтэй болохыг олон улсын хүний эрхийн баримт бичгүүдэд тодорхой заасан байна.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

СУДАЛГАА

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ДОТУУР БАЙРАН ДАХЬ ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

/СУДАЛГААНЫ ТОЙМ ТАЙЛАН/



Хүүхдийн эрх Хамгаалал Төвийн
тэргүүн, Сэтгэл судлалын магистр

Л.БАДАМЦЭЦЭГ

Хүүхэд хамгааллын тулгамдаж буй олон Асуудал байдаг. Тэдгээр асуудлуудын нэг нь хамгийн орхигдож, анхаарлын гадуур үлддэг “Дотуур байрын хүүхдийн хамгаалал”-ын асуудлыг хөндөж, тэнд амьдарч байгаа бүх хүүхдийг аливаа эрсдлээс хамгаалах зорилт дэвшүүлж, 2014 онд Хүүхэд хамгааллын үндэсний сүлжээнээс “**Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байран дахь хүүхэд хамгаалал**” нэртэй судалгааг хийлээ. Энэхүү түүвэр судалгаанд газар нутгийн хувьд бүсчилсэн байдлаар, Улаанбаатар хот болон 5 аймгийн нийт 17 сургуулийн дотуур байрыг хамруулсан байна.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар 511 дотуур байранд 34704 хүүхэд амьдарч, байгаагийн 28071 нь малчдын хүүхэд⁸² юм байна.

Судалгааг хийхдээ БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын 2008 оны 02 дугаар

82 БСШУ-ны албан ёсны вэб сайт www.mesds.gov.mn-ээс авав.

сарын 26-ны өдрийн 84/43 тоот хамтарсан тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлага”-ыг (цаашид нийтлэг шаардлага гэх) эх сурвалж болгож, хэрэгжилтийн үр дүнг тооцохдоо хүүхдийн хамгаалуулах эрхийг хангаж чадаж байгаа эсэхэд гол анхаарлаа хандууллаа.

Судалгааны аргын хувьд сонгож авсан дотуур байрын үйл ажиллагаатай биечлэн танилцаж, ажиглалт танадалт хийх, тэнд амьдарч буй хүүхдүүд, байрын багш, нийгмийн ажилтан, сургуулийн удирдлагуудтай ганцаарчилсан болон бүлгийн ярилцлага хийх, холбогдох баримт бичгийг судлах, товч анкет асуулгыг бөглүүлэх зэрэг аргуудыг хэрэглэсэн болно.

Нэг. Дотуур байрны үйлчилгээний орчин хүүхдийн эрхэд нийцэж байна уу?

Судалгааны энэ хэсэгт дотуур байрны үйлчилгээний орчин нөхцөл нь хүүхдийн эсэн мэнд, аюулгүй, эрүүл амьдрах эрхийг

хангасан, аливаа хор хохирол учруулахуйц эрсдэлээс хамгаалагдах боломж бүрдсэн байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх зорилготой хүүхдийн бие засах газар, ариун цэврийн өрөө, хүүхдийн байрлаж буй өрөөний халаалт дулаан гэсэн гурван орчныг сонгон авч, тэдгээр нь дотуур байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагад тусгасан шиг хүрэлцээтэй эсэх, ариун цэврийн шаардлага хангасан эсэх, гэрэлтүүлэгтэй эсэх, хүн 24 цагийн турш амьдрах тохилог дулаантай байх, мөн эдгээр газруудаар үйлчлүүлэх явцдаа хүүхэд хамгааллын эрсдэл болох хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэгт

өртөх, сөрөг явдалд уруу татагдахаас урьдчилан сэргийлсэн материаллаг орчныг бүрдүүлсэн эсэхийг анхаарсан юм.

Ариун цэврийн өрөө/бие засах газрын нөхцөл байдал, хүртээмж

- Нийтлэг шаардлагын 1.8-д зааснаар хүүхдийн нас, хүйсийн онцлогт тохирсон ариун цэврийн өрөө, гар угаалтуурын болон шүршүүрийн өрөөтэй байна. 20 хүүхдэд нэг шүршүүр, 20 эмэгтэй, 25 эрэгтэйд тус бүр нэг суултуур болон гар угаалтууртай байна гэж заасан байна.

Хүснэгт 1. Дотуур байрны бие засах газрын нөхцөл байдал

Дотуур байр	Тусгаарлагдсан	Хүртээмж	Зай	Гэрэлтүүлэг	
Өмнөговь, Даланзадгад	+	+	Байран дотор	+	
Өмнөговь, Цогтцэций	-	-	30 м	-	
Хөвсгөл, Мөрөн	+	+	30 м	-	
Хөвсгөл, Цагаан-Үүр	-	-	30 м	-	
Баян-Өлгий, Өлгий	+	-	Байран дотор	+	
Баян-Өлгий, Алтай	+	-	25-30 м	-	
Төв, Хүмүүн 1-р цогцолбор “А” дотуур байр	+	+	Байран дотор	+	
Төв, Хүмүүн 1-р цогцолбор “Б” дотуур байр	+	+	Байран дотор	+	
Төв, Эрдэнэ	+	+	500 м	-	
УБ хот, 116-р тусгай сургууль	+	+	Байран дотор	+	
УБ хот, 29-р тусгай сургууль	+	+	Байран дотор	+	
УБ хот, 73-р тусгай сургууль	+	+	Байран дотор	+	
Дорнод Хэрлэн	+	+	30 м	-	
Дорнод Хан-Уул	+	+	150 м	-	
Дорнод Цагаан-Овоо	+	-	25 м	-	
Дорнод Баян-Уул	+	+	30 м	-	
Хувь	Сайн	87,5	68,7	87,5	43,7
	Муу	12,5	31,3	12,5	56,3

График 1. Дотуур байрны бие засах газрын нөхцөл байдал



Халаалт нь төвийн шугаманд холбогдсон төв суурин газруудын дотуур байрны бие засах газар нь дотроо байрладаг бол, хөдөөгийн сумдын хувьд модон жорлон нь дотуур байрнаас 30 м-ээс хол зайд байрладаг ба ихэнх тохиолдолд хаалт байхгүй, өвлийн цагт мөстсөн, гэрэлтүүлэггүй байгаа нь хүүхдэд хүндрэлтэй, эрсдэлтэй байдлыг бий болгож байна.

Кейс 1

Хөвсгөл, Цагаан-Үүр сум, Баян-Өлгий, Алтай сум “...8-15 насны болон багш нарт зориулагдсан гадаа 8 хүний модон жорлонтой боловч жорлон нь дүүрсэн, нил мөстсөн, халтирдаг хүүхэд байтугай том хүн бие засах аргагүй, хүүхдүүд гадуур нь бие засаад удсан байсан...”, “... Гэрэлтүүлэг хангалтгүй, шөнө хүүхэд бие засах боломжгүй..., Өмнөговь Цогтцэций сум 6 настай хүүхдэд зориулсан гадаа жорлон байгаа боловч, ашигладаггүй, хаалгыг нь хадаасаар хавж хадсан байдалтай...”

Гадаа байрлаж буй бие засах газрын 43,7 хувь нь гэрэлтүүлэгтэй, 56,3 хувь нь гэрэлтүүлэггүй байгаа ба бие засахаар явахдаа гадны ямар ч аюулд өртөх магадлалтай байна.


Кейс 2

Өмнөговь, Даланзадгадын 1-р сургууль дотроо 00-той ч, гэрэл байхгүй, шатаад 7 хонож байна, амархан шатчихдаг, Төв аймаг Эрдэнэ сум “...Хааяа, айдаг. Гэрэл хангалтгүй, айдаг учир нь гэрэл жорлон хүртэл тусдаггүй” Баян-Өлгий, Өлгий сум “...Үдээс хойш тог өгдөггүй. Орой өрөөнөөс гарахаас айдаг. Мөн 11-с хойш гэрэл өгдөггүй. жорлон явж, бие засахаас айдаг”

/дотуур байранд амьдардаг хүүхдүүдийн ярианаас/

1.2 Дотуур байрны ариун цэврийн өрөөний нөхцөл байдал

График 2. Дотуур байрны ариун цэврийн өрөөний нөхцөл байдал



Дотуур байрнуудын 68,7 хувьд нь угаалтуур стандартад заагдсан тоотой байгаа хэдий ч, бүрэн ашигладаггүй, шаардлагад нийцэх байдал хангалтгүй байна.

Кейс 3

Хөвсгөл аймаг Мөрөн сум “...Аваарын хаалганы нарийхан коридорыг ашиглаж 2 угаалтуур тавьсан”, Хөвсгөл аймаг Цагаан-Үүр сум “...угаалтуурын өрөө нь маш хүйтэн тул хананаасаа мөөгөнцөртсөн, мөстсөн”.

Судалгаанд хамрагдсан аймгийн Төвийн сумдын дотуур байрны хувьд халуун ус нь бүрэн шийдвэрлэгдсэн, эрэгтэй эмэгтэйгээр тусгаарлагдсан, хүссэн цагтаа усанд орох боломжтой байсан бол хөдөөгийн алслагдсан сумдын дотуур байрны ихэнх нь буюу 56,3% нь дотуур байр халуун ус байхгүйгээс сумынхаа халуун усны газар өөрсдөө мөнгөө төлж ордог, Өмнөговь Даланзадгад сум "... Халуун усгүй тул сумын халуун устай гэрээ байгуулж хямдралтай үнээр /500 төгрөгөөр/ усанд оруулдаг, халуун ус нь ажиллагаатай цөөн газар нь мөөгөнцөр үүссэн, хүйтэн, хана цуурсан зэрэг ариун цэврийн хувьд шаардлага хангадаггүй байна. Баян-Өлгий, Өлгий хот "... 1 шүршүүртэй, шүршүүр нь бохир, ус алддаг" Хүүхдүүд 7 хоногт 1 удаа, зарим нь сард 3 удаа ордог бол гэртээ харьж усанд ордог ч хүүхэд байсан.

1.3 Өрөө тасалгааны тав тух

Хүснэгт 3. Дотуур байрны Өрөө тасалгааны тав тух

Кейс 4

Хөвсгөл, Цагаан-Үүр "...Өрөө бүр паартай, мөн зуухтай, модон цонхтой дулаалсан боловч тасалгааны температур 14-15 градустай өрөө хүйтэн, хүүхдүүд гадны куртиктэйгээ байсан. 7 хоногт 1 удаа /бусад үед сул халаалттай/ галладаг, нүүрс хэрэглэдэггүй, дан модоор галладаг тул амархан хөрдөг. Мэргэжлийн хяналтын шалгалт ирээд цаашид дотуур байранд хүүхэд амьдрах боломжгүй гэсэн дүгнэлт гаргасан"

Судалгаанд хамрагдсан бүх дотуур байрнууд өрөө болгондоо цонхтой, байгалийн гэрэл тусдаг, коридортоо гэрэлтэй байна. Коридорын гэрэлийн 81,2% нь чанарын

хувьд боломжийн байдаг ч 25% нь шөнийн цагаар буюу шөнө 11 цагаас хойш гэрэлээ унтраадаг бөгөөд энэ нь мөн л хүүхдүүд шөнө гарч бие засах, орж гарах үедээ айдас, түгшүүртэй байдаг байна.

1.4 Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал - Дотуур байр

Байрнуудын 56,2 хувьд нь аюулгүй гарц, аврах хаалгатай, бэлэн байдлын схемтэй, багш нарын хувьд галын хор хэрэглэх мэдлэгтэй гэж хэлж байсан хэдий ч аврах гарцыг ашигладаггүй, өвлийн улиралд гарц хаалгыг дулаалахдаа давхар хадаасаар дарж хадсан байдалтай байсан ба хүүхдүүдэд аюулгүй ажиллагааны талаар сургалт явуулдаггүй учир энэ талын мэдлэг муу байсан.

Мөн галын болон аюулгүйн хэрэгсэл дутуу гал унтраах хэрэгсэл байдаг ч түүнд хайхрамжгүй хандах, хэрэглээ талаас нь биш харин байх ёстой гэдгээр хандах байдал ажиглагдсан. Галын аюулаас урьдчилан сэргийлэх тухай мэдээлэл бүхий самбарууд байгаа ч хүүхдийн нүдний харааны төвшингөөс хэт дээгүүр хананд тогтоосон зэрэг зөрчил ажиглагдсан.

Кейс 5

Төв аймаг Хүмүүн 1-р цогцолбор "Б" дотуур байр "...Галын хорыг ажиллуулах мэдлэггүй. Гал унтраах хэрэгсэлээ шатны доод хонгилд хийж түгжсэн. Хэзээ ч ашиглаж байгаагүйгээс гадна хэн ч хүрч байгаагүй. Галын хорны ашиглах хугацаа нь дууссан. Өмнөговь аймгийн цогцолбор 1-р сургуулийн дотуур байрны гал унтраагуурын хэрэгсэл шаардлага хангахгүй, хүрз нь ишгүй, хувин, галын хор байхгүй"

Хоёр. Дотуур байрны хүний нөөцөд тавигдах шаардлага

Энэ хэсэгт дотуур байрын багш нарын хүрэлцээ, ажил мэргэжлээ хэрхэн үнэлдэг, цаашид тогтвор суурьшилтай ажиллах эсэх, нийгмийн асуудал, түүнийг шийдвэрлэж байгаа байдал, сургуулийн захиргааны зүгээс анхаарал тавьдаг эсэхийг хүүхдийн эрхэд суурилсан хандлагаар судлах зорилт тавьлаа.

Дотуур байрны хүүхдүүд тухайн

жилийнхээ 3/4 буюу 9 сарыг эцэг эх, гэр орноосоо хол, бие даан амьдардаг. Иймээс дотуур байрны багш ажилтнууд хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг орлож чадахуйц мэдлэг, чадвар, дадлага туршлагатай, хүүхдийн эрх хэрэгцээг мэддэг ойлгодог, анхаарч халамжилдаг, халуун дулаан сэтгэлтэй, мэргэжлийн ёс зүйтэй, мэргэшсэн ажилтан байх ёстой.

2.1 Дотуур байрны хүүхдийн тоо, багш ажилтнуудын хүрэлцээ

Хүснэгт 4. Дотуур байрны хүүхэд болон багш тоо

Дотуур байр	Хүчин чадал	Одоо байгаа Хүүхдийн тоо	Багшийн тоо	Шөнийн ээлжинд
Өмнөговь, Даланзадгад сум, 1-р сургуулийн дотуур байр		93	2	4 жижүүр
Өмнөговь, Цогтцэций сумын сургуулийн дотуур байр		42	1	3 жижүүр
Хөвсгөл, Мөрөн сумын сургуулийн дотуур байр		30	1	2 жижүүр
Хөвсгөл, Цагаан-Үүр сумын сургуулийн дотуур байр		83	4	4 багш, жижүүр
Баян-Өлгий, Өлгий хотын сургуулийн дотуур байр	80	151	2	4 жижүүр
Баян-Өлгий, Алтай сумын сургуулийн дотуур байр	80-100	186	3	4 жижүүр
Төв, Хүмүүн 1-р цогцолбор сургуулийн “А” дотуур байр		56	4	4 багш, жижүүр
Төв, Хүмүүн 1-р цогцолбор сургуулийн “Б” дотуур байр		84	4	4 багш, жижүүр
Төв, Эрдэнэ сумын сургуулийн дотуур байр	68	141	1	1 багш, жижүүр
УБ хот, 116-р тусгай сургуулийн дотуур байр		63	3	3 багш, жижүүр
УБ хот, 29-р тусгай сургуулийн дотуур байр		90	3	3 жижүүр
УБ хот, 73-р тусгай сургуулийн дотуур байр	200	144	4	4 багш, жижүүр
Дорнод Хан-Уул	52	180	2	Жижүүр
Дорнод Хэрлэн		40	1	Жижүүр
Дорнод Цагаан-Овоо		120	1	Жижүүр
Дорнод Баян-Уул		100	1	Жижүүр
Нийт		1603	37	37,5

Дотуур байрнуудад байрны хүчин чадал, стандартад нийцүүлсэн тоогоор багш ажиллаж байгаа бөгөөд Баян-Өлгий аймгийн Өлгий, Алтай сумд, Төв аймгийн Эрдэнэ, Дорнод аймгийн Хан-Уул зэрэг хүчин чадлаасаа **2 дахин их хүүхэдтэй** дотуур байрнууд хүүхдийн тооноос хамаарч бус байрны хүчин чадалд тохирсон тооны багш ажиллаж байгаа нь хүүхэдтэй ажиллах багшийн хүрэлцээ хангалтгүй байгааг харуулж байна. Дотуур байранд ажиллах хүний нөөцийг авч үзвэл хүчин чадлаасаа хамаараад 7-22 ажилтантай бөгөөд судалгаанд хамрагдсан байрнуудын дөнгөж 37,5%-д нь шөнийн ээлжинд багш хонодог бөгөөд, харин багш цөөтэй байруудад шөнө дан ээлжийн жижүүрүүд хонодог байна.

2.2 Багш нарын мэргэжил, дадлага туршилага, сэтгэл ханамж

Багш нарын насны байдлыг 4 ангилалаар авч үзвэл 25 хүртэлх насныхан хамгийн бага буюу 11,8%, 26-35 насныхан, 36-45 насныхан болон 50-аас дээш насныхан ижилхэн 29,4%-ийг эзэлж байгаа ба бүгдээрээ багшийн мэргэжилтэй байна.

Тэдний 64,7% нь хийж буй ажилдаа сэтгэл ханамжтай, үлдсэн 35,3% нь хийж буй ажилдаа сэтгэл хангалуун биш гэсэн байна. Сэтгэл ханамжтай гэж хариулсан багш нарын насны байдал нь 40-өөс дээш насныхан байгаа нь насны байдлаар өөр ажил олдохгүй, тэтгэвэрт гарахаа хүлээж байгаа бол /УБ, 29-р сургууль "...Тэтгэвэртээ гартлаа ажиллана. Ер нь эндээ ажиллах сонирхолтой"/, ажилдаа сэтгэл ханамжгүй, сонирхолгүй гэсэн багш нар нь насны хувьд 25-35 насныхан байгаа ба тэд багшийн мэргэжлээрээ ажиллах сонирхолтой, орон тоо хүлээж байгаа, байрны багш нь цалин

бага, ажлын цаг урт гэсэн шалтгаануудыг хэлсэн байна.

Судалгаанд хамрагдсан дотуур байрын багш нар өөрийн мэргэжлээр сургуульдаа багшлах боломжийг хүлээж, дотуур байранд ажиллаж байгаа гэдгээ фокус бүлгийн ярилцлагын үеэр илэрхийлж байлаа. Үүнээс үзэхэд тэдний хувьд дотуур байрын багш хийх нь мэргэжлээрээ ажиллахын өмнөх дамжих шат, түр зуурын, жижүүрийн үүрэг мэт үздэг гэж тодорхойлж болох юм.

Байрны багш нар нь ТҮ-IV ангилалаар цалинждаг дунджаар **430,000** орчим мянган төгрөг авдаг байна. /1 багш ТҮ-III, 1 багш ТҮ-V цалинждаг, энэ нь тэдний ажилласан жилтэй холбоотой байна. Дотуур байрын багш нь ажлын өдөр 8 цаг ажиллах хуваарьтай, энэ нь 2-с дээш байрын багш ажиллаж байгаа бол хэрэгжиж байгаа ба 1 багш ажилладаг бол өдөрт 10-12 цаг ажиллахаас гадна амралтын өдрүүдэд ч ажилладаг, мөн шөнийн цагаар хүүхэд өвдөх, ямар нэгэн зөрчил гаргахад дуудагдаж ирдэг тул байнгын ачаалалтай байна. Төрийн үйлчилгээний албан хаагчдад олгодог ур чадварын болон үр дүнгийн нэмэгдлийг аль ч сургууль багш нарт олгоогүй байна.

Багш нарын хувьд 2013 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан **“Дотуур байрны хүүхдийн өсөлт хөгжилт”** сертификаттай сургалтанд хамрагдсанаас өөр мэргэжлийн ямар нэгэн сургалтанд огт хамрагдаагүй бөгөөд, цаашид хамрагдах сонирхол, хэрэгцээ шаардлага маш их байдаг байна.

Дотуур байранд ажиллаж байгаа бусад ажилтнууд нэг ч удаа хүүхэдтэй ажиллах арга зүй, дотуур байрны хүүхдийн онцлог,

хүүхдийн эрхийн тухай сургалтуудад хамрагдаж үзээгүй байна.

Ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь нь тодорхой нь сайшаалтай зүйлийн нэг байлаа. Харин багш нарын ажилдаа сэтгэл ханамжтай байгаа эсэхийг тодруулахад багш нарын 90% нь сургуулийн гадна байгаа мэт дотоод мэдээлэл муутай, орчинд нь анхаарал тавьдгаас биш багш нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын ачааллыг харгалзан цалин урамшуулал олгох асуудал дээр сургуулийн захиргаа анхаардаггүй, багш уу, жирийн ажилтан уу гэдэг зааг ялгаагаа мэддэггүй гэх зэрэг дотуур байрны багшийн өөрийн үнэлэмжийн талаар ихэнх багш нар санал гомдол гаргаж байна.

Гурав. Хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлага

Дотуур байр бол хүүхдийн гэр, тэнд амьдарч буй найз нөхөд, багш нар нь тэдний гэр бүл байх ёстой. Иймээс энэ хэсэгт хүүхдэд тохиолдож болох эрсдэл, түүнийг даван туулах чадвар, хүүхдийн чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх болон сургуулийн захиргаа, эцэг эхчүүд хоорондын харилцааг хүүхдийн эрхэд суурилсан хандлагаар судлахыг зорьсон болно.

3.1 Хүүхдүүдийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй эсэх

Хүүхдүүдийн төрсний гэрчилгээ болон ЭМД-ийн дэвтэр байрны багш /байранд эмч ажилладаг тохиолдолд эмчид байдаг/ нарт байдаг ба байрны багш хүүхэд бүрийн ам бүлийн талаарх мэдээлэл, холбоо барих утас болон шаардлагатай бүх дэлгэрэнгүй

судалгаатай байсан. Зарим байрны хүүхдүүдийн төрсний гэрчилгээ хүүхдүүдэд болон эцэг эхчүүдэд нь байдаг. Харин Баян-Өлгий аймгийн **Өлгий** хотын байрны багшид хүүхдийн эрүүл мэндийн түүх, хүүхдийн ам бүлийн талаарх мэдээлэл байхгүй, хүүхдийн талаар тусгайлсан тэмдэглэл байгаагүй дутагдалтай байхад Өмнөговь аймгийн **Даланзадгад** сумын багш хүүхдүүдийн **зан төлөвийн судалгааг** гаргасан давуу талтай байлаа.

3.2 Дотуур байрны хүүхэдтэй ажиллах үйл ажиллагаа, дүрэм журам

Бүх дотуур байр өдөр тутмын цагийн хуваарьтай бөгөөд үүнд өдөр тутмын үйл ажиллагаа болон хичээл давтах цаг тусгасан байдаг байна. Байрны хүүхдүүдийн дунд явуулах хүмүүжлийн ажлын төлөвлөгөөтэй бөгөөд хүүхдүүдийн сонирхлын дагуу шатар, даам, шооны тэмцээн явуулдаг байна. Өмнөговь аймгийн 4-р сургуулийн дотуур байрны багш хүүхдэд хүмүүжлийн дадал чадвар олгох, гэрийн даалгавраа тогтвор суурьшилтай хийх, том хүүхдүүд нь бага насны хүүхдүүддээ туслах тал дээр нийгэмшихүйн олон талт ажил зохион байгуулдаг, 1-р сургуулийн захирал дотуур байрны хүүхдүүдтэй уулздаг тогтмол цагтай зэрэг сайн туршлага байна.

График 7. Саналын хайрцаг ажиллуулж, хүүхдийн саналыг авдаг




График 8. Хүүхдийн асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг байдал



Багш нарын 57,1% нь дотуур байранд саналын хайрцаг ажиллуулж хүүхдүүдээ санал авч харилцан ярилцах байдлаар хамтарч ажилладаг, Хүүхдүүдийн 50% нь хүүхдүүд санал хүсэлт болон хэлэх гэсэн үгээ “Саналын хайрцаг”-нд хийдэг, түүнийг нь сургуулийн нийгмийн ажилтан задалж байрны багштай хамтран шийдвэрлэдэг гэсэн бол 50% нь огт санал авдаггүй ба зарим тохиолдолд санал хэлэхэд хүлээж авдаггүй гэсэн байна. Баян-Өлгий, Өлгий сум “... Санал гомдол хэлэхэд цаасыг ураад хаядаг.” 17 настай охин

Саналын хайрцаг ажиллуулж байгаа тохиолдолд санал, хүсэлт бүрийг санал гаргасан хүүхдүүдтэй уулзаж шийдвэрлэх нь үр дүн сайтай байдаг байна. УБ хот, 116-р тусгай сургууль “...12 хүүхдийг компьютертэй болох санал гарсан нь биелэгдсэн”, Хөвсгөл аймаг Цагаан-Үүр “... Хүүхдийн санал гомдлыг байрны зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэдэг”.

Мөн багш нарын 31,3 хувь нь хүүхдүүдэд ганцаарчилсан зөвлөгөө өгдөг, зөрчил гаргасан хүүхдүүдтэй ажиллахад их цаг зарцуулдаг, 62,5 хувь нь хүүхдүүдийн эерэг зан үйлийг төлөвшүүлэх сургалт явуулдаг гэсэн бол хүүхдүүдийн ердөө 12,5 хувь нь асуудлыг багш нартайгаа ярилцдаг, харин 87,5 хувь нь найз нартайгаа ярилцдаг

гэсэн байна. УБ-ын 116-р тусгай сургуулийн дотуур байр амьдрах ухааны сургалт явуулдаг нь давуу талтай байсан ба бусад байрны багш нарын ярилцлагаас харахад өөрсдөө амьдрах ухааны сургалтаа мэдэхгүй байдалтай байна.

3.2 Эцэг эхтэй хамтран ажиллах үйл ажиллагаа

Байрны багш нарт эцэг эхчүүдтэй ажиллах тусгайлсан хөтөлбөр огт байдаггүй бөгөөд ихэнх багш нар сурагчдын амралтаар эцэг эх хүүхдүүдээ авах гэж ирэх үед нь сургалт зохион байгуулдаг гэж ярьж байгаа нь үнэн хэрэгтэй сургалт биш уулзалт, ярилцлага байсан. Харин 116-р тусгай сургуулийн байрны багш нар Тусгай хөтөлбөртэй бөгөөд Эцэг эхчүүдэд 4, хүүхдүүдэд 5 удаагийн сургалт явуулсан нь тухайн сургуулийн онцлогтой холбоотой байлаа. Өмнөговь аймгийн 1-р сургууль, Цогтцэций сумын дотуур байрны багш нарт хүүхдийн эцэг эхтэй хийх гурвалсан гэрээний загвар байгаа боловч, нэг ч хүүхдийн гэрээн дээр эцэг эх болон сургуулийн захирал гарын үсгээ зураагүй, баталгаажуулаагүй байв.

Өмнөговь аймгийн Даланзадгад, Цогтцэций сум, Баян-Өлгий аймгийн Алтай сумдын дотуур байр хүүхдүүдийн эцэг эх нь ирсэн үед хамт байлгах өрөө байгуулсан нь цаашид туршлага болгон түгээхэд ач холбогдолтой гэж үзэж байна.


Эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр бүх сургуулийн захиргаа анхаарах шаардлагатай байна. Тухайлбал, Зарим эцэг эхчүүд намар хүүхдээ цүнхтэй хувцсыг нь бариулаад, нутгийн унаа машинд дайгаад явуулдаг, хүүхэдтэй утсаар ярьж, хэрэгтэй мөнгө төгрөгийг мобайл банкаар, хувцас хунар эд зүйсийг хүнээр

өгч явуулаад, сургууль багш нартай ямар ч харилцаагүй байдаг, хүүхэд нь өвдөж, эмийн зардал гарахад өгдөггүй гэх мэт бэрхшээл гардаг тухай багш нар фокус бүлгийн ярилцлагаар асуудлыг гаргаж тавьж байна.. Ер нь хүүхэд хамгааллын асуудлын хүрээнд дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн эцэг эх, тухайн сургуулийн захиргаанд хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих эрх шилжүүлэх тухай эрх зүйн орчин байхгүй байгаа нь энэ мэт бэрхшээлийн шалтгаан болж байна гэж үзэж байна.

3.4 Чөлөөт цаг, соёлын арга хэмжээ

Дотуур байрны хүүхдүүдийн хувьд номын сангаар үйлчлүүлэхэд нээлттэй байдаг бөгөөд Төв Хүмүүн 1-р цогцолбор “А”, “Б” дотуур байр, Өмнөговь Цогтцэций сумын хувьд үйлчлэх хуваарь, номын сангийн журмыг бичиж тавьсан нь үйлчилгээг илүү тодорхой болгосон байна. Мөн явуулын номын сантай сумд ч байсан. Өмнөговь Цогтцэций сум “...Явуулын номын сангаар үйлчлэх хуваарьтай, номын сангийн журамтай”, Хөвсгөл аймаг Мөрөн сум “...Дотуур байрандаа нэг өрөөг гарган номын сан байгуулж эхэлж байгаа, явуулын номын сангаар үйлчлэх хуваарьтай, номын сан картаар үйлчилдэг”.

График 9. Хүүхдүүдийн спорт зааланд тоглодог байдал



Судалгаанд хамрагдсан дотуур байрнуудын багш нарын 84,6 хувь нь

хүүхдүүд спорт зааланд хуваарийн дагуу тогтмол буюу 7 хоногийн 1 өдөр 1-2 цагаар тоглодог, 7,7 хувь нь хааяа л тоглодог гэсэн бол хүүхдүүдийн хувьд эсрэгээрээ буюу 92,3 хувь нь хааяа л тоглодог, үлдсэн 15,4 хувь нь тогтмол буюу 7 хоногийн 1 өдөр 1-2 цагаар тоглодог гэсэн байгаагаас харахад багш нар хүүхдүүдийн чөлөөт цагт төдийлөн анхаарал тавьдаггүйг харуулж байна. Яагаад хуваарийн дагуу тоглодоггүйг хүүхдүүдээс асуухад ихэнхдээ өөр байгууллага, хүмүүст заалыг түрээсэлсэн байдаг гэж хэлж байна.

График 10. Дотуур байранд зохион байгуулсан сургалтууд



Судалгаанд хамрагдсан байрнуудын 50 хувьд нь л хүүхдүүдэд сургалт явуулсан бөгөөд, дийлэнхдээ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гамшигаас өөрийгөө хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зэрэг сургалтуудыг мэргэжлийн байгууллагын ажилтнууд болох цагдаа, эмч, онцгой байдлын ажилтан, ниймгийн ажилтанууд заадаг байна.

Хүүхдүүд чөлөөт цагаараа тасагтаа хичээлээ хийдэг 40%, уралдаан тэмцээн зохион байгуулдаг 30%, зааланд тоглодог 20%, янз бүрийн дугуйланд явдаг 10% гэж хариулснаас харахад ихэнх цагаа дотуур байрандаа байдаг байна.

3.5 Хүүхэд хамгааллын зөрчил, түүнийг шийдвэрлэж байгаа байдал

Хүүхэд хүүхдээ шоглох, нэр хоч өгөх,

доромжлох, ялгаварлан гадуурхах зэрэг хүүхэд хамгааллын зөрчил нийтлэг байгаа ч, хүүхдүүд энэхүү байдлыг байх ёстой хэвийн үзэгдэл хэмээн үзэж, гомдоллосон нэгнийгээ “тоглоом даадаггүй” хэмээн тохуурхах явдал нийтлэг байна. Харин багш нарын тухай хүүхэд хамгааллын тухай цэгцтэй ойлголт мэдлэг байхгүй ч, “хүүхдийг бие махбодын болон сэтгэл санааны шийтгэлээр шийтгэхийг хориглох” тухай Боловсролын хууль болон Багшийн ёс зүйн дүрмийг баримталж ажилладаг тухай 100% итгэлтэй ярьж, хүүхдүүд ч энэ тухай нотолж байсан. Байрны хүүхэд зөрчил гаргасан тохиолдолд ангийн багш, нийгмийн ажилтан, байрны багш хамтарч асуудлыг шийдэх, асуудал гүнзгийрвэл, хүүхэд, эцэг эхийн оролцоотой захирлын дэргэдэх зөвлөлөөр асуудлыг шийдвэрлэдэг байдал нийтлэг байсан хэдий ч хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд ямар үе шаттай арга хэмжээ авах, хэрхэн шийдвэрлэх багш ямар үүрэгтэй, мэдлэгтэй байх талаар нарийн мэдлэг байдаггүй байна.

Судалгаанд хамрагдсан дотуур байрнуудын хувьд 2008 оноос хойш бэлгийн хүчирхийлэлд өртсөн, завдсан, сургууль завсардсан тохиолдол гараагүй ба 1 байранд 2 жилийн өмнө амиа егүүтгэсэн тохиолдол гарсан хэдий ч ямар арга хэмжээ авсан нь тодорхойгүй байна.

Байранд хүүхэд өвдсөн тохиолдолд байрын багш эмнэлэгт үзүүлэх, оношлуулах, шинжлүүлэх үүрэг хүлээдэг, эмийн эмчилгээ хийлгэж байгаа тохиолдол эцэг эхээс зардлыг гаргуулдаг юм байна. Гэхдээ багш нар болон сурагчдад Эрүүл мэндийн даатгалын дэвтэр нь байхгүй, эцэг эх нь гэртээ хадгалдаг нийтлэг дутагдал байна. Сургуулийн зүгээс дотуур байрны хүүхдийн эмийн зардалд сард ойролцоогоор 10000 орчим төгрөг

зарцуулдаг нь яаж ч хэмнээд хүрэлцдэггүй тухай багш нар ярьж байв.

Дотуур байрнуудын 50% нь гамшгийн үеийн бэлэн байдлын төлөвлөгөөгүй байна. Цаашид гамшгийн үеийн хүүхэд хамгааллын сургалтанд байрны багш, ажилтнуудыг бүрэн хамруулах шаардлагатай.

Дүгнэлт

Тус судалгааг 2014 оны 02 сарын 25-аас 03 сарын 25-ны хооронд Улаанбаатар хот болон 5 аймгийн 11 сумын 17 дотуур байрыг хамруулан хийсэн. Судалгааг дараах үндсэн 3 шаардлагын хүрээнд багцлан хийж, дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Дотуур байрны үйлчилгээний орчинд тавигдах шаардлагын талаарх дүгнэлт

1.1 Дотуур байрны бие засах газрын хүртээмж 56,3 хувь байгаа нь хангалттай тоо биш байна. Ялангуяа хөдөө орон нутгийн онцлогт тохирсон, хүүхдийн нас, хөгжил, хэрэгцээний онцлогт тохирсон тусгай суултуур болон тавцантай гадаа жорлон шаардлагатай байна. Төвлөрсөн системд холбогдсон дотуур байр дотроо суултууртай бие засах газар орон тооны үйлчилгээний ажилтан ажиллаж байхад, гадаа жорлонг цэвэрлэх, орчны бохирыг зөөвөрлөх ажлыг хэн хийх нь тодорхойгүй байгаагаас үйлчилгээний шаардлага хангахгүй жорлон ялангуяа сумдын сургуулийн дотуур байранд нийтлэг байгаа нь орчны бохирдол, бохир гараар дамжин халдварлах халдварт өвчинд хүүхдүүд өртөх эрсдэл өндөр байна.

- 1.2 Байрны хүүхдийн бие засах газар нь байрнаас хол байж болох ч, гэрэлтүүлэг хангалттай биш байна. Энэ нь хүүхдүүд шөнө оройн цагт гарч бие засах үед харанхуйд айж ичээд зогсохгүй, гэмт хэргийн золиос болох эрсдэлтэй нөхцөл байдалд амьдарч байна. Мөн байрны дотор гудамж коридор, хонгил, үүдний өрөөний гэрэлтүүлгийг сайжруулах, цахилгааны доголдлыг тухай бүр нь нь засч байх, чийдэн шатсан тохиолдол бүрт сольж байх шаардлагатай байна.
- 1.3 Мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглах хугацаа дууссан, хана тааз нь энд тэндээсээ нурсан, мөөгөнцөртсөн, халаалтын систем доголдож дулаан алдагддаг, хүн амьдрах нөхцөлгүй хэмээн дүгнэгдсэн Дорнод аймгийн Хэрлэн, Хан-Уул, Баян-Уул, Цагаан-Овоо сумд, Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сум, Баян-Өлгий аймгийн Алтай сумын сургуулийн дотуур байруудад хүүхдүүдийг өдөр шөнөгүй гадуур хувцастай нь амьдруулж байгаа нь хүүхдийн амьд явах эрхийг бүхэлд нь зөрчиж байна.
- 1.4 Судалгаанд хамрагдсан бүх дотуур байранд гал гарах, ус үерт автах, газар хөдлөх, зуд болох зэрэг байгалийн болон хүний хүчин зүйлээс шалтгаалсан гамшиг тохиолдоход мөрдөх үйл ажиллагааны тодорхой төлөвлөгөө байхгүй, багаж хэрэгслээр хангагдаагүй, багш ажилтнууд, хүүхдүүд нь аюулаас урьдчилан сэргийлэх ойлголт мэдлэггүй, тэр ч байтугай аваарын хаалга, гарц, шатыг чөлөөлөөгүй байгаа явдал хүүхэд хамгааллын ноцтой зөрчил болж байна.
- 1.5 Дотуур байрандаа өөрийн гэсэн тусдаа халуун усгүй байр 56,3 хувь байна. Ийм нөхцөлд хүүхдүүд өөр өөрсдөө, тусгай цагийн хуваарьгүйгээр сумын халуун усанд ордог нь тэднийг элдэв гэмт хэрэгт өртөх, гадны нөлөөнд автах эрсдлийг дагуулж байна. Дотроо шүршүүртэй дотуур байрны хувьд зарим талаараа хүртээмжгүй, хүйтэн, хана нь цуурсан, мөөгөнцөрдсөн зэрэг чанарын шаардлага хангадаггүй байдал нь хүүхдийн эрүүл мэндэд аюултай, сөрөг нөлөө үзүүлэхээр байна.
- 2. Дотуур байрны хүний нөөцөд тавигдах шаардлагын талаарх дүгнэлт**
- 2.1 Дотуур байрны багш нь хамрагдаж буй хүүхдийн тооноос бус тухайн байрны ор, багтаамжид заагдсан тоонд дүйцүүлсэн тоогоор ажилладаг нь хүчин чадлаасаа олон хүүхэд хамруулсан байрны хувьд багшийн тоо хүрэлцээгүй байдалтай байна.
- 2.2 Дотуур байрны багшаар багш мэргэжилтэй хүн ажиллана гэсэн шаардлага хангагдаж байгаа ч, байрны багшийн ажлын үнэлгээ, үнэлэмж, цалин, нийгмийн баталгаа нь сургуульд хичээл заадаг багшаас доогуур тул, одоо ажиллаж байгаа дотуур байрны багш нар сургуульд нь өөрийн мэргэжлийн багшийн орон тоо гарахыг хүлээж, түр ажиллах сонирхолтой байдаг.
- 2.3 Дотуур байранд ажилладаг жижүүр, үйлчлэгч зэрэг албан тушаалтнуудыг хүүхэдтэй ажилах чиглэлээр ойлголт нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтанд нэг ч удаа хамруулдаггүй хэрнээ шөнийн ээлж, амралтын өдрүүдэд багш ажиллахгүй үед ч хүүхдийн хувь

заяаг даатгаж үлдээж байгаа нь НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай конвенцийн 3-р зүйлийн 3 дахь хэсгийг зөрчиж байна⁸³.

2.4 Дотуур байрын багш нарын ажилдаа сэтгэл ханамжтай байгаа эсэхийг тодруулахад багш нарын 90% нь сургуулийн гадна байгаа мэт дотоод мэдээлэл муутай, орчинд нь анхаарал тавьдгаас биш багш нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажлын ачааллыг харгалзан цалин урамшуулал олгох асуудал дээр сургуулийн захиргаа анхаардаггүй, багш уу, жирийн ажилтан уу гэдэг зааг ялгаагаа мэддэггүй гэх зэрэг дотуур байрны багшийн өөрийн үнэлэмжийн талаар ихэнх багш нар гомдолтой байгаа нь тогтвор суурьшилтай ажиллах хүсэл сонирхлыг хязгаарлаж байна.

2.5 Дотуур байрны багш нар Боловсролын тухай хууль, багшийн ёс зүйн дүрмээ сайн мэддэг ч, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргын тухай онолын болон практик ойлголт байхгүй, зөвхөн хүүхдэд гар хүрэх, сэтгэл санааны шийтгэл хэрэглэхгүй л байхад болно гэсэн нийтлэг ойлголттой байгаа нь тэдэнд хүүхдийн эрх, хамгаалал, хүмүүжлийн эерэг аргыг тухай мэдлэг олгох, хандлага төлөвшүүлэх сургалтууд нэн тэргүүнд шаардлагатай байна.

3. Хүүхдэд үзүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлагын талаарх дүгнэлт

3.1 Бүх байрны багш нар хүүхдийн

талаар хэрэгтэй мэдээллийг агуулсан дэлгэрэнгүй мэдээллийн сантай байсан нь хүүхэдтэй холбоотой ямар нэгэн бэрхшээл тулгарахад шийдвэрлэх боломжит мэдээлэл байсан нь сайшаалтай байлаа. Зарим багш нар хүүхдүүдийн зан төлөвийн судалгаа хийж, түүнийгээ хүүхэд бүрийн ялгаа, онцлогт тохируулан эерэг харилцаа тогтоодог нь цаашид дэлгэрүүлэх сайн туршлага болно гэж үзэж байна.

3.2 Хүүхдийн төрсний гэрчилгээ, Эрүүл мэндийн даатгалын дэвтэр зэрэг нийгмийн үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай бичиг баримтууд зарим нь хүүхдүүдэд, зарим нь эцэг эхэд нь байгаа байдал нь хүүхэд гэнэт өвдөж, эрүүл мэндийн үйлчилгээ авахад цаг хугацаа алдаж, эрүүл мэндийн эрсдэлд орох хүчин зүйл гэж үзэж байна.

3.3 Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх талаар хааяа гар зургийн, шатар даамны уралдаан зохиох, ном уншуулах зэргээс өөрөөр хүүхдийн идэвх оролцоог хангасан, орчин үеийн хүүхдийн сонирхолд нийцсэн, санаачлагатай ажиллаж байгаа сургууль, багш нар ховор байгаа тул дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хөгжих эрх нь хязгаарлагдаж байна.

3.4 Сургуулийн спорт заал дотуур байрны хүүхдүүдэд хаалттай гэж үзэж болно. Учир нь сургуулийн захиргаанаас тэдэнд хуваарилсан цаг нь билэгдлийн шинж чанартай, сургууль өөрөө ашиг олох зорилгоор тухайн цагт нь насанд хүрэгчдэд заалаа түрээслүүлдэг зөрчил нийтлэг байна.

⁸³ Оролцогч улсууд хүүхдийг халамжлах, хамгаалах үүрэг бүхий газар, албан байгууллагыг аюулгүй байдал, эрүүл мэндийн салбарт, ялангуяа ажилчдыг орон тоо, чадавхид хяналт тавих үүднээс эрх бүхий байгууллагаас тогтоосон жишигт нийцсэн нөхцөлөөр хангана. НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай конвенцийн 3-р зүйлийн 3 дахь хэсэг

- 3.5 Дотуур байранд мэргэжлийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйчийн хэрэгцээ байна. Хүүхдүүд гэрээ санах, уйтгарлах, гуниглах, үе тэнгийнхэн хоорондоо муудалцах үедээ 31% нь багшдаа хандахыг хүсдэг ч багш нь зав чөлөө муутай байдгаас дөнгөж 12,5% л хандаж зөвлөгөө авч чаддаг байна. Үлдсэн 87,5% нь үе тэнгийнхэнтэйгээ зөвлөлддөг байна.
- 3.5 Хүүхдүүдийн дунд амьдрах ухааны сургалт, ярилцлага явуулдаггүй нь сургалтын төлөвлөгөөгүй, багш нар энэ талын ойлголт мэдлэггүй, хүүхдүүд ямар сургалт болохыг мэдэхгүй байгаагаар нотлогдож байсан тул цаашид анхаарч, шийдвэрлэх асуудлын нэг гэж үзэж байна.
- 3.6 Хүүхэд хүүхдээ шоглох, нэр хоч өгөх, доромжлох, ялгаварлан гадуурхах зэрэг хүүхэд хамгааллын зөрчил нийтлэг байгаа ч, хүүхдүүд энэхүү байдлыг байх ёстой хэвийн үзэгдэл хэмээн үзэж, гомдоллосон нэгнийгээ “тоглоом даадаггүй” хэмээн тохуурхах явдал нийтлэг байна. Байрны хүүхэд зөрчил гаргасан тохиолдолд ангийн багш, нийгмийн ажилтан, байрны багш хамтарч асуудлыг шийдэх, асуудал гүнзгийрвэл, хүүхэд, эцэг эхийн оролцоотой захирлын дэргэдэх зөвлөлөөр асуудлыг шийдвэрлэдэг байдал нийтлэг байсан хэдий ч хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд ямар үе шаттай арга хэмжээ авах, хэрхэн шийдвэрлэх багш ямар үүрэгтэй, мэдлэгтэй байх талаар нарийн мэдлэг байхгүй байна.
- 3.7 Эцэг эхчүүдийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх тал дээр бүх сургуулийн захиргаа анхаарах

шаардлагатай байна. Тухайлбал, Зарим эцэг эхчүүд намар хүүхдээ цүнхтэй хувцсыг нь бариулаад, нутгийн унаа машинд дайгаад явуулдаг, хүүхэдтэй утсаар ярьж, хэрэгтэй мөнгө төгрөгийг мобайл банкаар, хувцасхунар эд зүйсийг хүнээр өгч явуулаад, сургууль багш нартай ямар ч харилцаагүй байдаг, хүүхэд нь өвдөж, эмийн зардал гарахад өгдөггүй гэх мэт бэрхшээл гардаг нь нийтлэг байсан бөгөөд, сургууль, эцэг эх, байрын багшийн гурвалсан гэрээгээ баталгаажуулаагүй байгаа явдал нь талуудын хамтын ажиллагаа байхгүйг харуулж байна. Ер нь хүүхэд хамгааллын асуудлын хүрээнд дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн эцэг эх, тухайн сургуулийн захиргаанд хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих эрх шилжүүлэх тухай эрх зүйн орчин байхгүй байгаа нь энэ мэт бэрхшээлийн шалтгаан болж байна гэж үзэж байна.

Санал, зөвлөмж

2008 онд БСШУ-ны сайд, ЭМ-ийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан ЕБС-ийн дотуур байрны үйлчилгээнд тавигдах нийтлэг шаардлагыг өнөөгийн нөхцөл байдалд тохируулан шинэчлэн өөрчлөх шаардлагатай байна. Үүнд:

1. Дотуур байрны үйлчилгээний орчинд тавигдах шаардлагын талаарх зөвлөмж

- 1.1 Дотуур байрны бие засах газрын хүртээмжийг нэмэгдүүлж, ариун цэвэр эрүүл ахуйн хяналтыг сайжруулах тал дээр сургуулийн захиргааны зүгээс анхааралдаа авах
- 1.2 Дотуур байрны гадна, дотор гэрэлтүүлгийг байнгын байлгах

- асуудал дээр тухайн сургуулиуд анхааралдаа авах
- 1.3 Мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглах хугацаа дууссан, хана тааз нь энд тэндээсээ нурсан, мөөгөнцөртсөн, халаалтын систем доголдож дулаан алдагддаг, хүн амьдрах нөхцөлгүй хэмээн дүгнэгдсэн дотуур байруудын судалгааг БШУЯ гаргаж, шинэ байр бариулах ажлыг төсөвт тусгуулах
 - 1.4 Дотуур байрны багш, ажиллагсдыг “Гамшгийн үеийн хүүхэд хамгаалал” сэдэвт сургалтанд хамруулах ажлыг БШУЯ, мэргэшсэн ТББ-уудтай хамтран зохион байгуулах
- 2. Дотуур байрны хүний нөөцөд тавигдах шаардлагын талаарх санал, зөвлөмж**
- 2.1 Дотуур байрны багшийн тоог нэмэгдүүлж, ажлын бус цагаар ч хүүхдүүд багштай хамт байх боломжийг бүрдүүлэхэд бодлогыг боловсруулах, шаардагдах хөрөнгө санхүүгийн тооцоо, үндэслэлийг гаргаж, төсөвт суулгах асуудлыг БШУЯ судлах, шийдвэрлэх
 - 2.2 Дотуур байрны багшаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйч мэргэжилтэй хүнийг ажиллуулах, цалин, нийгмийн асуудлыг багшийнхтай ижил түвшинд байлгах боломжийг БШУЯ судалж, шийдвэрлэх
 - 2.3 Дотуур байранд ажилладаг жижүүр, үйлчлэгч зэрэг албан тушаалтнуудыг хүүхэдтэй ажилах чиглэлээр ойлголт нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтанд хамруулах ажлыг тухайн орон нутгийн Боловсролын хэлтэс, Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтэс, мэргэшсэн ТББ-ууд зохион байгуулах
 - 2.5 Дотуур байрны багш нарыг хүүхдийн эрх, хамгааллын асуудлаар мэргэшүүлэх сургалтанд хамруулах
- 3. Хүүхэд үзүүлэх үйлчилгээнд тавигдах шаардлагын талаарх санал, зөвлөмж**
- 3.1 Хүүхэд хамгааллын асуудлын хүрээнд дотуур байранд амьдарч байгаа хүүхдүүдийн эцэг эх, тухайн сургуулийн захиргаанд хүүхдийг асран хамгаалах, харгалзан дэмжих эрх шилжүүлэх тухай эрх зүйн орчныг бий болгоход БШУЯ санаачилгатай ажиллаж, холбогдох хуулийн төслийг боловсруулж, батлуулах
 - 3.2 Хүүхдийн төрсний гэрчилгээ, Эрүүл мэндийн даатгалын дэвтэр зэрэг нийгмийн үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай бичиг баримтуудыг байрын багш эцэг эхээс хүлээн авч, найдвартай хадгалах журмыг бий болгох.
 - 3.3 Хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх үйл ажиллагааны хуваарыг сургуулийн заах аргын нэгдлээр хэлэлцүүлж батлуулж, мөрдөж байх
 - 3.4 Сургуулийн спорт заал дотуур байрны хүүхдүүдэд нээлттэй болгох.
 - 3.5 Хүүхдүүдийн дунд амьдрах ухааны сургалт явуулах сургалтын модуль боловсруулах
 - 3.6 Хүүхэд хүүхдээ шоглох, нэр хоч өгөх, доромжлох, ялгаварлан гадуурхах зэрэг хүүхэд хамгааллын зөрчил нийтлэг байгаа арилгах ажлыг хүүхдийн оролцоотой байнга зохион байгуулж, өөрөө өөрийгөө хамгаалах чадварыг суулгах

ХҮҮХДИЙН ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ: ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ №12

Өмнөх үг:

2014 оны 11 дүгээр сард дэлхийн хүүхдүүд, эцэг эх болон нийт иргэд, байгууллага, засгийн газруудын хамтаар НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц батлагдсаны 25 жилийн ойг тэмдэглэж байна. Бусад тэмдэглэлт өдрүүдийн адилаар, энэ ой нь өнгөрсөн хугацааны турш Конвенцид заасан үүрэг хариуцлагын хүрээнд хувь хүн, байгууллага, улс орон бүрийн хүүхдийн төлөө, хүүхэдтэй хамт хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг дүгнэн цэгнэх, дахин авч үзэх цаг хугацааны сорилт болж байна.

НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хороо нь Конвенц болон нэмэлт протоколуудын хэрэгжилтэд хяналт тавих үүрэгтэй бөгөөд засгийн газруудын тайланг хэлэлцэх, дүгнэлт зөвлөмж өгөх үйл явцаар дамжуулан хүүхдийн эрхийг ханган хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээний заавар удирдамжийг өгдөг. Иймд тус Хорооны Ерөнхий зөвлөмжүүд нь Хүүхдийн эрхийн тухай конвенцоор баталгаажсан эрхийг тайлбарлах албан ёсны тайлбар бөгөөд

конвенцийн хэрэгжилтийг үндэсний хэмжээнд хангах, тайлагнах үүргээ биелүүлэхэд нь гишүүн орнуудад дэмжлэг үзүүлэх зорилготой байдаг. Энэ утгаараа Ерөнхий зөвлөмж нь олон улсын хүний эрхийн эрх зүйн хөгжил, үндэсний хууль тогтоомжийг боловсронгуй болгоход ихээхэн чухал хэрэглэгдэхүүн болдог билээ.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Хүүхдийн Эрхийн Хорооны 2009 оны 51 дүгээр чуулганаар батлагдсан “Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх: Ерөнхий зөвлөмж №12”-ийн үндсэн агуулгыг Хүний эрх сэтгүүлийн уншигч та бүхэнд толилуулж байна. Сэтгүүлийн энэ дугаарт Ерөнхий зөвлөмж №12-ийн бүрэн текстийг нийтлэлгүй, хэсэгчлэн оруулсан болохыг анхаарна уу. Ерөнхий зөвлөмж №12-ийн НҮБ-ын албан ёсны хэлээр гаргасан бүрэн текстүүдийг дараах холбоосоос татаж авна уу.

www.ohchr.org/_layouts/treatybodyexternal/Download.aspx?symbolno=CRC%2fC%2fGC%2f12&Lang=en

Нэгдсэн Үндэстний Байгууллага



Хүүхдийн эрхийн тухай конвенц

CRC

ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖ

№ 12 (2009)

Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх
CRC/C/GC/12

*Хүүхдийн Эрхийн Хорооны 51 дүгээр чуулган
Женев хот, 2009 оны 05 дугаар сарын 25- ны өдрөөс 06 дугаар сарын 12-ны өдөр*

Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12 дугаар зүйлд:

“1. Оролцогч улсууд өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө.

2. Энэ зорилгоор өөртэй нь холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцүүлэхэд шууд, эсхүл үндэсний хууль тогтоомжид заасан журмын дагуу төлөөлөгчөөр буюу зохих байгууллагаар дамжуулан үг хэлэх бололцоог хүүхдэд олгоно.” хэмээн заасан байна.

I. УДИРТГАЛ

1. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 12 дугаар зүйл нь хүний эрхийн гэрээний онцгой заалт бөгөөд нэг талаар насанд хүрэгсдээс бүрэн хараат бус, нөгөө талаар эрх эдлэгч субъект болохын хувьд хүүхдийн эрх зүйн болон нийгмийн байдлыг тодорхойлоход чиглэсэн байна. 12 дугаар зүйлийн нэг дэх хэсэг өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхэд бүрийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд

зохих ач холбогдол өгөх тухай заасан байдаг. Харин хоёр дахь хэсэгт өөртэй нь холбоотой асуудлыг тухайлбал шүүх буюу захиргааны журмаар хэлэлцүүлэхэд хүүхдэд үг хэлэх эрх олгох талаар тусгасан байдаг.

2. Бүх хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх болон тэдний үгийг нухацтай анхааран үзэх нь уг Конвенцийн тулгуур үнэт зүйлсийн нэгийг бүрдүүлдэг. Хүүхдийн Эрхийн Хороо нь энэхүү 12 дугаар зүйлийг Хүүхдийн эрхийн тухай конвенцийн хүүхдийг алагчлахгүй байх, эсэн мэнд орших, хөгжих, хүүхдийн ашиг сонирхлыг дээдлэх зэрэг үндсэн дөрвөн зарчмын нэг мөн хэмээн тодорхойлсон. Энэ заалт нь зөвхөн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хуульчлаад зогсохгүй бусад бүх эрхүүдийг тайлбарлах, хэрэгжүүлэхэд онцгой ач холбогдолтой юм.
3. Конвенцийг 1989 онд баталснаас хойш тус 12 дугаар зүйлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд хууль эрх зүй, бодлого, аргачлалыг боловсруулах үйл явцад орон нутаг, үндэсний, бүс нутаг болон дэлхийн түвшинд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарсан. Сүүлийн үед энэ зүйлийн хэрэгжилттэй холбоотой нэгэн практик үйл ажиллагаа ихэд дэлгэрч байгаа бөгөөд хэдийгээр 12 дугаар зүйлд үгчлэн ороогүй ч “оролцоо” хэмээх ойлголтыг өргөн утгаар нь хэрэглэж

байна. Энэхүү нэр томъёог харилцан бие биенээ хүндэтгэсний үндсэн дээр хүүхдүүд болон насанд хүрэгсдийн хооронд өрнөх харилцан яриа, мэдээлэл солилцох үйл ажиллагааг тайлбарлахад хэрэглэдэг бөгөөд ингэх явцад хүүхдүүд өөрсдийнхөө үзэл бодлыг илэрхийлж сурахаас гадна насанд хүрэгсэд мөн тэднийг анхааралтай сонсож, түүнд ач холбогдол өгч, энэ нь эргээд үйл явцын үр дүнд нөлөөлдөг байна.

4. Оролцогч улсууд 2002 онд хүүхдийн асуудлыг авч хэлэлцсэн Ерөнхий Ассамблейн 27 дугаар тусгай чуулган дээр тус 12 дугаар зүйлийг хэрэгжүүлэх амлалтаа дахин баталгаажуулсан билээ.⁸⁴ Гэсэн хэдий ч Хүүхдийн эрхийн хорооноос цохон тэмдэглэснээр дэлхийн ихэнх улс орнуудад өөртэй нь холбогдох төрөл бүрийн асуудлаар хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх, мөн түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгдөг болоход улс төрийн болон эдийн засгийн хүндрэлээс эхлээд олон жил амь бөхтэй оршсон буруу дадал хэвшил, сөрөг хандлага зэрэг олон саад бэрхшээл тулгарсаар байна. Олон хүүхдүүд эрхээ эдэлж чадахгүй байгаа бөгөөд Хорооноос ялангуяа тодорхой бүлгийн хүүхдүүд, тухайлбал бага насны охид, хөвгүүд мөн түүнчлэн эмзэг бүлэгт хамаардаг хүүхдүүдийг үзэл бодлоо илэрхийлэх эрхээр хангахад тодорхой саад бэрхшээлүүд учирсаар байгааг хүлээн зөвшөөрдөг. Түүнчлэн Хороо нь одоог хүртэл амь бөхтэй оршсоор байгаа ихэнх дадал хэвшлийн талаар сэтгэл зовнисон хэвээр байна. Тийм учраас тус 12 дугаар зүйлд заасан хэм хэмжээг сайтар тайлбарлан таниулах, хүүхэд бүрийг энэ

эрхээр бүрэн хангах талаар илүү сайн ойлголттой болгох шаардлагатай байна.

5. 2006 онд тус Хорооноос 12 дугаар зүйлийн утга, түүний ач холбогдол, конвенцийн бусад зүйлүүдтэй хэрхэн холбогдох ба ялгагдах талаар хэлэлцэх, энэхүү заалтыг амжилттай хэрэгжүүлэхийн тулд нэн тэргүүнд шийдэх асуудлууд, сайн туршлагаас хуваалцах зорилгоор хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар нэг өдрийн ерөнхий хэлэлцүүлгийг зохион байгуулсан юм.⁸⁵ Энэхүү ерөнхий зөвлөмжид тухайн хэлэлцүүлгийн үеэр хүүхдүүдийг өөрсдийг нь оролцуулан харилцан солилцсон мэдээлэл, Хороонд оролцогч улсуудаас ирүүлсэн тайланг хянаж дүгнэхэд хуримтлуулсан туршлага, Засгийн газар, төрийн бус байгууллагууд, олон нийтийн байгууллагууд, хөгжлийн агентлагууд болон хүүхдүүд өөрсдөө 12 дугаар зүйлээр хуульчлагдсан эрхийг практикт хэрхэн хэрэгжүүлж байгаа тэргүүн туршлага, санал санаачилга зэргийг багтаасан болно.
6. Уг ерөнхий зөвлөмжийн А бүлэгт эхлээд тус 12 дугаар заалтын хоёр хэсгийн хууль зүйн тайлбар, дараа нь уг эрхийг бүрэн хэрэгжүүлэхэд, ялангуяа хүүхэдтэй холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцэхэд хүлээх үүргүүдийг тайлбарлана. Харин Б бүлэгт, уг 12 дугаар зүйлийн Конвенцийн ерөнхий зарчмууд болон бусад зүйлүүдтэй хэрхэн холбогдох тухай авч үзнэ. В бүлэгт янз бүрийн нөхцөл, орчинд хүүхдийг үг хэлэх эрхээр хангахад тавигдах шаардлагууд болон үр нөлөөний тухай дурдана. Г бүлэгт уг эрхийг хэрэгжүүлэхэд тавигдах үндсэн шаардлагуудыг авч үзэх бол Д

84 НҮБ-ын Ерөнхий Ассамблейн тогтоол S-27/2 "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц", 2002 он.

85 Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар хэлэлцсэн 2006 оны ерөнхий хэлэлцүүлгийн зөвлөмжийг доорх хаягаар орж үзнэ үү: http://www2.ohchr.org/english/bodies/crc/docs/discussion/Final_Recommendations_after_DGD.doc.

бүлэгт дүгнэлт багтсан байна

7. Хороо нь оролцогч улсуудад хандан энэхүү ерөнхий зөвлөмжийг Засгийн газар, захиргааны бүтцээрээ дамжуулан хүүхдүүд болон иргэний нийгэмд тайлбарлан таниулах ажлыг өргөнөөр зохион байгуулахыг санал болгож байна. Ингэхийн тулд энэхүү зөвлөмжийг тус тусын хэлнээ хөрвүүлж, мөн хүүхдэд ойлгоходхялбархувилбарыг боловсруулж, уг эрхийн цаад ач холбогдлыг хэлэлцэх, хэрхэн үр нөлөөтэй хэрэгжүүлэх талаар семинар, уулзалт зохион байгуулах, улмаар хүүхэдтэй болон хүүхдийн төлөө ажилладаг бүх мэргэжилтнийг сургах сургалтын хөтөлбөрт оруулах шаардлага урган гарч байна.

II. ЗОРИЛТУУД

8. Энэхүү ерөнхий зөвлөмжийн гол зорилт нь 12 дугаар зүйлийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд оролцогч улсуудыг дэмжихэд оршино. Үүний тулд:
- Засгийн газрууд, оролцогч талууд, төрийн бус байгууллагууд болон өргөн утгаараа нийгэмд уг 12 дугаар зүйлийн утга агуулга, ач холбогдлын талаарх ойлголтыг бэхжүүлэх
 - Тус 12 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, бодлогын зохицуулалтыг төгөлдөржүүлэх, практик үйл ажиллагааны хамрах хүрээг тэлэх
 - Хорооноос мониторинг хийсэн туршлагад үндэслэн 12 дугаар зүйлийн хэрэгжилтэнд нөлөөлөх эерэг хандлагуудад онцгой анхаарал хандуулах
 - Хүүхдийн өөртэй нь холбоотой бүх асуудлаар илэрхийлсэн үзэл бодолд

зохих ач холбогдол өгөх зохистой арга замыг эрэлхийлэх, түүнд тавигдах үндсэн шаардлагуудыг санал болгох хэрэгтэй байна.

III. ХУВЬ ХҮҮХДИЙН БОЛОН БҮЛЭГ ХҮҮХДИЙН ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ

9. Энэхүү Ерөнхий зөвлөмжийн агуулгын бүтцийг тус Хорооноос хувь хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх болон бүлэг хүүхдийн (тухайлбал сургуулийн нэг ангид сурдаг, нэг байранд хөрш зэргэлдээ оршин суудаг, тухайн орны хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, зөвхөн охидын гэх мэт) үзэл бодлоо илэрхийлэх эрх гэж хоёр тусад нь салгаж үзсэний дагуу боловсруулсан юм. Ийнхүү тусад нь ялгаж заагласны учир нь Конвенцид оролцогч улсууд нь хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан хүүхдийг үзэл бодлоо илэрхийлэх эрхээр хангахыг хуульчилсан байдагтай холбоотой юм. (12 дугаар зүйлийн 1, 2 дугаар хэсэгт хийсэн хууль зүйн тайлбарыг харар).
10. Хүүхдийн нас болон төлөвшлийн байдал гэсэн нөхцөлийг хувь хүүхэд болон бүлэг хүүхдүүд өөрсдийн үзэл бодлоо илэрхийлж буй тухайн үед үнэлж болно. Хүүхдийн нас болон төлөвшлийн байдлыг тухайн бүлэг хүүхдүүд тогтвортой оршин буй аль нэг бүтцийн бүрэлдэхүүн хэсгийн хувьд, тухайлбал гэр бүл, сургуулийн анги эсвэл хөрш оршин суугчид байвал үнэлэхэд боломжтой. Харин олон тооны хүүхдүүд байх, янз бүрийн бүлгийн хүүхдүүд хамтдаа үзэл бодлоо илэрхийлж буй тохиолдолд илүү төвөгтэй болдог. Хэдийгээр хүүхдийн

нас болон төлөвшлийн байдлыг тогтооход хүндрэл учирдаг ч, оролцогч улсууд нь хүүхдүүдийн үгийг тодорхой бүлгийн төлөөллийн санал хэмээн авч үзвэл зохилтой. Хорооны зүгээс оролцогч улсуудад хандан хүүхдийн үзэл бодлыг анхааралтай сонсож, хамт олноороо үзэл бодлоо илэрхийлсэн бол түүнийг нь хүлээн авахад бүхий л хүчин чармайлт гаргахыг онцлон санал болгож байна.

11. Оролцогч улсууд хүүхдийг өөрийн үзэл бодолтой байхыг хөхиүлэн дэмжиж, хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хэрэгжүүлэх боломжтой орчинг бүрдүүлэх ёстой.
12. Хүүхдийн илэрхийлж буй үзэл бодол дээр холбогдох мэдлэгийн цар хүрээ, туршлага нэмэгдэж болох бөгөөд түүнийг нь шийдвэр гаргах, бодлого боловсруулах, хууль санаачлах, аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд болон тэдний санаа бодолд үнэлэлт өгөхөд харгалзан үзэх нь зүйтэй.
13. Дээрх үйл явцыг ихэвчлэн ОРОЛЦОО гэж нэрлэдэг. Иймд хүүхэд эсхүл бүлэг хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилт нь энэхүү үйл явцын амин чухал хэсэг юм. Оролцоо гэдгийг хүүхдийн амьдралтай холбоотой бүхий л асуудлаар бодлого, хөтөлбөр, арга хэмжээ боловсруулахад хүүхдүүдийг зөвхөн түр хугацаагаар оролцуулсан болоод өнгөрөх бус, харин хүүхдүүд болон насанд хүрэгсэд үзэл бодлоо харилцан солилцох гарааны цэг байх ёстой хэмээн ойлгох нь онцгой ач холбогдолтой юм.
14. Энэхүү Ерөнхий зөвлөмжийн А бүлэгт (Хууль зүйн тайлбар) Хорооноос хувь хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн талаар авч үзсэн бол В бүлэгт

(Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг янз бүрийн нөхцөл байдалд хэрэгжүүлэх нь), Хороо нь хувь хүүхдийн болон бүлэг хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хоёуланг нь харгалзан үзсэн болно.

А. ХУУЛЬ ЗҮЙН ТАЙЛБАР

15. Конвенцийн 12 дугаар зүйл нь хүүхэд бүрийг өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах бөгөөд хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан өөрийн үзэл бодолд зохих ач холбогдол өгүүлж, анхаарал хандуулуулах эрхтэй болохыг тунхагласан юм. Уг эрхээр хангахын тулд оролцогч улсууд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүлээн зөвшөөрч, үзэл бодолд нь зохих ач холбогдол өгч хэрэгжүүлэх хуулиар заасан тодорхой үүрэг хүлээнэ. Энэхүү үүргийг биелүүлэхийн тулд оролцогч улсууд өөрийн хууль, эрх зүйн тогтолцоонд нийцүүлэн энэ эрхийг шууд баталгаажуулах, өмнөх хуулиа эргэн харах эсхүл шинээр хууль боловсруулж батлах шаардлагатай бөгөөд ингэснээр хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх бүрэн хэрэгжих юм.
16. Гэхдээ хүүхэд энэ эрхээ заавал хэрэгжүүлэх үүрэг хүлээхгүй. Үзэл бодлоо илэрхийлэх эсэх нь тухайн хүүхдийн хувьд өөрийнх нь сонголт болохоос зайлшгүй биелүүлэх үүрэг биш. Оролцогч улсууд нь хүүхдийг өөрийн дээд ашиг сонирхлын төлөө зайлшгүй шаардлагатай бүх мэдээлэл, зөвлөгөө авч, шийдвэр гаргах бололцоогоор хангана.
17. 12 дугаар зүйл нь Конвенцийн ерөнхий

зарчим болохын хувьд Оролцогч улсууд нь Конвенцид заагдсан бусад эрхүүд, хэм хэмжээг тайлбарлах, хэрэгжүүлэх явцдаа удирдлага болговол зохистой.⁸⁶

18. 12 дугаар зүйл нь хүүхэд зөвхөн өөрийн эмзэг байдал (хамгаалалт) эсхүл насанд хүрэгсэдээс хараат байх (хангамж) байдлаас үүдсэн эрх эдлэхээс гадна мөн өөрийн амьдралд нөлөө үзүүлдэг тийм эрх эдлэх эрхтэй болохыг тунхаглаж өгсөн.⁸⁷ Конвенцид хүүхдийг эрх эдлэгч субъект хэмээн хүлээн зөвшөөрсөн бөгөөд оролцогч улсууд гарын үсэг зурж баталгаажуулсан, дэлхийн бараг бүх улс орон нэгдсэн энэхүү олон улсын баримт бичгийн 12 дугаар зүйлд хүүхдийн энэхүү статуст онцгойлон ач холбогдол өгсөн байдаг.

1. 12 дугаар зүйлийн хэл зүйн тайлбар

(а) 12 дугаар зүйлийн нэг дэх хэсэг

(i) “хангах болно” заавал биелүүлэх заалт

19. 12 дугаар зүйлийн нэг дэх хэсэг оролцогч улсууд хүүхдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээр хангах болно хэмээсэн. “Хангах болно” гэсэн тусгай хүч нэмэгдүүлсэн хуулийн хэллэг нь оролцогч талуудад дур зоригоор хандах эрх байхгүй болохыг илтгэдэг. Тийм учраас оролцогч улсууд бүх хүүхдийн төлөө энэ эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л шаардлагатай арга хэмжээг авах хатуу үүрэг хүлээж

байна. Хүүхдийн өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх болон түүнд нь ач холбогдол өгөх механизмыг зөв бүрдүүлэх зорилгоор энэ үүрэг нь хоёр бүрэлдэхүүн хэсгийг өөртөө агуулдаг.

(ii) “Өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий”

20. Оролцогч улсууд нь өөрийн үзэл бодолтой байх чадвар бүхий хүүхдийг үзэл бодлоо илэрхийлэх эрхээр хангана гэж заасан. Энэ хэллэгийг ямар нэгэн хязгаарлалт мэтээр ойлгож болохгүй бөгөөд харин ч оролцогч улсуудын хувьд хүүхдийн хараат бус үзэл бодол төлөвшүүлэх чадварыг үнэлэхдээ боломжит хамгийн өргөн утгаар нь үнэлэх үүрэг хүлээнэ хэмээн ойлговол зохилтой. Энэ нь оролцогч улсууд хүүхдийг өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадваргүй хэмээн урьдчилан бодож болохгүй гэсэн үг юм. Харин эсрэгээр, Оролцогч улсууд хүүхэд өөрийн үзэл бодлоо төлөвшүүлэх чадвартай бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ хүлээн зөвшөөрдөг, мөн өөрөө эхэлж энэ чадвараа батлах албагүй гэдгийг ухамсарласан байвал зүйтэй.
21. Хорооноос 12 дугаар зүйлд заасны дагуу хүүхдийг үзэл бодлоо илэрхийлэх эрхээр хангахад насны ямар нэг хязгаарлалт байх ёсгүй гэдгийг онцлон анхааруулахын зэрэгцээ, оролцогч улсууд хуулиар эсхүл практик дээр хүүхэд өөртэйгээ холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо илэрхийлэхэд аливаанасны хязгаартавихыг дэмжихгүй болно. Үүнтэй холбогдуулан, Хороо нь доорх зүйлд онцгой ач холбогдол өгч байна. Үүнд:

⁸⁶ Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг хэрэгжүүлэх ерөнхий үйл ажиллагаануудын тухай Хорооны ерөнхий зөвлөмж No. 5 (CRC/GC/2003/5)-ыг үзнэ үү. (2003).

⁸⁷ Конвенцийг англиар гурван “P” гэж холбон тайлбарлах нь бий. Үүнийг монголчилбол “хууль тогтоомж,” “хамгаалалт”, “оролцоо” гэсэн утгатай болно.

- Нэгдүгээрт, 2004 онд зохион байгуулагдсан хүүхдийн эрхийг бага наснаас нь эхлэн хэрэгжүүлэх тухай ерөнхий хэлэлцүүлгийн дараах өдөр Хорооноос гаргасан зөвлөмжинд хүүхдийг эрх эдлэгч болох утгаар нь “хүүхдийг бага наснаас нь эхлэн өдөр тутмын амьдралд нь хэвшүүлэх...” хэмээн цохон тэмдэглэсэн.⁸⁸ Судалгаагаар хүүхэд бүр бага наснаасаа эхлэн үзэл бодлоо төлөвшүүлж, илэрхийлэх чадвартай нь тогтоогдсон. Тэр бүү хэл, үгээр илэрхийлж чадахгүй үедээ ч өөрийн үзэл бодолтой бодолтой байдаг ажээ.⁸⁹ Тийм учраас, 12 дугаар зүйлийг бүрэн хэрэгжүүлэхийн тулд бага насны хүүхдүүдийн өөрсдийн ойлголт, сонголт, дээд ашиг сонирхлоо илэрхийлэн зурсан зураг, харилцааны үгэн бус хэлбэр болох нүүрний хувирал, биеийн хөдөлгөөн, тоглоомыг хүртэл хүлээн зөвшөөрч, хүндэтгэлтэй хандах шаардлага гардаг.
- Хоёрдугаарт, хүүхэд өөртэй нь холбоотой бүх асуудлын талаар бүрэн ойлголт, мэдлэгтэй байх шаардлагагүй хэдий ч хүүхэд тухайн асуудлаар өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх талаар хангалттай ойлголттой байдаг.
- Гуравдугаарт, оролцогч улсууд нь өөрсдийн үзэл бодлоо хүргэхэд бэршээлтэй тулгарч буй хүүхдүүдийг эрхээ хэрэгжүүлэхэд нь багалгаа гаргах үүрэг хүлээнэ. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэхэд нь шаардлагатай харилцах хялбар арга замыг бүрдүүлэх, тоног төхөөрөмжөөр хангах, ашиглаж сургах нь зүйтэй.

Эцэст нь, оролцогч улсууд энэхүү эрхийг практикт буруу хэрэгжүүлбэл ялангуяа бага насны хүүхдүүд тухайлбал гэмт хэрэг, бэлгийн дарамт, хүчирхийлэл, бусад хэлбэрийн доромжлол, ёс бус харьцаа гэх мэт боломжит сөрөг үр дагаварууд гарахыг онцгойлон анхаарах ёстой. Оролцогч улсууд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хүүхдийг бүрэн аюулгүй байдалд хамгаалахад шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

(iii) “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх”

22. Хүүхэд “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” эрхтэй. “Чөлөөтэй” гэдэг нь хүүхэд өөрийн үзэл бодлоо ямар ч дарамт шахалтгүй илэрхийлэх, мөн үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх эсэхээ өөрөө шийдэх эрхтэй гэсэн үг юм. Мөн “чөлөөтэй” гэдэг нь хүүхдийг элдэв зохисгүй нөлөөлөл, дарамтад оруулах, хууран мэхэлж өөрийн сонирхолд нийцүүлэн ашиглахыг хориглоно. Цаашид “чөлөөтэй” гэдгийг хүүхдийн өөрийнх нь мэдлэгийн цар хүрээтэй нь холбон үзэх хэрэгтэй бөгөөд хүүхэд бусдын үзэл бодлыг бус зөвхөн өөрийнхөө үзэл бодлыг илэрхийлэх эрхтэй хэмээн ойлговол зохино.
23. Оролцогч улсууд нь хүүхэд өөрийг нь хүндэтгэсэн, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхэд нь аюулгүй, хувийн болон нийгмийн нөхцөл, орчин бүрдүүлэх ёстой.

88 CRC/C/GC/7/Rev.1, para. 14.

89 Cf. Lansdown G., “Хүүхдийн хөгжин буй чадавхи”, Innocenti Судалгааны төв, НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САН/ Save the Children, Florence (2005).

24. Хорооноос ялангуяа хүнд ноцтой гэмт хэрэг, онцгой байдлыг мөрдөн шалгах явцад хүүхдээс зайлшгүй гэж үзэхүйц байдлаас хэтрүүлж олон удаа байцаалт, мэдүүлэг авахгүй байхыг онцгойлон анхааруулж байна. Учир нь “байцаалт авах” нь хүүхдэд хожим нь маш сөрөг нөлөө үзүүлж болохуйц үйл явц юм.
25. Хүүхдийн үзэл бодлыг сонсох үүрэг бүхий хүмүүс, мөн тэдний эцэг эх эсхүл асран хамгаалагч нар нь түүнд тухайн асуудлын талаар хийх сонголт, гарах шийдвэр, гарах үр дагаврын талаар хүүхдэд мэдээлэх шаардлагатай. Түүнчлэн ямар нөхцөл байдалд түүнээс үзэл бодлоо илэрхийлэхийг хүсч байгаа талаар хүүхдэд мэдээлэх ёстой. Иймд мэдээлэл олж авах эрх нэн чухал юм. Учир нь энэхүү эрх нь хүүхэд тодорхой шийдвэр гаргахад тавигдах урьдчилсан нөхцөл болж өгнө.

(iv) “Өөртэй нь холбоотой бүх асуудлаар”

26. Оролцогч улсууд хүүхдийг “өөртэй нь холбоотой бүх асуудлаар” үзэл бодлоо илэрхийлэх бололцоогоор бүрэн хангах ёстой. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хоёрдахь нөхцөлийг тодорхойлдог. Хүүхдийн өөртэй нь холбоотой асуудлаар илэрхийлсэн үзэл бодлыг анхааралтай сонсох ёстой. Энэ үндсэн нөхцөлийг хүндэтгэн үзэж, өргөн утгаар нь ойлговол зохилтой.
27. Хүүхдийн эрхийн тухай конвенцийн эхийг боловсруулсан Хүний Эрхийн Комиссын байгуулсан Нээлттэй Ажлын Хэсэг эдгээр асуудлыг хүүхдийн эсхүл хүүхдүүдийн үзэл бодлыг хэмээн зааглан тодорхойлох ёстой хэмээсэн анхны саналаас татгалзсан болно.

Түүний оронд, хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх нь “өөртэй нь холбоотой бүх асуудлаар” байх нь зүйтэй хэмээн шийдсэн. Хорооноос нь тухайн асуудал хүүхэдтэй өөртэй нь шууд холбоотой, хүүхэд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвартай байгаа нь илэрхий илт байсан ч ихэнх хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдөж байгааг эмзэглэн хүлээн авдаг. “Асуудлыг” хэмээх нэр томъёог Конвенцид ил дурьдаагүй ч өргөн утгаар нь хэрэглэхийг дэмжиж байсан ба ерөнхий бүрэн эрх гэсэн санаа биш болохыг тодотгох зорилгоор “өөртэй нь холбоотой” гэж тодруулах нь зүйтэй хэмээн Хороо үзсэн болно. Гэсэн хэдий ч бодит байдал дээр тухайлбал Хүүхдийн төлөө Дэлхийн дээд хэмжээний уулзалтаас харахад хүүхэдтэй холбоотой асуудлыг өргөн утгаар нь ойлгох нь тэднийг амьдарч байгаа орчин, нийгэмтэй хамт авч үзэхэд тус дөхөм болох нь харагдаж байна. Тийм учраас, оролцогч улсууд хүүхдийн мэдлэгийн хүрээ нь тухайн асуудлыг шийдвэрлэхэд чанарын нөлөө үзүүлэхээр бол бүх тохиолдолд хүүхдийн үзэл бодлыг анхааралтай сонсох нь зүйтэй.

(v) “Хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгнө”

28. Хүүхдийн үзэл бодолд “нас, төлөвшлийн байдлыг нь харгалзан зохих ач холбогдол” өгөх ёстой. Энэхүү заалт нь хүүхдийн үзэл бодолд зохих ач холбогдол өгөх зорилгоор чадварыг нь үнэлэх эсхүл тухайн үйл явдлын үр дүнд нөлөөлөхүйц байдлаар харилцах ёстой болохыг хэлж байна. 12 дугаар зүйлд

- заасны дагуу хүүхдийн үг хэлэхийг зүгээр сонсох нь хангалтгүй бөгөөд өөрийн үзэл бодлоо илэрхийлэх чадвар бүхий хүүхдийн хувьд түүний үзэл бодолд нухацтай хандах шаардлагатай.
29. 12 дугаар зүйлд заасанчлан хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан үзэж түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгөхийг үүрэг болгосон нь хүүхдийн нас дангаараа түүний үзэл бодлын үнэ цэнийг тодорхойлж чадахгүй болохыг тодорхой зааж өгсөн. Хүүхдийн аливаа юмс үзэгдлийг ухаарч ойлгох түвшин нь тэдний биологийн настай хөдөлшгүй холбоотой гэсэн үг биш юм.
- Судалгаанаас харахад хүүхдийн үзэл бодол төлөвшин бүрэлдэх чадварыг хөгжүүлэхэд мэдээлэл, туршлага, орчин, нийгмийн болон соёлын хүлээлт, түүнийг дэмжих байдал зэрэг нь бүгд цогц байдлаар тодорхой хувь нэмэр оруулдаг байна. Иймээс хүүхдийн үзэл бодлыг тухайн тохиолдол бүрд нийцсэн зохистой шалгуураар үнэлэх ёстой.
30. Төлөвшлийн байдал гэдэг нь тухайн асуудлын цаад утга, холбогдлыг үнэлэн дүгнэх, ойлгох чадвартай байх гэсэн үг бөгөөд үүнийг хүүхдийн бие хүний чадавхийг тодорхойлоход харгалзан үзэх шаардлагатай. Төлөвшлийн байдлыг тодорхойлоход хүндрэлтэй боловч 12 дугаар зүйлд заасанчлан энэ нь тухайн асуудлаар өөрийн үзэл бодлоо бие дааж, ул суурьтай илэрхийлэх чадвар гэж тодорхойлогдоно. Тухайн асуудал хүүхдэд хэрхэн нөлөөлж буйг мөн харгалзан үзэх шаардлагатай. Хүүхдийн амьдралд сайн нөлөө илүү үзүүлэх тусам тухайн хүүхдийн төлөвшлийн байдалд зохих үнэлгээ нь илүү холбоотой болдог.
31. Мөн хүүхдийн хөгжиж буй чадавхи болон эцэг эхийн зүгээс өгч буй чиглэл, удирдамжийг мөн харгалзан үзэх хэрэгтэй. (В бүлгийн дор байгаа 84 дүгээр хэсгийг харарх).
- (b) 12 дугаар зүйлийн 2 дугаар хэсэг**
- (i) “Өөртэй нь холбоотой асуудлыг шүүх буюу захиргааны журмаар хэлэлцүүлэхэд” үзэл бодлоо илэрхийлэх эрх**
32. 12 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт өөртэй нь холбоотой асуудлыг ялангуяа шүүх буюу захиргааны журмаар хэлэлцүүлэхэд үг хэлэх бололцоог хүүхдэд олгох тухай тусгайлан зааж өгсөн.
- Хорооноос энэ заалт нь хүүхэдтэй холбоотой шүүхийн бүх ажиллагаанд хязгаарлалтгүйгээр тухайлбал эцэг эх нь гэрлэлтээ цуцлуулах, асрамжинд авах, халамж ба үрчлэх, хууль зөрчсөн хүүхэд, биений болон сэтгэл зүйн хүчирхийлэл, бэлгийн дарамт болон бусад гэмт хэргийн хохирогч болсон хүүхэд, эрүүл мэндийн тусламж, нийгмийн халамж, дагалдах хүнгүй хүүхэд, орогнол хүссэн хүүхэд, дүрвэгч хүүхдүүд, зэвсэгт мөргөлдөөн болон бусад гамшиг, хүнд онцгой байдлын хохирогч болсон бүх хүүхдүүдийг нэгэн адил үгээ хэлэх бололцоогоор хангахыг онцлон тэмдэглэж байна. Захиргааны журмаар нийтлэг хэлэлцэх асуудалд тухайлбал хүүхдийн боловсрол, эрүүл мэнд, орчин, амьдралын нөхцөл эсхүл хамгаалалтын арга хэмжээний талаар гаргах аливаа шийдвэрийг хамааруулан үзнэ. Дээрх хоёр төрлийн асуудал хэлэлцэх журам нь зөрчлийг шийдвэрлэх хувилбарт зохицуулалтууд буюу тухайлбал зуучлал

- болон арбитрын аргыг хэрэглэж болно.
33. Хүүхдийн өөрийнх нь нэхэмжлэлээр үүсгэсэн тухайлбал хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцсан тухай гомдол, сургуулиас хөөсөн тухай өргөдөл, бусад хүмүүсийн нэхэмжлэлээр үүссэн эцэг эх нь гэрлэлтээ цуцлуулах эсвэл үрчлэлт гэх мэт хүүхэдтэй холбогдох асуудлаарх шүүх буюу захиргааны ажиллагааны үед хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх хэрэгжих ёстой. Оролцогч улсуудыг шүүх эсхүл захиргааны журмын хэрэг шийдвэрлэхэд холбогдох эрх мэдэл бүхий этгээдээс хүүхдийн үзэл бодлыг харгалзан үзэх, хүүхдэд ямар ач холбогдолтой болохыг тайлбарлахыг шаардах эрх зүйн орчинг бүрдүүлэхийг бүх талаар дэмжинэ.
34. Хүүхэд заналхийлсэн, дайсагнасан, үл тоомсорлосон эсхүл тухайн хүүхдийн насанд үл тохирох орчинд үзэл бодлоо бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй. Шүүх буюу захиргааны ажиллагаа нь хүүхдэд тохирсон мөн хүртээмжтэй байх ёстой. Хүүхдэд ээлтэй мэдээлэл, тохирох өөрийн өмгөөлөл, хүүхэдтэй ажиллаж мэргэшсэн боловсон хүчин, шүүх танхимын дотоод засал, шүүгч болон хуульчдын өмсгөл, үзэгдэх байдал болон тусгай хүлээлгийн өрөө зэрэг нөхцөлөөр хангасан байхад онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.
- (ii) **“Шууд, эсхүл төлөөлөгчөөр буюу зохих байгууллагаар дамжуулан”**
35. Хүүхэд үзэл бодлоо илэрхийлэхээр шийдсэний дараа “шууд, эсхүл төлөөлөгчөөр буюу зохих байгууллагаар дамжуулан” үзэл бодлоо илэрхийлэхээ шийдэх хэрэгтэй. Хорооноос боломжтой бол аль ч ажиллагааны үед хүүхдийг өөрөө шууд үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангах нь зүйтэй гэж зөвлөдөг.
36. Төлөөлөгч гэдэг нь хүүхдийн эцэг эх хоёр (эсхүл аль нэг нь), хуульч, эсхүл бусад хүмүүс (ниймийн ажилтан гэх мэт) байж болно. Гэсэн хэдий ч ихэнх хэргүүд дээр (иргэний, эрүүгийн эсхүл захиргааны) хүүхэд болон түүний гарцаагүй төлөөлөгч (эцэг эх хоёр, эсвэл аль нэг нь) хоёрын хооронд ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэл гардаг гэдгийг анхаарах хэрэгтэй. Хэрэв төлөөлөгчөөр дамжуулахаар болсон тохиолдолд тухайн төлөөлөгч шийдвэр гаргагчид хүүхдийн үзэл бодлыг үнэн зөв хүргэсэн байх нь онц чухал юм. Тухайн нөхцөл байдлын дагуу хүүхэд өөрөө (эсхүл зохих байгууллага) чухам ямар аргыг сонгохоо шийдэх нь зүйтэй. Төлөөлөгчид нь шийдвэр гаргах үйл явцын талаар олон талын мэдлэг, ойлголттой байхаас гадна хүүхэдтэй ажиллах туршлагатай байх ёстой.
37. Тухайн төлөөлөгч нь бусад хүмүүс (хүүхдийн эцэг эх хоёр эсхүл аль нэг нь), байгууллага эсхүл холбогдох этгээдийн (тухайлбал оршин суух байр, захиргаа эсхүл сургуулийн) эрх ашгийг бус дан ганц хүүхдийн эрх ашгийг дээдлэн төлөөлж байгаа гэдгээ ямагт хатуу санах ёстой. Хүүхдийн үзэл бодлыг төлөөлөн илэрхийлэхээр томилогдсон төлөөлөгчийн баримтлах зарчим, үг дамжуулах журам/дүрмийг боловсруулах нь зүйтэй юм.

(iii) “Үндэсний хууль тогтоомжид заасны дагуу”

38. Төлөөлөгчид олгогдох боломжууд нь үндэсний хууль тогтоомжид заасны дагуу байх ёстой. Гэхдээ энэхүү байдал нь хүүхдийн үндсэн эрхийн хэрэгжилтийг боомилох буюу хязгаарладаг процессийн эрх зүйг ашиглахыг зөвшөөрсөн хэмээн ойлгогдохгүй байвал зохино. Харин ч эсрэгээр нь, оролцогч улсуудыг зүй зохистой ажиллагааны үндсэн дүрмүүдийг хатуу мөрдөх тухайлбал өмгөөлөх эрх, өөрийн хавтаст хэрэгтэй танилцах эрхээр хангахыг дэмжинэ.
39. Уг ажиллагааны үед баримтлах журам зөрчигдвөл, шүүхийн эсхүл захиргааны эрх мэдэлтний гаргасан шийдвэр нь маргаантай гарч болох бөгөөд хүчингүй болгох, өөрчлөх эсхүл дахин шалгах аар буцаагдаж болзошгүйг анхаарах ёстой.

2. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх алхмууд

40. 12 дугаар зүйлийн дээрх хоёр заалтад заасны дагуу өөртэй нь холбоотой асуудлаар эсхүл албан ёсны бусад үйл ажиллагаанд хүүхдийг үзэл бодлоо илэрхийлэхээр урих үед уг эрхээр үр нөлөөтэй хангах зорилгоор дараах таван алхмыг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Эдгээр шаардлагуудыг доорх байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй.

(a) Бэлтгэл ажил

41. Хүүхдийн үзэл бодлыг сонсох үүрэг бүхий албаны хүмүүст хүүхдэд өөртэй нь холбоотой бүх асуудлаар, ялангуяа шүүх буюу захиргааны ажиллагааны

шийдвэр гаргах явцад үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд гаргах шийдвэрт хүүхдийн үзэл бодол нөлөөлөх тухай танилцуулсан байх ёстой. Цаашилбал, хүүхэд шууд харилцах эсхүл төлөөлөгчөөр дамжуулах эсэхээ өөрөө сонгох эрхтэй болохыг хүүхдэд мэдэгдэх ёстой. Мөн энэ сонголтын болзошгүй үр дагаварын тухай хүүхэд мэдэж байх нь зүйтэй. Шийдвэр гаргагч нь хүүхдийг мэдүүлэг өгөхийн өмнө бэлдэх хэрэгтэй бөгөөд хэзээ, хаана, хэрхэн түүнээс мэдүүлэг авах, хэн хэн оролцохыг тайлбарлахын сацуу энэ талаар тэдний санаа бодлыг сонсож, түүнийг анхааралдаа авна.

(b) Хүүхдээс мэдүүлэг авах

42. Хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эрхээ эдлэх орчин нь дэмжсэн, эрх олгосон байх ёстой бөгөөд хүүхдийн үгийг сонсох үүрэг бүхий насанд хүрсэн этгээд нь түүнийг анхааралтай сонсох хүсэлтэй байгаагаа, түүний хэлэхээр шийдсэн зүйлийг нухацтай харгалзан үзнэ гэдгээ илэрхийлж байх хэрэгтэй. Хүүхдийн үзэл бодлыг сонсох үүрэг бүхий этгээд гэдэгт хүүхэдтэй холбоотой асуудалд оролцох насанд хүрсэн хүнийг (тухайлбал багш, нийгмийн ажилтан эсхүл асрагч), байгууллагын шийдвэр гаргагч (тухайлбал, захирал, захиргааны ажилтан эсхүл шүүгч), мөн мэргэжилтэн (тухайлбал, сэтгэл судлаач эсхүл эмч) хэлнэ.
43. Туршлагаас харахад нэг талыг барьсан байцаалт гэхээс илүү энгийн хүүрнэх ярианы хэлбэрээр өрнөх нөхцөл нь илүү үр дүнтэй байдаг. Боломжтой бол,

хүүхдийн үгийг нээлттэй шүүх хурал дээр бус хаалттай шүүх хурал хийж сонсох нь зүйтэй.

(с) Хүүхдийн чадварыг үнэлэх

44. Хүүхдийн үзэл бодолд зохих ач холбогдол өгөх ёстой бөгөөд тухайн тохиолдлуудад хийсэн судалгаагаар хүүхэд бүр өөрийн үзэл бодолтой байх чадвартай болохыг тогтоосон. Хүүхэд өөрийн үзэл бодлоо хүлээн зөвшөөрөхүйц, бие даасан байдлаар илэрхийлж байвал шийдвэр гаргагч хүүхдийн үгийг тухайн асуудлыг шийдэхэд шийдвэрлэх хүчин зүйл хэмээн авч үзэх шаардлагатай. Хүүхдийн чадварыг үнэлэх арга замыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

(d) Хүүхдийн үзэл бодолд зохих ач холбогдол өгсөн тухай мэдээлэл (үнэлэлт, эргэх холбоо)

45. Хүүхэд өөрийнх нь үзэл бодолд зохих ач холбогдол өгч байгаад сэтгэл хангалуун байхын тулд шийдвэр гаргагч нь тухайн хүүхдэд үйл явцын үр дүнгийн талаар мэдээлэх, түүний үзэл бодлыг хэрхэн харгалзан үзсэн талаар тайлбарлах ёстой. Ийм үнэлэлт, эргэх холбоо нь хүүхдийн үзэл бодлыг албаны шугамаар сонсоод өнгөрсөн бус түүнийг нухацтай анхааралдаа авсны баталгаа болно. Ийм мэдээлэл авсан хүүхэд шалгаж шаардах, санал нийлэх эсхүл өөр санал тавих шүүх буюу захиргааны журмаар шийдсэн бол давж заалдах эсхүл гомдол гаргаж болно.

(e) Гомдол гаргах, шүүхээс хохирлыг

барагдуулах, зөрчигдсөн эрхийг сэргээх нь

46. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх зөрчигдсөн, мөн үзэл бодолд нь зохих ач холбогдол өгөөгүй гэж үзвэл гомдол гаргах, шүүхээр олгосон эрхээ хэрэгжүүлэх тийм эрх зүйн таатай орчин бүрдүүлэх шаардлагатай. Хүүхдүүд өөрсдийн гомдлоо омбудсмен буюу гомдлыг шийдвэрлэх байгууллага, албан тушаалтан эсхүл бүх хүүхдийн байгууллагууд, сургууль болон цэцэрлэгт мөн түүнтэй дүйцэх хүнд хандан гомдол гаргах боломжтой байх нь зүйтэй. Хүүхдүүд тэдгээр хүмүүсийг хэн болох, хэрхэн үнэлэх талаар мэдэж байх хэрэгтэй. Гэр бүлийн доторх зөрчил, маргаантай холбоотой асуудлаар тухайн орны хүүхэд залуучуудын байгууллагад хандах нь зүйтэй.

47. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх шүүх болон захиргааны ажиллагааны үед зөрчигдсөн эрхээ сэргээлгэхээр (12 дугаар зүйл, 2 дахь хэсэг) хүүхэд давж заалдах эсхүл гомдол гаргах эрхээр хангагдсан байх ёстой. Гомдол гаргах ажиллагаа нь хүүхэд хүчирхийлэлд өртөх эсхүл шийтгүүлэх эрсдэлгүй, найдвартай зохицуулалттай байх ёстой.

3. Оролцогч улсуудын хүлээх үүргүүд

(a) Оролцогч улсуудын хүлээх үндсэн үүргүүд

48. Оролцогч улсууд нь хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилтийн дагуу тэдний үзэл бодолд зохих ач холбогдол өгсөн талаар тохирох мэдээлэл, зохих дэмжлэг, шаардлагатай бол үнэлэлт, эргэх холбоо тогтоох

болон тэдний гомдол гаргах, шүүхээр олгогдсон эрх, хохирлоо барагдуулах зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжоо эргэн хянан магадлах, эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах үүрэг хүлээнэ.

49. Дээрх үүргийг биелүүлэхийн тулд, оролцогч улсууд нь доорх стратегийг баримтлах нь зүйтэй. Үүнд:

- 12 дугаар зүйлд харшилсан, хязгаарласан аливаа хууль тогтоомжийг хянан үзэх ба хүчингүй болгох
- Хараат бус хүний эрхийн байгууллагуудыг байгуулах, жишээлбэл хүүхдийн гомдлыг хүлээн авдаг омбудсмен, хүүхдийн эрхийн бүрэн эрх бүхий элч нар⁹⁰
- 12 дугаар зүйл, түүнийг практикт хэрэгжүүлэх талаар хүүхэдтэй болон хүүхдийн төлөө ажилладаг бүх мэргэжилтнүүд тухайлбал хуульч, шүүгч нар, цагдаа, нийгмийн ажилтнууд, олон нийтийн ажилтнууд, сэтгэл судлаачид, асрагч нар, байрны болон шоронгийн харгалзагчид, боловсролын салбарын бүх түвшний багш нар, эмнэлгийн эмч, сувилагч, бусад мэргэжилтнүүд, төрийн албаны ажилтнууд, хоргодох байрны ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах нь зүйтэй.
- Хүүхдийг үзэл бодлоо илэрхийлэхийг дэмжих, урамшуулахад тохиромжтой нөхцөлийг бүрдүүлэх болон тэдний үзэл бодолд ач холбогдол өгөх тухай заалтыг хууль, тогтоомж болон байгууллагын дотоод журамд албан

⁹⁰ 2002 оны Хорооны ерөнхий зөвлөмж No. 2 (2002) Бие даасан хараат бус хүний эрхийн байгууллагууд

ёсоор тусгаж баталгаажуулах, түүний хэрэгжилтийг үр дүнтэй эсэхэд үнэлгээ байнга хийлгэх нь чухал. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд саад болж буй сөрөг хандлагуудтай тэмцэх олон нийтийн кампанит ажил, тухайлбал олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр нэр хүндтэй удирдагч нарын үзэл бодлыг сонсох, хүүхдийн тухай нийтэд өргөн тархсан буруу үзэл, дадал, хэвшлийг өөрчлөх зэрэг ажлуудыг зохион байгуулах

В. Үзэл бодлоо илэрхийлэх эрх Конвенцийн бусад заалтуудтай холбогдох нь

68. 12 дугаар зүйл нь ерөнхий зарчим болохынхоо хувьд Конвенцийн бусад ерөнхий зарчмууд болох 2 дугаар зүйл (алагчлагдахгүй байх эрх), 6 дугаар зүйл (эсэн мэнд амьдрах, хөгжих эрх) ялангуяа 3 дугаар зүйл (хүүхдийн дээд ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих) нь шууд харилцан холбоотой юм. Мөн 12 дугаар зүйл нь иргэний эрх, эрх чөлөөний тухай зүйлүүдтэй ялангуяа 13 дугаар зүйл (үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх) болон 17 дугаар зүйл (мэдээлэл олж авах эрх)-тэй салшгүй уялдаатай. Цаашилбал, 12 дугаар зүйл нь Конвенцийн бусад бүх зүйлүүдтэй зайлшгүй холбогдох юм. Учир нь хүүхдийг Конвенцийн тус тусын заалтуудад хуульчлагдсан эрх, түүний хэрэгжилтийн талаар өөрийн үзэл бодол бүхий субъект болохыг хүлээн зөвшөөрөхгүйгээр тэдгээр эрх бүрэн утгаар хэрэгжих бололцоогүй юм.

С. Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг төрөл

бүрийн орчин, нөхцөл байдалд хэрэгжүүлэх нь

89. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх нь хүүхдийн өсөн бойжих, хөгжих, сурах төрөл бүрийн байгууллага, нөхцөлд байдалд ч хэрэгжих ёстой. Эдгээр орчин болон нөхцөл байдалд хүүхэд болон хүүхдийн үүргийн талаар өөр өөр ойлголт байдаг бөгөөд эдгээр нь өдөр тутмын асуудал, гаргах шийдвэрт хүүхдийн оролцоог дэмжих эсвэл хязгаарлаж болох юм. Оролцогч улсууд нь хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийн хэрэгжилтэнд нөлөөлөх төрөл бүрийн арга хэмжээнд хүүхдийн оролцоог ашиглаж болох юм.

1. Гэр бүлийн орчинд

90. Гэр бүл бол бага наснаас эхлэн хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж болох, тэдэнд ач холбогдол өгөх, улмаар олон нийт, нийгэмд энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд бэлтгэдэг чухал орчин юм.¹⁴ Эцэг эхийн асрамж нь хувь хүний хөгжилд тус болох, гэр бүлийн харилцааг өргөжүүлэх улмаар хүүхдүүдийн нийгэмших үйл явцыг дэмжих болон гэр бүлийн орчинд бүх хэлбэрийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх үүрэг гүйцэтгэдэг.
91. Конвенцид хүүхдийг зохих чиглэл, удирдамжаар хангахын тулд (84 дүгээр хэсгийг харах) эцэг эх эсхүл бусад хууль ёсны асран хамгаалагч нарын эрх үүргийг хүлээн зөвшөөрдөг боловч, хүүхдэд үзэл бодлоо илэрхийлэх эрх олгосон байхыг онцлон тэмдэглэдэг бөгөөд хүүхдийн тийм чадварыг хөгжүүлэхэд нийцүүлэн удирдан чиглүүлэхийг шаарддаг.
92. Оролцогч улсууд нь хууль болон бодлогоор дамжуулан эцэг эх, асран хамгаалагч, хүүхэд асрагч нарыг хүүхдийн үгийг сонсох мөн тэдэнтэй холбоотой асуудлаар үзэл бодолд нь зохих ач холбогдол өгөхийг урамшуулах нь зүйтэй. Эцэг эхчүүдийг хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх, нийгмийн бүх шаг давхаргад тэдний үгэнд зохих ач холбогдол өгүүлэх талаар дэмжихийг зөвлөдөг.
93. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэдэг эцэг эхийн хандлагыг хөгжүүлэх, урьд нь бүрэлдэн тогтсон эерэг зан үйл, хандлага дээр тулгуурласан, мөн Конвенцид тунхагласан хүүхдүүд болон эцэг эхийн эдлэх эрхийн талаар мэдээллийг түгээх зорилгоор эцэг эхчүүдэд зориулсан боловсролын хөтөлбөрүүдийг боловсруулахыг Хорооноос санал болгож байна.
94. Тэдгээр хөтөлбөрүүд нь дор дурдсан зүйлд хандсан байх хэрэгтэй. Үүнд:
- Эцэг, эх, хүүхдүүдийн хоорондын харилцан хүндэтгэсэн харьцаа
 - Шийдвэр гаргахад оролцох хүүхдийн оролцоо
 - Гэр бүлийн гишүүн бүрийн үзэл бодолд зохих анхаарал хандуулахын утга холбогдол
 - Хүүхдийн хөгжин буй чадвар, чадамжийг ойлгож, хөхиүлэн дэмжиж, хүндэтгэх
 - Гэр бүлийн зөрчлийг зохицуулах арга замуудыг тусгасан байвал зохино.
95. Эдгээр хөтөлбөрүүд мөн хөвгүүд ба охидууд тэгш эрхтэйгээр үзэл бодлоо илэрхийлэх гэсэн зарчмыг баталгаажуулсан байх ёстой.
96. Олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд хүүхдийн оролцоо нь хүүхдүүдэд өөрсдөд нь болон тэдний гэр бүл,

цаашилбал нийгэмд асар их үнэ цэнэтэй болохыг эцэг, эхчүүдэд тайлбарлан таниулахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх ёстой.

3. Эрүүл мэндийн үйлчилгээнд

98. Конвенцийн заалтын хэрэгжилт нь хүүхдийн эрүүл өсөн бойжих, хөгжихийг хөхиүлэн дэмжихэд оролцох болон энэ талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэн үзэхийг шаарддаг. Энэ нь хувь хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой аливаа шийдвэрүүд болон мөн төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого болон үйлчилгээг боловсронгуй болгоход хүүхдийг оролцуулахад нэгэн адил хамаатай.
99. Хорооноос хүүхдийн эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой практик болон шийдвэрт хүүхдийг оролцуулахтай холбогдуулан харгалзан үзэх хоорондоо ялгаатай боловч холбоотой хэд хэдэн асуудлууд байгааг тодорхойлсон.
100. Бүх хүүхдүүд, бага насныхныг оролцуулан тэдний хөгжин буй чадавхид нийцсэн байдлаар шийдвэр гаргах ажиллагаанд оролцуулах нь зүйтэй. Тэдэнд хийх эмчилгээ, үзүүлэх нөлөө болон үр дүнгийн талаар мэдээллээр хангах нь зүйтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тэдэнд тохирсон болон хүртээмжтэй хэлбэрээр мэдээлэл өгөх нь зүйтэй.
101. Оролцогч улсууд нь хүүхдийн аюулгүй байдал, сайн сайхны төлөө эцэг эхийн зөвшөөрлийг авалгүйгээр, наснаас нь хамааралгүй эмнэлгийн нууц зөвлөгөө авах хууль эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх хэрэгтэй. Жишээлбэл хүүхэд гэртээ хүчирхийлэл эсхүл дарамтын нөхцөлд байгаа, нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол эсхүл эмнэлгийн үйлчилгээ авах тал дээр хүүхэд болон эцэг эхийн хооронд зөрчил үүссэн үед хэрэгтэй юм. Зөвлөгөө, зөвлөмж авах эрх нь эмнэлэгт зөвшөөрөл өгөх эрхээс ялгаатай бөгөөд ямар ч насны хүүхэд хүртэхэд хязгаарлалт тавих учиргүй.
102. Хорооноос зарим улсад зөвшөөрөл өгөх эрхийг тодорхой насны хүүхдэд шилжүүлдэг туршлагыг талархан хүлээн авч оролцогч улсуудыг ийм хуулийг санаачлахыг дэмжиж байна. Тийм учраас тухайн наснаас дээш насны хүүхдүүд бие даасан, шаардлага хангасан шинжээчтэй зөвлөлдсөний дараа хувийн чадавхийн талаар гаргасан мэргэжлийн үнэлгээг шаардахгүйгээр өөрөө зөвшөөрөл өгөх эрхийг эдэлнэ. Гэсэн хэдий ч хорооноос бага насны хүүхэд нь түүний эмчилгээний талаар мэдээллээр үзэл бодлоо илэрхийлэх чадавхитайгаа харуулж чадсан бол түүний үзэл бодолд ач холбогдол өгнө гэж тусгасан.
103. Эмч нар болон эрүүл мэндийн төвүүд нь хүүхдийн эмчилгээний талаарх судалгаа, эмнэлгийн туршилтанд тэдний оролцоотой холбоотой тодорхой мэдээллийг олж авах боломжоор хангах нь зүйтэй. Хэрэв судалгааны талаар мэдээлэх бол тэдний мэдэгдсэн зөвшөөрлийг бусад процедурын хамгаалалт дээр нэмж олж авч болно.
104. Оролцогч улсууд нь хүүхдийн эрүүл мэнд болон хөгжлийн талаарх үйлчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэхдээ хүүхэд өөрийн санал болон туршлагад үндэслэн хувь нэмрээ оруулах боломж олгохуйц арга хэмжээг авч явуулна. Тэдний үзэл бодол нь эмнэлгийн үйлчилгээний хангамж, тухайлбал

ямар үйлчилгээ хэрэгцээтэй байгаа, хаана хэрхэн хамгийн сайнаар хангах, үйлчилгээг авахад саад хийдэг ялгаварлан гадуурхал, эмнэлгийн ажилтнуудын чанар ба хандлага, өөрийн эрүүл мэнд болон хөгжилд тавих хариуцлагын түвшинг нэмэгдүүлэх хүүхдийн чадавхийг хөхиүлэх дэмжихэд тустай. Ийм мэдээллийг жишээ нь, үйлчилгээ, зөвлөгөө авсан, эсхүл судалгаанд оролцсон хүүхдүүдээс үнэлэлт дүгнэлт өгүүлж болохоос гадна энэ мэдээллийг хүүхдийн эрхийг хүндэтгэсэн эмнэлгийн үйлчилгээний стандарт болон үзүүлэлтүүдийг боловсруулахад орон нутгийн эсхүл үндэсний хүүхдийн зөвлөл, парламентад шилжүүлж болно.⁹¹

4. Боловсрол ба сургуулийн орчинд

105. Боловсролын салбарт хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүндэтгэн үзэх нь сурч боловсрох эрхийн хэрэгжилтийн суурь үндэс болдог. Хорооноос тэмдэглэхдээ өнөөдөр дарангуйлал, ялгаварлан гадуурхал, үл хүндэтгэл болон хүчирхийлэл нь олон сургууль, ангийн бодит байдал, дүр зургийг тодорхойлж байна. Ийм орчинд хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх, түүнд нь ач холбогдол өгөхөд тохиромжтой бус гэдэг нь хэн бүхэнд ойлгомжтой юм.
106. Хорооноос оролцогч улсуудад хүүхдүүдийг эдгээр асуудалтай холбоотой үзэл бодлоо илэрхийлэх, түүнд нь зохих ач холбогдол өгүүлэх бололцоогоор хангахад шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг санал

болгож байна.

107. Боловсролын бүх орчинд, тухайлбал бага насныханд зориулсан боловсролын хөтөлбөрүүдэд ч гэсэн хүүхдийн идэвхитэй оролцоог хөхиүлэн дэмжих нь зүйтэй.⁹² Сургах болон сурахад хүүхдийн ирээдүйн хэтийн төлөв болон амьдралын нөхцөл байдлыг анхааралдаа авах шаардлагатай. Энэ зорилгоор, боловсролын бодлого тодорхойлогч нар сургалтын хөтөлбөр боловсруулахдаа хүүхдүүд болон эцэг эхийн үзэл бодлыг тусгах ёстой.
108. Хүний эрхийн боловсрол нь тухайн хүүхэд бусад хүүхэд болон насанд хүрэгсэдтэй хамтдаа сурч, тоглож, амьдардаг, хүний эрх жинхэнэ утгаар хэрэгждэг орчинд хүүхдийн зан үйл болон урам зоригийг өдөөж, төлөвшүүлж чадна.⁹³ Ялангуяа, эдгээр байгууллагуудад хүүхдүүд өөрсдөө Конвенцид тунхагласан хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх, тэдний үзэл бодолд зохих ач холбогдол өгсөн эсэхэд ажиглалт хийдэг, шүүмжлэлтэй ханддаг чаддаг байх ёстой.
109. Хүүхдийн оролцоо нь хүүхэд төвтэй, интерактив сургалтанд шаардлагатай хамтын ажиллагаа, хоёрын талын дэмжлэгийг өдөөдөг, анги танхимд хамт олонч уур амьсгал бүрдүүлэхэд их чухал юм. Хүүхдийн үзэл бодолд ач холбогдол өгөх нь ялангуяа ялгаварлан гадуурхахыг таслах зогсоох, зодож шийтгэх болон сахилга батын арга хэмжээ авахаас урьдчилан сэргийлэхэд онцгой ач холбогдолтой юм. Хороо нь

91 Хорооноос гаргасан Ерөнхий зөвлөмж No. 3 (2003)-д анхаарал хандуулахыг хүсч байна. ДОХ ба хүүхдийн эрхийн талаарх 11 ба 12 дахь хэсгүүд, мөн Ерөнхий зөвлөмж No. 4 (2003) Өсвөр үеийнхний эрүүл мэндийн тухай, 6 дахь хэсэг

92 "Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага: Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үйл ажиллагааны хүрээ ба боловсрол дахь эрхүүд", НҮБ-ЫН ХҮҮХДИЙН САН/UNESCO (2007).

93 Хүүхдийн эрхийн хороо, Ерөнхий зөвлөмж No. 1 (2001) Боловсролын зорилтын тухай (Конвенцийн 29 дүгээр зүйл, 1 дэх хэсэг), (CRC/GC/2001/1).

- үе тэнгийнхний сургалт, зөвлөлгөө, туслалцааг өргөжүүлэхийг уриалж байна.
110. Шийдвэр гаргах үйл явцад хүүхдийн байнгын оролцоог жишээлбэл ангийн зөвлөл, сурагчийн зөвлөл, сургуулийн удирдлага дахь сурагчдын төлөөллөөр дамжуулан зөвлөл болон хороон дээр сургуулийн бодлого, зан үйлийн дүрэм зэргийг хэлэлцэхэд өөрсдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх замаар хангаж болно. Эдгээр эрхийг хуульчилж өгөх шаардлагатай, ингэснээр түүнийг хэрэгжүүлэх эсэх нь тухайн эрх мэдэлтэн, сургуулийн удирдлага болон эрхлэгч багш нарын сайн дурын асуудал бус, заавал хэрэгжүүлэх заалт болно.
111. Сургуулийн гадуур, оролцогч улсууд орон нутгийн болон үндэсний хэмжээнд боловсролын бодлоготой холбоотой бүхий л асуудлаар тухайлбал боловсролын тогтолцооны хүүхдэд ээлтэй байх чанар, сургалтын албан ба албан бус хэлбэрүүд, сургалтын хөтөлбөр, заах арга зүй, сургуулийн бүтэц, стандарт, төсөв болон хүүхэд хамгааллын тогтолцооны талаар хүүхдүүдтэй зөвлөлдөх нь зүйтэй.
112. Хорооноос оролцогч улсуудад хандан хүүхдэд боловсролын салбарт оролцох үүргээ чадвартайгаар хэрэгжүүлэхэд туслэх зорилготой байгуулагдсан сурагчдын бие даасан байгууллагуудын хөгжлийг дэмжихийг уриалж байна.
113. Дараагийн шатны сургуульд шилжих, эсхүл хаана, хэрхэн сурах тухай сонголт хийх үед гаргах аливаа шийдвэр нь хүүхдийн ашиг сонирхлыг дээд зэргээр хөндөж байгаа гэсэн утгаар нь ийм нөхцөлд хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг баталгаажуулсан байх ёстой. Гарсан шийдвэрийг захиргааны эсхүл шүүхийн хяналтанд харгалзан үзэх ёстой. Мөн түүнчлэн, сахилга баттай холбоотой асуудлын талаар хүүхэд үзэл бодлоо илэрхийлэх эрхийг бүрэн хүндэтгэх ёстой. Ялангуяа сургууль, сургалтын байгууллагаас хасах арга хэмжээ авсан тохиолдолд энэ шийдвэрийг шүүхээр хүүхдийн сурах эрхийг зөрчсөн эсэхийг хянуулж, шалгуулах ёстой.
114. Хорооноос олон оронд хүүхдүүд болон өсвөр үеийнхнийг нийгэмд идэвхитэй үүрэг гүйцэтгэх, улс эх орондоо хариуцлагатай иргэн болон төлөвшихөд бэлдэх интерактив, халамжилсан, хамгаалсан, идэвхитэй оролцсон тийм орчныг бүрдүүлэхийг эрмэлзсэн хүүхдэд ээлтэй сургалтын хөтөлбөрийг нэвтрүүлж байгааг талархан хүлээн авч байгаа.
- 5. Тоглоом, чөлөөт цаг, спорт болон соёлын арга хэмжээний үед**
115. Хүүхдүүдийн хөгжил, нийгэмших үйл явцад тоглох, зугаацах, амрах, биеийн тамир болон соёлын арга хэмжээнүүд зайлшгүй чухал шаардлагатай. Эдгээр арга хэмжээг зохион байгуулахдаа хүүхдийн дур сонирхол, чадавхийг харгалзан үзэх нь зүйтэй. Үзэл бодлоо илэрхийлэх чадвар бүхий хүүхдүүдтэй тоглох, амралт чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх газрын хүртээмжийн талаар харилцан ярилцах нь зүйтэй. Албан ёсны зөвлөлдөх үйл ажиллагаанд оролцох боломжгүй бага насны хүүхдүүд болон зарим хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд тэдэнд хүсэл сонирхлоо илэрхийлэх тусгай бололцоогоор хангах нь чухал.

6. Ажлын байранд

116. Хөдөлмөрийн насны доод хязгаарын тухай болон Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц No. 138 (1973) ба 182 (1999)-д зөвшөөрснөөс доош насны хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдүүдийн үгийг тэдний үзэл бодол, ашиг сонирхлыг олж мэдэх үүднээс хүүхдэд ээлтэй орчинд сонсох ёстой. Ингэх нь тэдгээр хүүхдийн хөдөлмөрлөж буй эдийн засаг болон нийгэм-тогтолцооны хязгаарлалтууд мөн соёлын орчинг харгалзан үзэж, байдлыг сайжруулах талаарх шийдлийг эрж хайхад орших ёстой.
117. Хөдөлмөр эрхэлж буй хүүхдийн эрхийг зохих хуулиар хамгаалах ёстой бөгөөд ажиллах нөхцөл болон ажлын байр нь хөдөлмөрийн хуульд нийцсэн эсэхэд мэргэжлийн байцаагч нар хяналт тавих ёстой. Хүүхдүүд өөрсдөө эсхүл Хөдөлмөр эрхлэгч хүүхдүүдийн эвсэл, холбоо, төлөөлөгч нараар дамжуулан Хөдөлмөрийн тухай хуулийг хэлэлцэх эсхүл хүчин төгөлдөр байгаа эрх зүйн хэм хэмжээг эргэн хянаж үзэх, үнэлэлт дүгнэлт өгөхөд дуу хоолойгоо хүргэх нь зүйтэй.

7. Хүчирхийллийн нөхцөл байдал

118. Конвенцид хүүхдийг бүх хэлбэрийн хүчирхийллээс хамгаалагдах эрхээр хангасан бөгөөд оролцогч улсууд нь хүүхэд бүрийг ялгаварлан гадуурхаж, алагчлахгүйгээр энэ эрхээр хангах үүрэг хүлээдэг. Хорооноос оролцогч улсуудыг хууль эрх зүйн, бодлого, боловсролын болон бусад үйл ажиллагаанд хүүхдүүдийг оролцуулж, тэдэнтэй

зөвлөлдөхийг дэмжиж байна. Ялангуяа, эмзэг бүлэгт хамаардаг, тухайлбал мөлжлөгөд өртсөн, гудамжны эсвэл дүрвэгч хүүхдүүдийг хууль, эрх зүй болон бодлогын холбогдох асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх зорилгоор зохиогдох зөвлөлдөх үйл ажиллагаанаас хасахгүй байх тал дээр онцгой анхаарал хандуулах ёстой.

119. Үүнтэй холбогдуулан, Хорооноос Ерөнхий нарийн бичгийн даргын Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тухай судалгааны үр дүнг талархан хүлээн авч, улмаар оролцогч улсуудад хандан энэхүү зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх, ялангуяа энэ зөвлөмжид хүүхдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хүүхдийн эсрэг хүчирхийллээс хамгаалах, тайлан болон үнэлгээтэй холбоотой бүх асуудлаарх тэдний үзэл бодолд зохих ач холбогдол өгөхөд онцгой анхаарал хандуулахыг уриалж байна.⁹⁴
120. Хүүхдийн эсрэг үйлдэгдсэн ихэнх хүчирхийлэлд хүүхдүүд тодорхой хэлбэрийн хүчирхийллийн зан үйлийг байх ёстой зан үйл хэмээн хүлээн зөвшөөрдөг, эсхүл үгээ хэлэх, мэдээлэх хүүхдэд ээлтэй механизмыг бүрдүүлээгүй гэсэн үндсэн хоёр шалтгааны улмаас ямар ч арга хэмжээ авдаггүй өнгөрдөг байна. Жишээлбэл, хүүхдүүдэд бие махбодын шийтгэл, зодуур, бэлэг эрхтний гэмтэл эсвэл эрт гэрлэлт гэх мэт амссан доромжлол, хүчирхийллийн талаар итгэлтэйгээр, аюул заналхийлэлгүйгээр ярьж, хэлэх хүн байхгүй, эсхүл тэдний эрхийг хэрэгжүүлэх үүрэгтэй хүмүүст хандан өөрсдийн ерөнхий ажиглалтын талаар үгээ хүргэж, харилцах ямар нэгэн суваг

⁹⁴ Хүүхдийн эсрэг Хүчирхийллийн талаарх НҮБ-ын Судалгааны бие даасан шинжээчийн тайлан (A/61/299).

байхгүй байна. Ийм учраас, хамгаалах арга хэмжээнд хүүхдүүдийг үр нөлөөтэй оролцуулахын тулд тэдний үзэл бодлоо илэрхийлэх, биеийн болон сэтгэл зүйн бүх хэлбэрийн хүчирхийллээс ангид байх эрхийн талаар мэдээлэл өгөх шаардлагатай байна. Оролцогч улсууд нь бүх хүүхдийн байгууллагууд хамтран хувь хүн болон албан байгууллагад хүүхдүүд хандахад хялбар холбогдох, аюулгүй, итгэлтэй байдлаар тухайлбал утсаар, мэдээлэл өгөх бололцоогоор хангаж, хүүхдийн эсрэг хүчирхийлэлтэй тэмцэх өөрсдийн үзэл бодол, туршлагаасаа хуваалцаж, хувь нэмэр оруулах тийм орчинг бүрдүүлэхийг хариуцах ёстой.

121. Мөн түүнчлэн Хорооноос оролцогч улсуудын анхаарлыг Ерөнхий нарийн бичгийн даргын “Хүүхдийн эсрэг Хүчирхийллийн тухай” судалгааны зөвлөмжид орсон хүчирхийллийн эсрэг хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд, хүүхдийн гаргасан санал, санаачлагуудыг дэмжих болон тэдгээр байгуулагуудыг хүчирхийллийн эсрэг хөтөлбөр, арга хэмжээ зохион байгуулах, хамтран ажиллах, үнэлгээ өгөхөд оролцуулснаар хүүхдүүд өөрсдийгөө хамгаалахад голлох үүрэг гүйцэтгэх чадвартай болгоход анхаарлаа хандуулахыг хүсч байна.

8. Урьдчилан сэргийлэх стратегийг боловсруулах нь

122. Хорооноос хүүхдийн дуу хоолой нь хүүхдийн эрхийг зөрчихөөс урьдчилан сэргийлэх улам бүр өсөн нэмэгдэж буй хүчирхэг зэвсэг болж байгааг цохон тэмдэглэсэн. Насанд хүрээгүйчүүдийн үйлдсэн гэмт хэрэг, гудамжны

хүүхдийн боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй тэмцэх, сургуулийн орчин дахь хүчирхийллээс урьдчилан сэргийлэх гэх мэт олон асуудлыг нааштай шийдэж байгаа сайн туршлагауд их байна. Хүүхдүүдтэй дээрх болон бусад асуудалтай холбоотой хууль, эрх зүй болон бодлого боловсруулах, холбогдох төлөвлөгөө, хөтөлбөр зохиох, боловсруулах, болон хэрэгжүүлэхэд хамтран харилцан ярилцаж, зөвлөлдөх нь зохилтой.

11. Үндэсний болон олон улсын түвшинд

127. Хүүхдийн оролцоог хамгийн ихээр бүрдүүлэх боломж нийгэмд байдаг. Хорооноос хүүхдүүд үзэл бодлоо шийдвэр гаргах ажиллагаанд хүргэх орон нутгийн хүүхдийн парламент, хотын захиргааны дэргэдэх хүүхдийн төлөө төв, энэ зорилгоор зөвлөгөө өгөх төвүүд олноор байгуулагдаж байгааг талархан хүлээн авдаг. Гэвч орон нутгийн засаг захиргаан дахь албан ёсны төлөөллийн оролцооны эдгээр бүтцүүд нь орон нутагт 12 дугаар зүйлийн заалтыг хэрэгжүүлэх олон аргуудын зөвхөн ганц хувилбар бөгөөд энэ нь харьцангуй цөөн тооны хүүхдүүдийг хамруулдаг байна. Улс төрчид, албан хаагчид зөвлөгөө өгөх цаг гаргах, нээлттэй байгууллагууд болон сургууль, цэцэрлэгээр явж уулзалт зохион байгуулах нь хүүхдийн бусадтай харилцах нөхцөлийг бүрдүүлдэг.

128. Хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагууд байгуулах, тэдний санал санаачлагыг дэмжин урамшуулснаар утга төгөлдөр оролцоо болон

төлөөллийн орон зайг бүрдүүлж өгнө. Нэмж хэлэхэд, хүүхдүүд сургууль, тоглоомын талбай, цэцэрлэгт хүрээлэн, амралт, спортын цогцолбор, нийтийн номын сан, эрүүл мэндийн төвүүд, орон нутгийн тээврийн тогтолцоог барьж байгуулах, зохион бүтээхэд өөрсдийн хүсэл, үзэл бодлоо илэрхийлж, зохих хувь нэмрээ оруулж болох юм. Нийгмийг хөгжүүлэх төлөвлөгөөнд олон нийтийн санал зөвлөгөөг авч, хүүхдүүдийн үзэл бодол, саналыг ил тодоор тусгасан байвал зохино.

129. Энэ хооронд олон улс оронд дүүрэг, бүс нутаг, мужийн түвшинд хүүхдийн дээрх оролцоог идэвхжүүлэх бололцоог бүрдүүлж байгаа бөгөөд хүүхдийн парламент, зөвлөл, бага хурлууд хүүхдийн үзэл бодлыг сонсох, тэдний дуу хоолойг шийдвэр гаргагчдад хүргэх зорилгоор хүүхдэд зориулж чуулга уулзалтууд зохион байгуулдаг. Төрийн бус байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд хүүхдийн оролцоог дэмжих арга зам практикийг боловсруулсан бөгөөд энэ нь хүүхдийн төлөөллийг билиг тэмдгийн шинжтэй хангах, эсхүл хүүхдийг хувийн ашиг сонирхолдоо ашиглах эрсдлээс хамгаалах юм.

130. Хорооноос НҮБ-ын Хүүхдийн Сан болон төрийн бус байгууллагуудын зүгээс хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж, хүүхдийн амьдралтай холбоотой бүх асуудлаар тэдний оролцоог эгэл жирийн ард түмний дунд, нийгэм, үндэстэн, олон улсын түвшинд дэмжин, сайн туршлагаа харилцан солилцох үйлсэд оруулж буй асар их хувь нэмрийг нь ямагт талархаж байдаг. Хүүхдийн өөрийн

удирдлагын байгууллагуудыг хооронд нь холбох, сүлжээ бүрдүүлэх нь олон нийтийн өмгөөллийн хөтөлбөр, чадавхи бэхжүүлэх бололцоог нэмэгдүүлэх болно.

131. Олон улсын түвшинд, 1990, 2002 онуудад Ерөнхий Ассамблейгаас хуралдуулсан Дэлхийн хүүхдийн Дээд чуулганд хүүхдүүдийн оролцсон байдал, Хүүхдийн эрхийн хорооны хуралдаанаар оролцогч улсуудын ирүүлсэн тайланг хянаж үзэх ажиллагаанд хүүхдүүдийг хамруулсан зэрэг нь тодорхой ач холбогдлоо өгсөн. Хороо нь оролцогч улсуудын хүүхдийн эрхийн хэрэгжилтийн хяналтын явцад хүүхдийн байгууллагууд, тэдний төлөөлөгчдийн бичгээр ирүүлсэн тайлан, амаар нэмж өгсөн мэдээллийг хүлээн авахад бэлэн байхаас гадна оролцогч улсууд болон төрийн бус байгууллагуудыг Хороонд өөрсдийн үзэл бодлоо хүргүүлэхийг дэмжих болно.

D. Хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэхэд тавигдах үндсэн шаардлагууд

132. Хороо нь оролцогч улсуудад хандан хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарласан, эсхүл хэдийгээр хүүхдийн үгийг сонсдог ч түүнд ач холбогдол өгдөггүй аливаа билэг тэмдгийн шинжтэй, дүр эсгэсэн хандлагаас зайлсхийхийг уриалж байна. Мөн Хороо нь насанд хүрэгсэд хүүхдийг хуурмаг байдлаар ашиглан, өөрсдийн саналыг хүүхдээр дамжуулах, эсхүл хүүхдийг оролцох үед аюултай, эрсдэл бүхий байдалд оруулах нь ёс зүйгүй үйлдэл бөгөөд үүнийг 12 дугаар

зүйлийн хэрэгжилт хэмээн ойлгож болохгүй болохыг онцлон тэмдэглэж байна.

133. Хэрэв хүүхдийн оролцоог үр дүнтэй, утга төгөлдөр байлгахыг хүсвэл оролцоог нэг удаагийн хувийн асуудал бус, харин эргэх холбоо бүхий үйл явц хэмээн ойлгох шаардлагатай. Хүүхдийн эрхийн тухай конвенцийг 1989 онд баталснаас хойш хуримтлуулсан туршлага нь 12 дугаар зүйлийг үр дүнтэй, ёс зүйтэй, утга төгөлдөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан тавигдах үндсэн шаардлагуудын талаар өргөн цар хэмжээний тохиролцоонд хүрээд байна. Хорооноос оролцогч улсуудад хандан 12 дугаар зүйлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд эдгээр шаардлагуудыг хууль, эрх зүйн болон бусад бүх төрлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэхийг зөвлөж байна.

134. Хүүхэд болон хүүхдүүд үзэл бодлоо илэрхийлэх болон оролцох бүх үйл явц нь доорх шаардлагуудыг хангасан байх ёстой. Үүнд:

- (а) *Ил тод ба мэдээллээр хангасан байх* - хүүхдүүдийг үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнд зохих ач холбогдол өгөх болон хэрхэн оролцох хүрээ, зорилго, боломжит үр нөлөөний талаар хүртээмжтэй, олон талт, тэдний насны онцлогт тохирсон мэдээллээр хангах ёстой;
- (б) *Сайн дурын байх* – хүүхдүүдийг өөрсдийнх нь хүсэл зоригоос ангид үзэл бодлоо илэрхийлэхийг албадах ёсгүй бөгөөд оролцооны аль ч шатанд өөрсдөө татгалзаж болох талаар тэдэнд мэдэгдэх нь зүйтэй;
- (в) *Хүндэтгэсэн байх* – хүүхдүүдийн үзэл бодлыг хүндэтгэн үзэх ёстой бөгөөд тэднийг шинийг санаачлах, эрэлхийлэх боломжоор хангах нь

зүйтэй. Хүүхдүүдтэй ажилладаг насанд хүрэгсэд тэдний оролцооны, тухайлбал гэр бүл, сургууль, болон ажиллах орчинд оруулсан хувь нэмэр, сайн үлгэр жишээг магтан сайшааж, талархаж, хүндэтгэх нь зүйтэй. Мөн түүнчлэн насанд хүрэгсэд хүүхдийн амьдралтай холбоотой нийгэм-эдийн засаг, хүрээлэн буй болон соёлын орчны талаар ойлголттой байх хэрэгтэй. Хүүхдийн төлөө болон хүүхэдтэй ажилладаг хүмүүс, байгууллагууд нь хүүхдийг олон нийтийн үйл ажиллагаанд оролцож байгаатай холбогдуулан тэдний үзэл бодлыг хүндэтгэн үзэх нь зүйтэй;

- (г) *Холбогдолтой байх* – хүүхдийн үзэл бодлоо илэрхийлэх асуудал нь тэдний бодит амьдралтай холбоотой асуудлаар байх бөгөөд өөрсдийн мэдлэг, дадал, чадвар дээр тулгуурлах боломжтой байх нь чухал юм. Мөн түүнчлэн, хүүхдүүдийг өөрсдөө чухал, ач холбогдолтой гэж үзсэн асуудлаа тодорхойлох, онцлон тэмдэглэх эрх эдлэх бололцоогоор хангах;
- (д) *Хүүхдэд ээлтэй байх* – хүрээлэн буй орчин, ажлын арга барил нь хүүхдийн чадвар, чадамжид нийцсэн байх учиртай. Хүүхдүүдийг үзэл бодлоо итгэл төгс илэрхийлэхэд бэлдэх хангалттай цаг хугацаа болон нөөц бололцоогоор хангах ёстой. Тэдэнд хүүхдийн насны онцлог, хөгжиж буй чадавхид нийцүүлэн өөр өөр төрлийн дэмжлэг болон оролцооны хэлбэрүүд хэрэгтэй байгааг анхаарах хэрэгтэй байна;
- (е) *Тэгш эрхтэйгээр оролцуулах* –

хүүхдийн оролцоо нь ялгаварлан гадуурхах, алагчлахын аль ч хэлбэрээс зайлсхийсэн, эмзэг бүлэгт хамаардаг хүүхдүүдэд боломж олгохыг хөхиүлэн дэмжих, охид хөвгүүдийг тэгш эрхтэйгээр оролцуулсан байх ёстой. (88 дугаар хэсгийг харах) Хүүхдүүд нь хоорондоо ялгаатай бөгөөд тэдний оролцоо нь гарал үүслийн аливаа ялгаварлан гадуурхалгүй, тэгш боломж олгосон байх хэрэгтэй. Мөн хөтөлбөр боловсруулахдаа бүх орны хүүхдүүдийн соёлын ялгааг харгалзан үзсэн ёстой.

(ё) *Сургалтад хамруулах* – хүүхдүүдийн оролцоог тэдний хөгжиж буй чадавхид нийцүүлэхэд үр дүнтэй хэрэгжүүлэх, тухайлбал бусдыг сонсох, бусад хүүхдүүдтэй хамтарч ажиллах дадалд сургахад насанд хүрэгсдийг бэлтгэх, дадал олгох, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй. Мөн хүүхдүүд үр нөлөөтэй оролцоог хөхиүлэх дэмжих талаар явагдах сургалтанд багшлах боломжтой бөгөөд ингэхийн тулд тэднээс өөрсдийн ур чадвараа сайжруулах, эрхээ хамгаалахад идэвхтэй оролцох ухамсар, хурал зохион байгуулах, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлтэй харилцах, илтгэх, өмгөөлөлд суралцах шаардлага урган гарна;

(ж) *Эрсдлээс хамгаалагдсан, эрсдэлд мэдрэмтгий байх* – хүүхэд тодорхой нөхцөл байдалд үзэл бодлоо илэрхийлэх нь тэднийг эрсдэлд оруулах магадлалтай байдаг. Хүүхдүүдтэй ажилладаг насанд хүрэгсэд тэдний оролцооноос үүдэн гарч болзошгүй хүчирхийлэл,

мөлжлөг гэх мэт эрсдэл эсхүл бусад сөрөг үр дагавараас урьдчилан сэргийлэх бүхий л арга хэмжээг авах ёстой. Зохих хамгаалалтаар хангахын тулд зайлшгүй авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зарим бүлэг хүүхдүүдэд тохиолдож болзошгүй эрсдлүүд, мөн тэдний тусламж хүртэхэд учрах нэмэлт бэрхшээлүүдийг урьдчилан тооцоолсон хүүхэд хамгааллын тодорхой стратегиуд боловсруулах ажил багтана. Хүүхдүүд элдэв төрлийн халдлагаас хамгаалагдсан байх эрхийн тухай, мөн зохих шаардлагатай тусламж хаанаас авах талаар мэддэг байх ёстой. Хүүхдүүд гэр бүл болон нийгмийн ажилд хувь нэмрээ оруулах нь тэдний оролцооны цаад ач холбогдол болон үнэ цэнийн тухай ойлголт өгөх бөгөөд хүүхдийг эрсдэлд оруулахаас хамгаалахад мөн чухал шаардлагатай байх юм;

(з) *Хариуцах чадвартай байх* – дараагийн хийх ёстой ажлын талаарх амлалт гаргах болон өмнөх ажилд үнэлэлт дүгнэлт өгөх нь нэн чухал юм. Жишээлбэл, ямар ч судалгаа, зөвлөгөөний явцад хүүхдүүдэд тэдний үзэл бодлыг хэрхэн харгалзан үзсэн талаар мэдээлэх, шаардлагатай бол тухайн судалгааны үр дүнд нөлөөлөх, маргах бололцоогоор хангасан байх ёстой. Мөн түүнчлэн хүүхдүүдээс тэдний оролцоо нь тухайн үр дүн буюу шийдвэрт хэрхэн нөлөөлсөн талаар тодорхой үнэлэлт дүгнэлт өгөхийг хүсэх хэрэгтэй. Боломжтой бол хүүхдэд дараачийн үйл ажиллагаанд

оролцох эрх өгөх гадна хүүхдийн оролцооны талаар мониторинг болон үнэлгээ хийх үйл ажиллагаанд татан оролцуулах шаардлагатай.

Д. Дүгнэлт

135. Хүүхдийн өөртэй нь холбоотой бүх асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хэрэгжүүлэх, түүний үзэл бодолд зохих ач холбогдол өгч, харгалзан үзэхэд хувь нэмэр оруулах нь тус конвенцид нэгдсэн оролцогч улсуудын хувьд тодорхой, бүр хойшлуулшгүй хуулиар хүлээсэн үүрэг болно. Энэ эрх бол ямар ч ялгаварлан гадуурхалтгүй хүүхэд бүрийн эдлэх ёстой эрх юм. 12 дугаар зүйлд заасан эрхийг эдлэх бүрэн боломжид хүрэхийн тулд нь хүүхдүүдэд үг хэлэх бололцоог олгох, өөртэй нь холбоотой асуудалд оролцох оролцоог хязгаарлаж байгаа хууль, эрх зүй, улс төр, эдийн засаг, нийгэм болон

соёлын саад бэрхшээлүүдийг арилгах шаардлага зүй ёсоор урган гарч байна. Энэ нь хүүхдийн чадавхийн талаарх тогтсон бодлоо өөрчлөхөд бэлэн байх, тэдний чадвар, чадавхийг хөгжүүлэх, нээн илрүүлэх орчинг бүрдүүлэхийг хөхиүлэн дэмжих, түүнчлэн өөрсдийн нөөц бололцоог бүрэн дайчилж, зохих сургалт, судалгааны ажлыг зохион байгуулахыг шаардаж байна.

136. Эдгээр үүрэг хариуцлагыг бүрэн биелүүлэх нь оролцогч улсуудын хувьд том сорилт болно. Гэхдээ уг ерөнхий зөвлөмжид санал болгосон стратегиудыг системтэйгээр хэрэгжүүлж, хүүхдүүд, тэдний үзэл бодлыг хүндэтгэх соёлыг төлөвшүүлж чадвал энэхүү тавигдсан зорилгод хүрэх бүрэн боломжтой юм.

Орчуулсан: Ч.Алтангэрэл,

(Хүний эрхийн хэрэгжилтэд хяналт тавих үндэсний чадавхийг бэхжүүлэх төслийн зохицуулагч)

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ЗОЧНЫ ЯРИА

ОРОН НУТАГТ ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛАХ, УУЛ УУРХАЙН САЛБАРААС НУТГИЙН ИРГЭДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БАГАСГАХ АЖЛЫГ ХИЙХ ХЭРЭГТЭЙ



“Хүний эрх” сэтгүүлийн энэ удаагийн зочноор Каритас Чех олон улсын байгууллагын Монгол дахь төлөөлөгчийн газрын дарга, ноён Тибо Шануа уригдлаа.

-Та хэдийнээс манай улсад ажиллаж байна вэ? Зорьсон ажил үйлс тань бүтэмжтэй юу?

-Би Монгол Улсад Каритас Чех байгууллагын Суурин төлөөлөгчөөр 2013 оны 9 дүгээр сараас эхлэн ажиллаж байна. Нэг жил гэдэг бол үйл ажиллагааны гол үндсэн, эцсийн үр дүндээ хүрсэн гэж дүгнэхэд хэтэрхий богино хугацаа гэж бодож байна.

Гэсэн хэдий ч, энэ нэг жилийн хугацаанд Каритас Чех Байгууллагын Монгол дахь төслийн багийнхантайгаа хамт биднийг сорьсон олон асуудлыг амжилттай даван туулж, олон чиглэлээр үйл ажиллагаа явуулж, тодорхой зарим чиглэлд чухал үр дүнд хүрч чадсан. Энэ нь төслийн багийнхны маань зорилгодоо хүрэх хүсэл эрмэлзлийг

нэмэгдүүлж байна. Миний хувьд урам зориг дүүрэн, ажилдаа дур сонирхолттой хамт олонтой ажиллах завшаан олдсон. Тэр дундаа хүний эрхийн салбарт хэрэгжиж буй төслүүд маань хүлээгдэж буй үр дүндээ хүрэхээс гадна, төлөвлөснөөсөө илүү үр нөлөө үзүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

-Каритас Чех Байгууллага нь эрх хязгаарлагдсан хүмүүст зориулсан томоохон төслийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгаа. Төслийн нэгээхэн хэсэгт нь Хүний эрхийн Үндэсний Комисс хамтарч ажиллан улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бүх хорих ангиудад, албан хаагчдад нь хүний эрхийн сургалтыг явууллаа. Цаашид энэ төсөл үргэлжлэх үү? Уншигчдад мэдээлэл өгөх зорилгоор энэ асуултыг тавьж байгааг ойлгоно уу?

-Каритас Чех Байгууллага нь Европын Холбоо, Чехийн Хөгжлийн Агентлагийн санхүүжилтээр 2013 оны 11 дүгээр сараас

2015 оны 4 дүгээр сарыг дуустал “Монголын хорих байгууллагуудад хүний эрх болон ардчиллыг хөгжүүлэх, иргэний нийгмийг дэмжих” төсөл хэрэгжүүлж байна. Төсөл нь Монголын хорих ангиудад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийг дэмжих, хорих анги дахь залхаан цээрлүүлэх, эрүүдэн шүүх, хүнлэг бус харилцах, доромжлох явдлаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих зорилготой юм.

Төслийн хүрээнд 4 үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Юуны өмнө их дээд сургуулийн багш нар, сэтгэл судлалын мэргэжилтнүүд болон Франц улсын мэргэжилтэнтэй хамтран хорих ангийн нийгмийн ажилтнуудад зориулсан “Хорих анги дахь нийгмийн ажил” сургалтын хөтөлбөрийг боловсруулсан. Төслийг хамтран хэрэгжүүлэгч “Монголын Хорих байгууллагын нөхөрлөл” ТББ-тай хамтран хорихын нийгмийн ажилтнуудад боловсруулсан сургалтын модулийн хүрээнд онолын болон практик сургалтуудыг явууллаа. Сургалтын хөтөлбөрийг нийгмийн ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох үнэлгээнд үндэслэн боловсруулж, ял эдэлж буй хүмүүсийг нийгэмд эргэн нийгэмшүүлэх, тэдэнтэй ажиллах аргачлал, гарын авлагыг багтаасан. Энэ нь тэдгээр ажилтнуудад өдөр тутмын ажилдаа тогтмол ашиглахуйц чухал ач холбогдолтой материал болсон гэж үзэж байна. Сургалтад нийт 80 нийгмийн ажилтанг хамруулсан.

Хоёрдугаарт, Монголын хорих байгууллагад ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн хэрэгжилтийг үнэлэх үндэсний хэмжээний судалгаа хийж, “Ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн өнөөгийн байдал” нэртэй судалгааны тайланг 2014 оны зургаадугаар сард хэвлүүлэн гаргасан. Судалгааны үр дүнд тулгуурлан хүний эрхийг

дэмжихэд чиглэгдсэн санал зөвлөмжийг боловсруулан гаргасан. Энэхүү судалгааны тайланг Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын албан ёсны цахим хуудаст байршуулсан байгаа. Уг судалгаа нь Монгол Улс дахь ял эдэлж буй хүмүүсийн хүний эрхийн асуудлыг хөндсөн анхны цогц хэмжээний судалгаа болж чадсан гэж бодож байна. Түүнчлэн судалгааны тайлан нь Хүний эрхийн Үндэсний Комиссын дэмжлэгтэйгээр шийдвэр гаргагчдад чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагааны үндэс суурь болж өгөх юм.

Гуравдугаарт, бид Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих ангиудын албан хаагчдад зориулан “Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт сургалтын хөтөлбөрийг боловсруулан, 800 орчим албан хаагчдад ажлын байранд нь очиж, сургалтыг зохион байгуулсан.

Мөн хорих ангид ажиллаж буй албан хаагчдын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх зорилгоор “Хүний эрхийн баримт бичиг, зөвлөмж, тогтоол шийдвэрийн эмхэтгэл”, ял эдэлж буй хүмүүст зориулан “Хүний эрх” эмхэтгэл гарын авлагыг тус тус хэвлүүлэн тараалаа. Энэхүү үйл ажиллагааг бид хамтын ажиллагааны гэрээний хүрээнд танай байгууллагаар дамжуулан хүргэсэндээ баяртай байна. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын мэргэшсэн сургагч багш нар хорих ангийн нийт албан хаагчдын 60 орчим хувийг дээрх сургалтад хамруулсан.

Манай төслийн дараагийн үйл ажиллагаа бол ял эдэлж буй хүмүүст эрх зүйн зөвлөгөө өгөх Монголын төрийн бус байгууллага сонгон шалгаруулж, үйл ажиллагааг нь тогтворжуулах санхүүгийн дэмжлэг үзүүлэх явдал.

-Каритас Чех Байгууллагаас хүний эрхийн чиглэлээр явуулж буй бусад төсөл, ажлуудаас сонирхуулна уу. Төлөвлөсөн зорилгодоо хүрч чадаж байна уу?

-Манай байгууллага нь дээр дурдсан төслөөс гадна Европын Холбооны санхүүжилтээр “Хүний аюулгүй байдлын судалгааны төв” ТББ-тай хамтран “Хүн худалдаалахтай тэмцэхэд иргэний нийгмийг дэмжих нь” төслийг хэрэгжүүлж байна. Энэ төслийн хүрээнд хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монголын 18 ТББ-ын сүлжээг байгуулсан. Сүлжээ нь хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх, хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх, шууд туслалцаа үзүүлэх зэрэг үйл ажиллагааг явуулж байна.

Мөн Цагдаагийн ерөнхий газар, Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Каритас Чех Байгууллага хамтран олон улсын сургагч багшаар дамжуулан цагдаагийн байгууллагын 36 албан хаагч, мөрдөн байцаагчдад сургалт явуулсан. Сургалтын гол зорилго нь хүн худалдаалах гэмт хэрэг дээр ажиллаж буй албан хаагчдыг чадавхжуулах явдал байсан юм. Түүнчлэн цагдаагийн албан хаагчдад хохирогч, гэрчээс мэдээлэл авах, үр дүнтэй ярилцлага хийх арга техник, хохирогчийг таних, хамгаалах, хүн худалдаалагчийг шийтгэх дотоод, гадаадын хууль эрх зүйн тогтолцооны талаар мэдээлэл өгсөн. Энэхүү төсөл нь маш олон үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлж байгаа бөгөөд Каритас Чех Байгууллага, Хүний аюулгүй байдлын судалгааны төв 2015 оны дөрөвдүгээр сард төсөл дууссаны дараа ч үргэлжлүүлэн хэрэгжүүлэх хүсэлтэй байгаа юм. Мөн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль, хуулийн хэрэгжилтийн зөрүүтэй байдлын талаар Хууль зүйн яаманд

санал, зөвлөмж хүргүүлнэ.

-Монгол улсад хүний эрхийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахад ямар хүндрэл бэрхшээл гарч байна вэ? Даван туулах ямар арга замууд байв?

-Миний бодлоор Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагууд ижил асуудал, бэрхшээлтэй тулгардаг. Нэлээд эмзэг салбарт тооцогддог хорих анги дахь хүний эрхийн асуудлын хүрээнд манайх шиг олон улсын төрийн бус байгууллагад ажиллах боломж олгож байгаа нь талархуштай явдал мөн.

Түүнээс гадна төрийн байгууллагын албан хаагчид байнга солигдож байдаг тул өмнөх мэдээллийг уламжлах асуудал гардаг. Ихэнх тохиолдолд төрийн бус байгууллагууд байнга өөрсдийгөө дахин танилцуулж, үйл ажиллагаагаа тайлбарлаж, хамтын ажиллагааг шинээр эхлэх шаардлагатай болдог.

Нөгөө талаас хууль сахиулах байгууллагуудтай дотоодын болон олон улсын төрийн бус байгууллагууд хамтран ажиллах бодит боломж байна. Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллахад төслийн оролцогч талуудаас дэмжлэг авах, зарим үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, харилцан тохирох асуудалд хугацаа их зарцуулах шаардлагатай болдог.

-Каритас Чех нь хүмүүнлэгийн далайцтай үйл ажиллагаа явуулдаг. Хүний эрхийн ямар асуудалд танай байгууллага голчлон анхаарал хандуулж байна вэ? Цаашид аль чиглэлийг түлхүү баримтлах вэ?

-Цаашид үнэхээр ажиллах шаардлагатай салбарын асуудлыг тодорхойлсон. Зарим асуудал бидний анхаарлыг их татаж байгаа. Тухайлбал, хүн худалдаалах гэмт хэрэг нь

Монгол Улсад ноцтой асуудал болж байгаа учраас Каритас Чех Байгууллага болон Хүний аюулгүй байдлын судалгааны төв хамтран төслөө үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн эсрэг төрийн бус байгууллагуудын сүлжээний тогтвортой байдлыг хангах, мөрдөн байцаагч болон хүн худалдаалах гэмт хэрэгтэй холбоотой хууль сахиулагчдад нэмэлт сургалт явуулах, сэрэмжлүүлэх мэдээллийг улам дэлгэрүүлж, уг асуудлын талаарх ойлголтыг олон нийтэд сурталчлан хуулийн хүрээг сайжруулан ажиллах хэрэгтэй байна.

Бид мөн бусад хууль сахиулагч төрийн байгууллагын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх талаар чадавхийг бэхжүүлэх, хохирогчдод тусламж үзүүлэх, буруутай этгээдэд зохих шийтгэл оногдуулахад төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах чиглэлээр төсөл хэрэгжүүлэх саналтай байгаа. Үүнээс гадна цагдаагийн газрын саатуулах байрны нөхцөлийг сайжруулах, мансууруулах бодисоос урьдчилан сэргийлэх, уул уурхай дагасан орон нутгийн иргэдийн зөрчигдсөн эрх, сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрхийг хамгаалах зэрэг үйл ажиллагааг явуулах сонирхолтой байна.

-Манай Улсад хүний эрхийн шийдвэрлэгдээгүй олон асуудал бий. Тэдгээрээс таны анхаарлыг татаж, сэтгэл эмзэглүүлсэн ямар асуудал байна вэ?

-Хөдөө орон нутаг дахь хүний эрхийн асуудал нь яах аргагүй өнөөгийн тулгамдсан асуудлын нэг гэж бодож байна. Орон нутагт гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн эсрэг үйл ажиллагаа явуулах, уул уурхайн салбараас нутгийн иргэдэд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах ажлыг хийх хэрэгтэй. Эдгээр асуудлын ихэнхийг огт

хөнддөггүй, тоон болон чанарын мэдээлэл дутмаг байдаг. Тухайлбал, бэлгийн болон гэр бүлийн хүчирхийлэл нь хориотой, эмзэг сэдэв байдаг. Энэ талаар асуух нь хүний эрхтэй шууд холбоотой байдаг тул судлахад хүндрэлтэй байна.

Уул уурхайн салбараас болж малчид, нүүдэлчдийн эрх ашиг хөндөгдөж байгаа нь өнөөгийн гол асуудлын нэг болж байгаа ба орон нутгийн иргэдийн хувьд шударгаар шийдвэрлүүлэх боломж тэр бүр байхгүй байна. Ирээдүйд Монгол Улс хөдөө, орон нутгийн иргэд рүүгээ илүү анхаарал хандуулж, хууль эрх зүйн орчинг нь сайжруулах хэрэгтэй.

-Хүмүүнлэг, хүний эрхийн чиглэлээр ажилладаг хүний нүдээр Монголд ямар асуудлыг хэрхэн шийдвэрлэвэл зохилтой санагддаг вэ?

-Хүний эрхийн асуудлыг үр дүнтэй хэлэлцэхийн тулд төрийн, иргэний нийгмийн, хувийн гэх мэт олон салбарын байгууллагуудын төлөөлөл хоорондоо нягт хамтран ажиллах шаардлагатай. Олон салбарын бодлого, төрийн, ТББ-ын үйл ажиллагааг уялдуулах, нэгдсэн ойлголттой байх хэрэгтэй. Монгол Улсын Засгийн газар иргэний нийгмийн байгууллагыг шийдвэр гаргах үйл явцад оролцуулах болсон нь сайшаалтай.

-“Хүний эрх” сэтгүүл зочноо тодотгох, ажил үйлсийг нь танилцуулах зорилгоор урьж ярилцдаг. Та өмнө нь ямар чиглэлээр, хаана ажиллаж байсан бэ? Ажил, мэргэжил, сонирхол гээд өөрийнхөө талаар танилцуулна уу?

-Би 10 гаруй жилийн турш дүрвэгсэд, цагаачлагчдын хэрэг дээр ажиллаж байсан. Францын Цагаачлалын албанд ажиллаж байх хугацаандаа Африк, Дундад Азиас

ирсэн дүрвэгчдэд эрх зүйн мэдээлэл өгөх, хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байлаа. Мөн үүний хажуугаар хүний эрхийн асуудал, цөөнхийн эрх, хорих байрны нөхцөл, жендерийн асуудалтай холбоотой хэд хэдэн судалгааны ажлууд хийсэн.

Түүнчлэн НҮБ-ын Дүрвэгсдийн Агентлагт Йемен, Камерун болон Тунист иргэний дайн, олон нийтийн дарангуйлал, хүний эрхийн зөрчлөөс сэргийлэх хөтөлбөрт ажиллаж байсан. Дүрвэгсдийн лагерьт тамлан зовоох болон хүчирхийлэлд өртсөн, асран халамжлагчгүй, хараа хяналтгүй хүүхдүүд, эрсдэлд өртсөн эмэгтэйчүүд, хүнд өвчин туссан дүрвэгчид болон аюулгүй хамгаалалт шаардлагатай улс төрийн орогнол хүссэн хүмүүстэй ажиллаж байсан. Эдгээр хүмүүсийн хэрэг дээр ажиллаж, тухайн дүрвэсэн улсад нь хэргийг нь шийдвэрлэж болох эсвэл гуравдагч улсад суурьшуулах гэх зэрэг асуудлыг шийддэг байлаа. НҮБ-ын Дүрвэгсдийн Агентлагт ажиллаж байхдаа дүрвэгсэд болон орон нутгийн нийгэмлэг, албан байгууллага болон хамтрагч

байгууллагуудтай хамтран ажиллаж байсан. НҮБ-ын Дүрвэгсдийн Агентлагт ихэвчлэн өндөр хүлээлттэй, маш эмзэг хүмүүстэй ажиллаж байсан нь миний хувьд хамгийн их ур чадвар шалгасан ажил болсон. Гэхдээ үр өгөөж хүртэж байгаа хүмүүстэйгээ шууд холбоо тогтоож ажиллаж байсан нь урамшмаар санагддаг юм билээ.

-Баярлалаа. Танаас асуугаагүй, ярьж амжаагүй зүйл байгаа бол энэ асуулыг танд үлдээе?

-Бидний зүгээс танай сэтгүүлд ярилцлага өгч байгаадаа маш их баяртай байна. Мөн Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтран ажиллахад таатай байдаг гэдгийг уламжилмаар байна. Та бүхний ажилд амжилт хүсье. Баярлалаа.

-Цаг зав гарган ярилцсан танд баярлалаа.

Ярилцсан: З.Бадмаараг

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын референт)

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ХАВСРАЛТ

**АЗИЙН ХҮҮХДИЙН ЭРХИЙН
ГУРАВДУГААР ЧУУЛГА УУЛЗАЛТААС
ГАРСАН ТУНХАГЛАЛ**

2014 оны 8 дугаар сарын 24, Улаанбаатар хот

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай Конвенц батлагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан Улаанбаатар хотод 2014 оны 8 дугаар сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулсан Азийн Хүүхдийн эрхийн гуравдугаар чуулга уулзалтын оролцогчид, Индонез, Камбож, Монгол, Солонгос, Энэтхэг, Япон орны төлөөлөгчид бид,

Сөүл хотод 2009 онд болсон Зүүн Ази дахь Хүүхдийн эрхийн өнөөгийн нөхцөл байдал, тулгарч буй бэрхшээл сэдэвт Азийн Хүүхдийн эрхийн анхдугаар чуулга уулзалт болон Токио хотод 2011 онд болсон Хүүхдэд таагай дэлхийг бий болгох нь сэдэвт Азийн Хүүхдийн эрхийн хоёрдугаар чуулга уулзалтаас гарсан үр дүнд *тулгуурлаж*,

Гамшиг, зэвсэгт мөргөлдөөн зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрт өртөж хэлмэгдэн хохирсоор байгаа хүүхдүүдийн зовлон шаналалд *зовинож*,

Ядуурал, хүний наймаа, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, эдийн засгийн мөлжлөг, албадан хөдөлмөр, мансууруулах бодисын хэрэглээ болон зүй бус харьцаа, бие махбодын шийтгэл, дээрэлхэлт зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бусад хэлбэрээс хохирч буй Азийн олон хүүхдэд *анхаарал хандуулж*,

Үндэстнүүдийн Холбооноос ерэн жилийн өмнө 1924 онд батлан гаргасан Хүүхдийн эрхийн талаарх Женевийн Тунхаглалд “хүн төрөлхтөн хүүхдэд хамгийн сайн сайхныг өгөх үүрэгтэй” хэмээн мэдэгдсэнийг *санан*,

Хүүхдийн эрхийн тухай Конвенцид нэгдэн орсон Азийн улс орнууд уг

Конвенцоор баталгаажсан эрхүүдийг бүх хүүхдэд баталгаатай эдлүүлэх, үүний хүрээнд ялгаварлан гадуурхалтыг хориглох, хүүхдийн дээд ашиг сонирхолыг дээдлэх, амьд явах, оршин тогтнох, хөгжих эрхийг баталгаажуулах, хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх хэмээсэн Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн дөрвөн үндсэн зарчмыг чухалчлан, хүүхэд бүрийг иргэн, эрх эдлэгч гэж хүндлэх ёстой болохыг *дахин баталж*,

Хүүхдийн нөхцөл байдлын талаарх баримт болон бодит дүр зураг, мөн хүүхэдтэй холбоотой хууль тогтоомж, бодлого, санаачлага, туршлагын талаарх мэдээлэл зэрэг хүүхдийн эрхийн талаарх судалгаа, үзэл бодол, мэдээллийн солилцоог эрчимжүүлэхийн ач холбогдлыг *дахин хүлээн зөвшөөрч*,

Бүс нутагтай хүүхдэд ээлтэй улсуудыг бий болгохоор чармайхын тулд Азийн Хүүхдийн эрхийн Форумд нэгдэн орохыг Ази тивийн бусад оронд *уриалж*,

Хүүхдийн эрхийн тухай Конвенц нийтлэг зорилго болохын хувьд засгийн газар, судлаач, шинжээч, олон улсын байгууллагууд, иргэний нийгэм болон бусад үүрэг хүлээгчдийн дунд хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих замаар Азийн бүс нутагт бүх улсад Хүүхдийн эрхийн тухай Конвенцийг бодитоор хэрэгжүүлэхийг чармайх *шийдвэр төгс байж*,

Мөн түүнчлэн бүх оролцогч талуудад хүүхдүүдэд өөрсдөд нь холбоотой бүх хэрэг явдалд үзэл бодлоо илэрхийлэх, үүний тулд зохион байгуулалтад орох боломжийг олгож туслах, мөн өөрсдөдөө нь хамаатай хууль

тогтоомж, бодлого, хөтөлбөр, бусад алхамыг төлөвлөх, хэрэгжүүлэх бүтэц, механизмыг тэдэнд бий болгож өгөхийг *урамиуулж*,

Улаанбаатар хотноо зохион байгуулж буй Гуравдугаар Чуулга Уулзалтын гол сэдэв болох “хүүхдэд ээлтэй Азийн нийгмийг” хөгжүүлэх дараах санаачлагыг хөхиүлэн дэмжихээр *санал нэгдэв*. Үүнд:

1. Ази дахь Хүүхдийн эрхийн Конвенцийн бүх гишүүн улсыг хүүхдийн эрхийг хангаж, тэдэнд эрх зүйн статус олгох хууль тогтоомжийг нийцүүлэн батлахыг уриалах,
2. Гамшиг, зэвсэгт мөргөлдөөний үед болон тэдгээрийн дараах сэргээн босголт, дахин байгуулалтын үйл явцад Хүүхдийн эрхийн тухай конвенц, түүний нэмэлт протоколуудын зарчим, зорилтод суурилсан бодлого авч хэрэгжүүлэх, тэр дундаа сэргээн босголт, дахин байгуулалтын явцад хүүхдийн оролцоо, дуу хоолойг сонсох механизмыг бий болгох,
3. Зүй бус харьцаа, бие махбодын шийтгэл, дээрэлхэлт зэрэг хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хориглох бодлого хөтөлбөр, хууль тогтоомж, соён гэгээрүүлэлт болон бусад арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх ажиллагааг эрчимжүүлэх, эдгээр санаачлагын үндсэнд хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан сэргийлэх, тэдгээрийг хориглох цогц хөтөлбөр, ёс зүйн хэм хэмжээг боловсруулах,
4. Хүүхдийн тэвчишгүй хөдөлмөрийг хориглохын зэрэгцээ, тийм хөдөлмөр эрхэлж буй хүүхэд болон тэдний гэр бүлд бусад боломжит хувилбаруудыг олгон, тэдний сурч боловсрох эрхийг хангаж, хүүхдийн өсөж хөгжих баталгаатай орчныг бүрдүүлэх бүхий л арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хүүхэд болон тэдний гэр бүлтэй зөвлөлдөж, шийдвэрлэн хяналт үнэлгээ хийхэд тэднийг оролцуулах.
5. Хүүхдийн амь насыг хамгаалж, тэдний аюулгүй, эрүүл энх өсөх баталгааг хангахын тулд насанд хүрэгчдийн өнцгөөс харж боловсруулсан холбогдох бодлого, хууль тогтоомжийг хүүхдийн эрхийн үүднээс шинжилж, өөрчлөн сайжруулж байх,
6. Хүүхдэд, мөн түүнчлэн тэдний эцэг эх, гэр бүл, хүүхэд асрагч, багш болон хүүхэдтэй ажилладаг бусад хүмүүс хүүхдэд зохих ёсны анхаарал үзүүлэх баталгааг хангахын тулд тэдний эрхийг хамгаалах үүднээс нөхцөлийг нь сайжруулах цогц бодлогыг хөхиүлэн дэмжих,
7. Хүүхдийн эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих, түүнд хяналт тавих ажиллагааг боловсронгуй болгох механизм, тогтолцоог орон нутгийн, үндэсний, бүс нутгийн түвшинд олон талт байдлаар хөгжүүлэх, эдгээр механизм, тогтолцооны бодитой ажиллагааг хангах сүлжээг дэмжих, тэр дундаа хүүхэд хүндрэл бэрхшээлгүйгээр туслалцаа авч, эрхээ сэргээлгэх боломжтой тусгай механизмыг нэн даруй, бодит хэрэг болгон хөгжүүлэх,
8. Цаашид Хүүхдийн эрхийн тухай конвенцийн бодит хэрэгжилтийг хангах үүднээс уг конвенцийн гурван нэмэлт протоколд нэгдэн орох буюу тэдгээрийг соёрхон батлах чармайлтыг хөхиүлэн дэмжих,
9. “Хүүхдэд ээлтэй хот/орон нутаг” үндэсний санаачлагыг дэмжин Засгийн газар, НҮБ-ын Хүүхдийн сан болон олон улсын байгууллагууд, судлаач, шинжээчид, иргэний нийгэм, бусад оролцогчидтой хамтран “хүүхдэд ээлтэй Азийн нийгэм” бий болгохын төлөө чармайх, үүнд хүүхдийн оролцоог ханган ажиллах.

DECLARATION OF THE THIRD ASIAN FORUM ON THE RIGHTS OF THE CHILD

24 August 2014, Ulaanbaatar

We, the participants of the Third Asian Forum on the Rights of the Child, which was held in Ulaanbaatar on 23-24 August, 2014, and in line with the 25th anniversary of the adoption of the Convention on the Rights of the Child (CRC) by the United Nations,

Building on the outcomes of the First Forum in Seoul in 2009 (key theme: the Actual Situation of and Challenges to the Rights of the Child in East Asia) and the Second Forum in Tokyo in 2011 (key theme: Creating ‘A World Fit for Children’),

Empathizing with and bearing in mind the suffering and sorrow of children who are still victimized and damaged by all forms of violence against children, particularly as result of a number of disasters and armed conflicts,

Drawing attention to a large number of Asian children who suffer from poverty, all forms of human trafficking, worst forms of child labor, economic exploitation, forced labour, drug abuse as well as other forms of violence against children including child abuse, corporal punishment and bullying,

Recalling that the Geneva Declaration of the Rights of the Child, adopted by the League of Nations ninety years ago in 1924, stated that “mankind owes to the child the best it has to give”,

Reconfirming that the rights enshrined in the CRC, to which all the Asian states have become parties, must be ensured for all children in all settings with special emphasis placed on the four general principles of the CRC. Namely; non-discrimination; the best interests of the

child; the right to life; survival and development and respect for the views of the child; and that all children must be respected as citizens and rights holders.

Reconfirming the importance of advancing the exchange of information and opinions as well as research on the rights of the child, including sharing data on pictures of children’s situations as well as information on legislation, policies, initiatives and practices concerning children,

Inviting other countries in Asia to join the Asia Forum on the Rights of the Child to work towards the creation of child-friendly Asian countries,

Determined to pursue the effective realization of the CRC in each state and in the whole region of Asia by promoting collaboration among researchers and experts as well as governments, international organizations, academics, NGOs/civil society and other actors with the principles of the CRC as the common ideal,

Encouraging all stakeholders to facilitate and assist children in expressing their views on all matters affecting them, including by organizing themselves for this purpose, and to create structures and mechanisms for children to participate in the formulation and implementation of laws, policies, programs and other measures concerning them,

Have agreed to promote the following initiatives for the development of “child-friendly societies in Asia”, which is the key theme of the Third Forum in Ulaanbaatar,

1. To urge all State Parties in Asia, which have acceded to the CRC, should take initiatives to adapt and pass laws fulfilling children's rights and giving them legal status.
2. To implement policies based on the purposes and provisions of the CRC and its Optional Protocols, especially during disasters and armed conflict, which frequently occur, including during recovery and reconstruction efforts; in particular, to listen carefully to children and create mechanisms which make children partners in recovery and reconstruction processes.
3. To accelerate the development and implementation of policies, legislation, awareness-raising activities and other measures for the prevention and prohibition of all forms of violence against children, including child abuse, corporal punishment and bullying; through these initiatives, to develop comprehensive plans and codes of conduct for the prevention and prohibition of all forms of violence against children.
4. To prohibit the worst forms of child labour and to provide children engaged in the worst forms of child labour and their families with viable alternatives, while taking all measures to ensure the right to education and secure children's growth and development. The viable alternatives must be decided after consultation with children and their families who will benefit from the policies. Children and families should take part in monitoring and evaluating the programmes designed for them.
5. In order to ensure that children's lives are protected and that they can grow up and develop in a safe and secure environment, to conduct review from children's rights perspectives of the relevant policies formulated by adults from adults perspectives, with a view to restructuring such policies.
6. To provide comprehensive and continuous support for children as well as their parents and families; and to promote a diversity of support policies, including the improvement of conditions of day-care workers, teachers and other supporters who work with children, with a view of protecting their rights so that they can provide appropriate support for children.
7. To develop mechanisms and systems for advancing the protection, promotion and monitoring of children's rights in a multifaceted way at local, national and regional levels and to promote networking for the effective functioning of these mechanisms and systems; in particular, to develop specific mechanisms, urgently and effectively which children can easily access in order to be given effective remedies.
8. To promote the ratification of or accession to the three Optional Protocols to the CRC, with a view to ensure the effective implementation of the CRC.
9. To work towards the creation of "child-friendly Asian societies" on the basis of the national initiatives for "child-friendly cities/communities", via the collaboration of governments, UNICEF and other international organizations, academics, NGOs/civil society and other stakeholders; as well as taking into account the opinions of children in the region.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН



UHR.MN
СУДАЛГААНЫ САН

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс
Тусгаар тогтнолын талбай, Засгийн газрын XI байр, Ү давхар
Утас: 266506, 262902, Факс: 976-11-320284
Цахим хаяг: www.mn-nhrc.org, Цахим шуудан: info@mn-nhrc.org
Иргэдээс гомдол хүлээн авах, хууль зүйн зөвлөгөө өгөх утас: 7000222